

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	9
3. УХАА ХУДАГ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ГОЛ ҮР ДҮН.....	11
4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	13
5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	40
6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	43
7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	46
8. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	48
9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	49
10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	54
11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	62
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	72
14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗАРДАЛ	104
15. ДҮНГЭЛТ	ERROR! BOOKMARK NOT DEFINED.

1.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, бизнест тодорхой хувь нэмэр оруулах, нэн ялангуяа нүүрс, нүүрсэн химийн бүтээгдэхүүний олборлолт, үйлдвэрлэл, борлуулалтыг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр дэлхийн зах зээлд баттай байр суурь эзлэх эрхэм зорилготойгоор “Энержи Ресурс” ХХК нь 2005 оны 4-р сарын 22-нд байгуулагдсан үндэсний хөрөнгө оруулалттай компани юм. Тус компани нь “Ухаа худаг” төслийн хүрээнд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах Ухаа худаг коксжих нүүрсний ордыг 2009 оноос олборлож эхэлсэн нь коксжсон нүүрсний зорилтот зах зээлд хүргэхэд томоохон алхам болсон. “Энержи Ресурс” ХХК нь өндөр хөгжилтэй орнуудад мөрддөг олон улсын стандартыг эх орондоо нэвтрүүлж, бодит ажил хэрэг болгон хариуцлагатай уул уурхайн жишиг тогтоохыг зорьж, Монгол улсад өрнөж буй их бүтээн байгуулалтад өөрийн хувь нэмрээ оруулан ажиллаж байна. Тус компани нь Ухаа худаг төслийн хүрээнд явагдаж байгаа бүхий л үйл ажиллагааны явцад байгаль орчныг хамгаалах багц хууль, стандартууд, Олон улсын стандартыг даган мөрдөж, төслийн үйл ажиллагааны явцад гарч байгаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, байгаль орчныг хамгаалах зорилготойгоор ажилладаг. “Энержи Ресурс” компани нь 2007 онд Ухаа Худагийн ордын ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмших болсноор ордыг ашиглах ТЭЗҮ, Баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ зэргийг боловсруулан батлуулж, 2008 оны 10 сараас ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээнийн дагуу уулын бэлтгэл ажлыг эхлүүлсэн ба 2009 оны 4 сард улсын комисс Ухаа Худагийн уурхайг байнгын ашиглалтанд хүлээж авснаар хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлыг эхлүүлсэн.

2023 оны 9-р сарын 30-ны гүйцэтгэлээр 9,615,463 сая тн нүүрс олборлосон байна

11952А тусгай зөвшөөрлийн булангийн цэгүүдийн солбицолууд

Дугаар	Х	У
11952А - 4	4835630.651	536106.290
11952А - 1	4839519.390	536085.354
11952А - 2	4839364.841	543699.684
11952А - 3	4835676.639	543725.328

“Энержи Ресурс” компани нь Монгол улсын хөгжил дэвшил, үйлвэржилт, шинэчлэлд тодорхой хувь нэмэр оруулах, “Ухаа Худаг” нүүрсний ордыг цогц байдлаар ашиглах зорилтын хүрээнд уурхайн нүүрс олборлолтын үйл ажиллагаатай зэрэгцүүлэн жилд 15 сая нүүрс хүлээн авч баяжуулах үйлдвэр, 18 МВт конденсатын цахилгаан станц, хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэр, уурхайн ажиллагсдын “Галлерей кемп”, гүний ус олборлох худаг, ус цэнгэгжүүлэх байгууламж, Ухаа худаг-Гашуун сухайтын чиглэлийн 245 км хатуу хучилттай зам, 5000 хүн ам оршин суух “Цэций” хороолол орон сууц, хоногт 1200м³ ус цэвэршүүлэх цэвэрлэх байгууламж болон бусад ахуйн барилгыг барьж ашиглалтанд оруулсан.

1.1 Ухаа худаг нүүрсний уурхай

“Энержи Ресурс” ХХК нь уурхайн олборлолтын чиглэлээр ашигт малтмалын эрэл хайгуул, нөөцийн үнэлгээ, уурхайн урт, дунд болон богино хугацааны төлөвлөлт, ISO, GB, MNS стандарт шаардлагуудыг хангасан нүүрсний чанарын бүрэн хэмжээний судалгаа, уул уурхайн хүнд машин механизмын засвар үйлчилгээ, ашигт малтмалын олборлолт зэрэг 10 гаруй чиглэлд үйл ажиллагаа явуулж байна. Ордын нүүрсний тогтоцоос хамааран нүүрсний хаягдал бохирдлын хэмжээг багасгах зорилгоор нүүрс олборлолтын доголуд дээр Hitachi1200 болон Liebherr 9250 урвуу хутгуурт гидравлик экскаваторуудболон уурхайн дотоод тээвэрлэлтэнд Caterpillar фирмийн автосамосвалуудыг ашигладаг. Уурхай 12 цагийн 2 ээлжээр, 24 цагийн турш ажилладаг бөгөөд үйл ажиллагаа хэвийн үед 700 орчим хүн ажилладаг.




Зураг 10.1. Нүүрсний уурхай

1.2 Нүүрс баяжуулах үйлдвэр

Ухаа Худаг төслийн хүрээнд жилд тус бүр 5 сая тонн нүүрс угааж, боловсруулах хүчин чадалтай 3 модуль бүхий Нүүрс баяжуулах үйлдвэр (НБҮ) Австралийн Седжмен компанийн зураг төслөөр баригдсанаас эхний модулийг 2011 оны 6-р сард, 2-р модулийг 2012 оны эхний хагаст ашиглалтанд оруулж жилдээ 10 сая тонн нүүрс хүлээн авч баяжуулсан ба 3-р модулийг 2013 оны 7 сард оруулснаар жилийн хүчин чадал 15 сая тонн болж өргөжсөн. 2023 оны 9-р сарын 30-ны байдлаар 5,042,144 коксжсон нүүрс боловсруулсан байна.



Зураг 1.2. Нүүрс баяжуулах үйлдвэр




Зураг 1.3. Нүүрс баяжуулах үйлдвэрийн технологийн схем

1.2.1. НБУ-ийн хаягдлыг усгуйжүүлэх үйлдвэр

Нүүрс баяжуулах үйлдвэрийн хаягдлыг усгуйжүүлэх ажиллагаанд шинэ техник технологийг ашиглан байгаль орчинд ээлтэй нөхцлөөр шийдвэрлэхээр Нүүрс баяжуулах үйлдвэрийн Хаягдлыг усгуйжүүлэх байгууламжийг барьж байгуулан 2013 оны 12-р сард ашиглалтанд оруулсан.

Уг байгууламж нь баяжуулах үйлдвэрийн хаягдлыг усгуйжүүлж, гарсан усны 67%-85%-ийг эргүүлэн ашиглахад зориулагдсан үйлдвэр юм. Үйлдвэрт 8 ширхэг усгуйжүүлэх төхөөрөмжийг суурилуулсан ба нэг төхөөрөмж нь цагт 75.3 м³ хаягдлыг базаж 65 м³ шүүгдсэн ус, 21 тн хуурай хаягдал болгон ялгана. Шүүгдсэн усыг технологийн шугаманд эргүүлэн ашигладаг.




Зураг 1.4. Хаягдлыг усгуйжүүлэх үйлдвэрийн технологийн схем

1.3. Дулааны цахилгаан станц

“Энержи Ресурс” ХХК-ийн Ухаа худаг коксжих нүүрсний ордыг түшиглэн 18 МВт-ын хүчин чадалтай цахилгаан станц барьж, 2011 оны 9 сарын 24-нд ашиглалтанд оруулсан. Тус станц нь уурхайн болон дэд бүтцийн төслүүдийн эрчим хүчний бүхий л хэрэгцээг хангахаас гадна төвийн эрчим хүчний системээс алслагдсан Өмнөговь аймгийн Цогтцэций сумыг цахилгаанаар найдвартай хангаж байна. Монголдоо анх удаа дотоодын чадварлаг инженерүүдийн ур ухаанаар боссон энэхүү цахилгаан станц говь нутгийн байгалийн онцлогт нэн тохиромжтой хуурай хөргөлтийн систем, шаталтын үр дүнд үүссэн байгаль орчинд хортой үнсийг цахилгаан ионжих аргаар ялгах цахилгаан филтер, усны бага хэрэглээ гээд технологийн олон давуу талыг агуулсан тул одоогоор Монголд ажиллаж буй бусад цахилгаан станцуудтай харьцуулахад усыг 4-5 дахин хэмнэх боломжтой. Дулаан цахилгаан станц нь 2023 оны 9 сарын 30-ны байдлаар 88,068,42 кВт. цахилгаан эрчим хүч үйлдвэрлэсэн байна.



Зураг 1.5. Цахилгаан станц



Зураг 1.6. Дулааны цахилгаан станцын технологийн схем

1.4. Ус хангамж


Ухаа Худаг уурхайн цогцолборын үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэглээний ус хангамжийн ухаалаг, дэвшилтэт системийг бий болгох ажил 2008 оны 1-р сараас эхэлж улмаар 2011 оны 6-р сард ашиглалтанд орсон. Ингэхдээ цэвэр усны нөөцөөр хомс говь нутгийн онцлогийг дээд зэргээр харгалзсан, усыг 100 хүртэлх хувь дахин ашиглах, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, дэвшилтэт технологид суурилсан болно.

Уурхайн нийт төслүүдийн усны хэрэгцээг хангаад зогсохгүй Өмнөговь аймгийн Цогтцэций сумыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, ундны цэвэршүүлсэн усаар хангаж буй ус хангамжийн систем нь 56,000 куб метрийн багтаамжтай усан сан, насос станц болон иж бүрэн автомат хяналтын систем гээд технологийн онцлог шийдэл бүхий хэсгүүдээс бүрдэл болдог.

2023 оны 10 сарын 30-ны байдлаар 1,791,910 м³ ус үйлдвэрлэлд ашигласан байна.

1.4.1. Ус хангамжийн систем

Одоогийн байдлаар Наймантын хотгорын болон Наймдайн хөндийн гэсэн хоёр үндсэн ус хангамжийн системийг байгуулснаас Наймантын хотгорын ус хангамжийн системийг ашиглаж байна.



Зураг 1.7. Ус хангамжийн ерөнхий схем зураг

1.4.2. Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууламжууд

Тус компани нь нийгмийн хариуцлагатай уул уурхайн төслийн хүрээнд өөрийн ажиллагсад төдийгүй Цогтцэций сумын иргэдийг стандартын шаардлагад нийцсэн ундны цэвэр усаар хангадаг бөгөөд хэрэглээнээс гарсан ахуйн бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх үйл ажиллагааг шийдвэрлэсэн болно. Энэ зорилгоор дараах байгууламжуудыг барьж байгуулан, ашиглаж байна. Үүнд:

Ундны ус цэнгэгжүүлэх байгууламж

- Хүчин чадал: 750 м³/хоног
- Ус цэнгэгжүүлэх байгууламж нь Цогтцэций сумын хүн ам болон уурхайн ажилчдын хотхоныг цэвэршүүлсэн усаар хангах зорилгоор байгуулагдсан.
- Ус цэвэршүүлэх төхөөрөмжийг Герман улсын Prominent компанид үйлдвэрлэсэн бөгөөд мембран шүүлтүүр бүхий урвуу осмосын зарчмаар ажилладаг.
- Байгалийн усыг чөлөөт ионуудаас 97-98%-иар, бусад хольцноос 99% хүртэл цэвэрлэх боломжтой.

Цогтцэций сум, Цэций хорооллын хэрэглээнээс гарсан ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж

- Хүчин чадал: 1200 м³/хоног

- Бүрэн автомат цэвэрлэх байгууламж ба 96 % хүртэл цэвэрлэх боломжтой.
- 35х20 м-ийн талбайтай аваарийн сан- 1ш, 35х20 м-ийн талбайтай лагийн сан 1ш, 1400 м³-ийн 4 ш шүүрүүлэх талбайтай.
- Чехийн SPR технологитой

1.5. Уурхайн ажиллагсдын хотхон

2013 оны 1 сард Цогтцэций суманд олон улсын жишигт нийцсэн, боловсролын орчин үеийн Мөрөөдөл нэртэй томоохон цогцолбор болох 640 хүүхдийн дунд сургууль, 144 хүүхдийн цэцэрлэг, 100 хүүхдийн дотуур байр бүхий иж бүрэн байгууламж Өмнөговь аймгийн болон тус компанийн хөрөнгө оруулалтаар байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Компанийн ажиллагсдын нийгмийн асуудлыг цогцоор шийдэх бодлогын хүрээнд орон сууцны хороолол болон хашаатай бүрэн тохижуулсан ажилчдын гэр хорооллыг барьж байгуулсан. 2011 онд 377 айлын хашаа 2022 онд уурхайчин хорооллын өргөтгөл 165 айлын хашаа 2014 онд “Цэций” хороололд 480 айлын орон сууц ашиглалтанд орж, нийт 1022 айл өрх тус хороололд амьдарч байна.

1.6. Ухаа худаг Гашуун сухайт чиглэлийн авто зам

“Энержи Ресурс” компани Ухаа Худаг – Гашуун сухайт чиглэлийн 245 км хатуу хучилттай замыг барьж байгуулах ажлыг амжилттай хэрэгжүүлж, 2011 оны 10-р сард ашиглалтанд оруулсан. Хатуу хучилттай авто зам ашиглаж байгаа нь уурхайн тээвэрлэлтийн хүчин чадал, бүтээмжийг нэмэгдүүлснээс гадна хайрган хучилттай зам ашигласнаас үүдэлтэй тоосжилтыг эрс бууруулж, говь нутгийн байгалийн тэнцвэрт байдлыг хадгалахад бодитой хувь нэмэр оруулж байна. Замыг Засгийн газрын 2013 оны 299-р тогтоолоор 2014 оны 02 сарын 14-өөс хойш төрийн өмчид шилжүүлсэн бөгөөд одоогоор энэхүү замын хувьцааны 40%-ийг төрийн өмчит “Эрдэнэс таван толгой” ХХК, 40%-ийг “Энержи Ресурс” ХХК, 20%-ийг Орон нутгийн өмчит “Таван толгой” ХХК тус тус эзэмшиж байгаа. Авто зам төрийн өмчид шилжсэнтэй холбоотойгоор замын менежмент, засвар үйлчилгээ, аюулгүй байдлын хяналт зэрэг асуудлыг “Гашуунсухайт автозам” ХХК хариуцан замын үйл ажиллагааны тогвортой байдлыг ханган ажиллаж байна.



Зураг 1.8. Хатуу хучилттай нүүрс тээврийн зам

1.7. Цагаан Хад Нүүрс ачиж буулгах талбай

Нүүрс буулгах агуулах болон Гаалийн хяналтын талбай нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Номгон багийн нутагт, Цагаан хад нэртэй газарт орших бөгөөд сумын төвөөс урагш 75км, Гашуун сухайтын хилийн боомтоос 20 гаруй км зайд байрлана. Цагаан хадны нүүрс ачиж буулгах талбайд БНХАУ-сад экспортлох нүүрсийг талбайгаас дахин ачиж хилийн шалган нэвтрүүлэх болон гаалийн хяналт-бүрдүүлэлт хийдэг. Энэ талбай нь нийт 10 га талбайг эзэлдэг. Нүүрс ачиж буулгах талбайн ажиллагсад, засварын газрын ажилчдын хотхонд 35 гэр, 3 контейнэр хаус бүхий кэмп, цахилгаан дулааны эх үүсвэрийн барилга, хоолны газар, ундны ус цэвэрлэх байгууламж, угаалга болон нийтийн халуун усны газар, авто гараж, шалган нэвтрүүлэх байр, спортын талбай зэргээс бүрддэг. Нүүрс ачиж буулгах талбайд нийт 4 дугуйт ачигч, усны 1 машин, 60 орчим хүн ажилласан.



Зураг 1.9. Цагаан хадны нүүрс ачиж буулгах талбай

1.8 Шатахуун түгээх станц

Шатахуун түгээх станцыг Ухаа худаг уурхайд ажиллаж буй техник хэрэгслийг түлшээр найдвартай хангах зорилгоор 2019 онд үйл ажиллагаандаа шилжүүлэн авсан. Шатахуун түгээх станц нь шатахуун далд нөөцлөх 50м³-н багтаамжтай 3, ил 24ш нөөцлөх сав болон тээврийн машин орж гарах, зам шатахуун буулгах хэрэгсэл, технологийн худгууд, хаягдлын сан, шатахуун буулгах талбай, шатахуун түгээгүүрүүд, шатахуун түгээх станцын ажилчдын амрах байр зэргээс бүрддэг.

2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Ухаа Худаг ордоос нүүрс олборлох, боловсруулах, тээвэрлэх төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг 2019 онд шинэчлэн боловсруулсан төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тодорхойлсон байдаг. Төсөл хэрэгжиж байгаа бүс нутагт “Энержи Ресурс” ХХК-аас гадна “Эрдэнэс Таван толгой” ХК, “Таван толгой” ХК зэрэг бусад аж ахуйн нэгжүүд нүүрсний уурхайн ба тэдгээрт туслах дэд бүтцийн төсөл хэрэгжүүлдэг учраас тухайн газрын хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөл нь хам шинж чанартай юм.

Ухаа Худаг ордоос нүүрс олборлох, боловсруулах, тээвэрлэх төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг түүнд өртөх орчноор нь буюу агаар, гадаргын болон газар доорх ус, хөрс, амьтан ургамлын аймгийг хамруулан дараах байдлаар тодорхойлсон.

Агаарын чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Гол сөрөг нөлөөллүүд:

- Ил уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлох, ачиж буулгах үйл ажиллагаа болон хөдөлгөөнт эх үүсвэрээс агаарт РМ10-аас жижиг хэмжээтэй нарийн ширхэгт тоосонцорын хэмжээ ихсэх.
- Элэгдэл эвдрэлд өртсөн газраас салхины болон хөдөлгөөнт техникийн нөлөөгөөр тоосжилт үүсэх.
- Тэсэлгээ, уурхайд ажиллаж байгаа техник, тоног төхөөрөмжөөс үүсэх дуу шуугиан.
- Цахилгаан станц ба бага оврын халаалтын зуух, хүнд даацын болон бусад техникээс бохирдуулагч хий агаарт ялгарах.

Болзошгүй сөрөг нөлөөллүүд:

- Нүүрс ачиж буулгах талбай дахь нүүрсний овоолгуудыг удаан хугацаагаар хадгалснаас нүүрс өөрөө халж шатан хүлэмжийн хий ялгаруулж агаарын чанарт нөлөөлөх.
- Төслийн хэмжээнд ашиглаж байгаа хатуу хучилттай зам эвдрэх, зам засах зэргээс шалтгаалан шороон зам гарган ашигласнаас агаарт тоосжилт үүсэх.
- Баяжуулах үйлдвэрт ашиглагдах химийн хортой болон аюултай бодисуудын агуулах сав, шатахуун түгээх станцын агуулахаас нэвчилт үүсэх эсвэл байгалийн гамшгийн улмаас бодис материал алдагдсанаас агаарт химийн бодис ууршин тухайн орчны агаарыг бохирдуулах.

Усны чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Гол сөрөг нөлөөлөл:

- Төслийн үйл ажиллагаанд зориулан Наймантын хөндийн гүний ус олборлолтоос шалтгаалан гүний усны түвшин буурах.
- Уурхайн олборлолтын явцад шүүрүүлэлтийн усыг шавхсанаас гүний усны түвшин буурах.

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Уурхайн хотхон болон ажилчдын кэмпиин бохир ус цэвэрлэх байгууламжийн эвдрэл гэмтэл, технологийн горим алдагдсанаас үүдэн гадаргын болон газрын доорх усны чанар найрлагад нөлөөлөх.
- Баяжуулах үйлдвэрт ашиглагдах химийн хортой болон аюултай бодисуудын агуулах сав, шатахуун түгээх станцуудын агуулахаас нэвчилт үүсэх, байгалийн гамшгийн улмаас бодис материал алдагдсанаас хөрсөнд нэвчин уст үеийг бохирдуулах.
- Хаягдал чулуулгийн овоолго дахь хүчил шүлтийн тэнцвэр алдагдаж хүчиллэг урсацын нөлөөгөөр гадаргын болон газрын доорх ус бохирдох.
- Баяжуулах үйлдвэрийн эргэлтийн усан сангаас гүний усанд нэвчилт үүсч усны чанарт нөлөөлөх.
- Наймантын хөндийн гүний ус олборлолтоос шалтгаалан малчдын гар худгуудын усны түвшин буурах.

Хөрсний чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Гол сөрөг нөлөөлөл:

- Олборлолт явуулах талбайн шимт хөрсийг хуулж овоолго үүсгэснээр тухайн газрын хэлбэр төрхөд өөрчлөлт орох.
- Шинээр барилга байгууламж барих, зам гаргах зэргээс хөрсөн бүрхэвч эвдрэл элэгдэлд орох.

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Салаа зам үүсгэснээс шалгаалан хөрс эдэгдэл эвдрэлд орох.
- Химийн бодис, тос тосолгооны материал, бохир ус асгарсанаас шалтгаалан хөрс бохирдох.
- Хуурай хог хаягдлыг зөвшөөрөлгүй газар хаяснаар хөрс бохирдох.
- Борооны усны угаагдал, үерийн усны улмаас бохирдол зөөгдөн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах.
- Наймантын хөндийн гүний ус олборлосноос шалтгаалан хөрсний чийгийн хэмжээ багасч хөрсний үржил шимт чанар муудах.

Ургамлан бүрхэвчид үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Гол сөрөг нөлөөлөл:

- Олборлолт явуулах талбайн шимт хөрсийг хуулж овоолго үүсгэснээр тухайн газрын ургамлан бүрхэвч устгах.
- Шинээр барилга байгууламж барих, зам гаргах зэргээс хөрсөн бүрхэвч эвдрэл элэгдэлд орж тухайн хэсгийн ургамлан бүрхэвч доройтох.

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Салаа зам үүсгэснээс шалгаалан хөрс элэгдэл эвдрэлд орж ургамлан бүрхэвчид нөлөөлөх.
- Химийн бодис, тос тосолгооны материал, бохир ус асгарснаас шалтгаалан ургамлын ургалтанд нөлөөлөх.
- Төслийн үйл ажиллагааны улмаас үүсэх тоосжилт ургамлын гадаргууд бууснаар фотосинтезийн процессийг багасгаж ургамлын ургалтанд нөлөөлөх
- Наймантын хөндийн гүний ус олборлолтын улмаас хөрсний чийг багасч ургамлан бүрхэвч сийрэгжих.

Биологийн төрөл зүйлд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Гол сөрөг нөлөөлөл:

- Уул уурхай түүнийг дагасан үйлдвэр, суурьшлаас тухайн бүс нутгийн амьтан дайжих, дүрвэх.
- Уурхайн хөрс хуулалт, хашаажуулалт зэргээс амьтны амьдрах орчин, идэш тэжээл хязгаарлагдах.

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Нүүрс тээврийн зам хөндлөн гарах амьтад машинд дайруулах.
- Өндөр хүчдэл болон цахилгааны шугамын шувуу үргээгч эвдэрсэнээс шувуу цахилгаанд цохиулах.

3. УХАА ХУДАГ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ГОЛ ҮР ДҮН

Өмнөговь аймгийн Цогтцэций суманд орших Ухаа худагийн ордоос нүүрс олборлох, боловсруулах, тээвэрлэх төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулахдаа БОНХЯ-ны сайдын 2019 оны 10 сарын 19-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримталсан болно.

Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд түүний биелэлтийн тоон үзүүлэлэлтийг дараах хүснэгтэнд нэгтгэн илэрхийлэв.

Хүснэгт 3.1 Байгаль орчны менежмент төлөвлөгөөд тусгагдсан ажлуудын хэрэгжилт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төрөл	Төлөвлөсөн ажлын тоо	Гүйцэтгэсэн ажлын тоо	Хийгдэж буй болон хойшлогдсон ажлын тоо
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	32	31	1
2	Нөхөн сэргээлт	4	4	0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	2	2	0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох	1	1	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах	0	0	-
6	Осол эрсдэлийн менежмент	6	6	-
7	Хог хаягдлын менежмент	9	9	0
8	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	10	8	2
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	17	17	-
10	Олон нийтэд тайлагнах үйл ажиллагаа	6	6	0
Нийт		87	84	3

2023 оны Ухаа худаг төслийн Байгаль орчны менежмент төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлсэн гол үйл ажиллагаанууд, түүний үр дүнг дурдвал:

- Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт тусгагдсан Монгол орны хэмжээнд уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч эзэнгүй орхигдсон талбайг нөхөн сэргээх зорилтын хүрээнд манай компани гар аргаар алт олборлосон Өмнөговь аймгийн Баяндалай сумын Баян цагааны нуруу нийт 5 га эвдрэлтэй талбайд техникийн нөхөн сэргээлтийг холбогдох стандартын дагуу амжилттай хийж гүйцэтгэлээ.
- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хүрээнд Энержи Ресурс ХХК-ийн мод тарьж ургуулах урт хугацааны төлөвлөлтийн дагуу Баяндалай сумын Цагааны голд байгалийн урсац бүхий булгийг түшиглэн Өмнөговь аймгийн БОАЖГ-аас санал болгосон 10 га талбайд загаар ойжуулалт хийх ажлыг ойн мэргэжлийн байгууллагатай хамтран хийж гүйцэтгэсэн. Мөн ажилчдын хотхон болон ажилчдын орон сууц орчмын нийтийн эзэмшлийн талбайд 29 мянган мод, Богд уулын Хүрхрээгийн аманд 2500 мод, Хэнтий аймгийн Мөрөн сумын тариалангийн талбайн хамгаалалтын зурваст 9 мянган ширхэг мод тус тарьснаар энэ онд нийт 50.5 мянган модыг тарьсан байна.
- Уурхайн хаягдлын овоолгын 20 га талбайг хэлбэршүүлэн налууулж, 10га шимт хөрсөөр хучих ажлыг гүйцэтгэв.

- Цагаанхад НАБТ-н ажилчдын хотхонд хоногт 100 мкуб ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийг барьж ашиглалтад оруулсан бөгөөд тус цэвэрлэх байгууламжаас гарах саарал усыг мод усалгаанд ашиглахаар төлөвлөж байна.
- Цөлжилттэй тэмцэх дэлхийн өдрийг тохиолдуулан Өмнөговь аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Оюу толгой ХХК хамтран 2023 оны 6 сард зохион байгуулсан Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг сааруулах сэдэвт бага хуралд оролцож “Гөвийн бүсэд байгуулсан ногоон байгууламж нөхөн сэргээлтийн туршлага” сэдвээр илтгэл танилцуулсан.
- Уурхайн үйл ажиллагаанаас гарч буй дахивар хог хаягдлыг нэг цэгт төвлөрүүлж эхэлсэн бөгөөд нутгийн игэд болон дахивар бүтээгдэхүүн авдаг ААН-үүдэд өгөх зохицуулалтыг хийж эхэлсэн.

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

4.1. Уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Тоо хэмжээ
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					
1	Уурхайн технологийн замаас үүсэх тоосжилтоос сэргийлэх зорилгоор усалгаа хийх	Ил уурхай	Уурхайн технологийн замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор CAT773D маркийн усны машин нийт 285,795 м ³ усаар усалгаа хийсэн байна.	Үйлдвэр лэлийн зардалд багтсан	10000 м3/сар
2	Уурхайн технологийн зам шинээр тавих болон түүний засвар үйлчилгээнд тоосжилт бага үүсгэдэг материалыг сонгож ашиглах	Ил уурхай	Тайлант хугацаанд уурхайн технологийн тээврийн замын засвар үйлчилгээнд өмнөх жилүүдэд тоосжилт бага үүсгэдэг нь батлагдсан замын 26,197 м ³ материалыг ашиглан технологийн тээврийн замыг зассан.	Үйлдвэр лэлийн зардалд багтсан	30000 м3
3	Агаарын чанарын хэмжилт, тоосны мониторингийн дүнг үндэслэн хүлцэх хэмжээнээс дээш гарсан үзүүлэлтийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлж үр дүнд хүрсэн байна.	Ил уурхай	Уурхайн тоосжилтыг бууруулахад мананцаржуулагч ашиглах ажил хийгдээгүй.	Үйлдвэр лэлийн зардалд багтсан	Мананцаржуулагч ашигласан байх
Усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					
4	Цэвэрлэх байгууламжид нийлүүлэгдэх зөөврийн бохир усны хяналтыг сайжруулах	Цэвэрлэх байгууламж	Ахуйн хаягдал ус цэвэрлэх байгууламжийг горимын дагуу ажиллаж 2023 оны 09 сарын байдлаар 30-ны байдлаар 147,542 м ³ бохир усыг цэвэршүүлсэн. Хаягдал усыг стандарт шаардлагад нийцүүлэхийн сайжруулалт, засвар үйлчилгээг хийж байна.	Үйл ажиллагааны зардлаас	90м3/хоног

5	Цэвэрлэх байгууламжаар усыг цэнгэгжүүлж унд ахуйн хэрэгцээнийн усаар хангах	Унды ус цэнгэгжүүлэх байгууламж	Ундны ус цэнгэгжүүлэх байгууламж нь Галлерей кемп, Цэций хороолол, Уурхайчин хороолол болон Сумын цэвэр усны хэрэглээг ханган ажиллаж байна. 2023 оны 9-р сарын 30-ны байдлаар 102,126 м ³ ус цэнгэгжүүлэн ахуйн цэвэр усны хэрэглээнд нийлүүлсэн.	Үйлдвэрлэлийн зардалд багтсан	200 м3/хоног
6	Ус ашиглах дүгнэлт, зөвшөөрлийг холбогдох байгууллагаар гаргуулж гэрээ байгуулах,	Ухаа худаг ус хангамж	Усны тухай хуулийн холбогдох заалтын дагуу холбогдох баримт бичгийг бүрдүүлэн хүргүүлж “Усны газар”-аас 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 06/112 тоот Ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулж авсан.	Үйл ажиллагааны зардлаас	12 сар тутам
7	Хаягдал усны гэрээ байгуулж биелэлтийг ханган, төлбөрийг цаг тухайд нь барагдуулах.	Ухаа худаг ус хангамж	Манай компани “Ус бохирдуулсны төлбөрийн тухай” хуулийн дагуу Ухаахудаг ус хангамж ХХК дээр 218.432 мян.м3, Энержи Ресурс ХХК дээр 555.828 мян.м3 бохир усыг хүрээлэн буй орчинд болон төвлөрсөн бохир усны шугаманд “Хүрээлэн байгаа орчин, Усны чанар, хаягдал, ерөнхий шаардлага MNS4943:2015”, “Хүрээлэн байгаа орчин чанар, Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус, ерөнхий шаардлага MNS6561:2015” стандартаар тогтоосон норматив шаардлагад нийцүүлэн хаях зайлуулах зөвшөөрлийг нэг жилийн хугацаатайгаар авч гэрээг байгуулав.	Үйл ажиллагааны зардлаас	12 сар тутам
Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					
8	Үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулж, хадгалах ба уг үйл ажиллагаанд хяналт тавих.	Ил уурхай	Тайлант хугацаанд хаягдал чулуулгийн талбайн тэлэлттэй холбогдуулан 32000 м3 шимт хөрсийг хуулж, стандартын дагуу овоолго үүсгэсэн байна.	Үйлдвэрлэлийн зардлаас	5000м3

9	Уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан хэмжээнд олборлолт хийх	Уурхайн засварын газар	Уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан хэмжээнд олборлолт хийх Ухаа худаг уурхайн 2023 оны уулын ажлын төлөвлөлтөөр нийт 14.37 сая тонн нүүрс батлуулсан төлөвсөн. 2023 оны 9-р сарын 30-ны байдлаар 9,615,463 тонн нүүрс олборлосон байна.	Үйлдвэрлэлийн зардлаас	Сар бүр
10	MV-011952 тусгай зөвшөөрлийн талбайд болон талбайгаас тусгай зөвшөөрөлгүйгээр түгээмэл тархацтай ашигт малтмал, ус, ургамал ашиглахгүй байх	Ил уурхай	Ухаа худаг төслийн хүрээнд тайлант онд түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглаагүй. Ухаа худаг лицензийн талбайд Цэций хороолол өргөтгөл болон Ухаа худаг терминалын талбайн урсгал засварын бүтээн байгуулалтын ажилд ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох түр зөвшөөрлийг Өмнөговь аймгийн засаг даргын 2023 оны 7-р сарын 07-ны А/1263 тоот захирамжаар авсан.	Үйл ажиллагааны зардлаас	Сар бүр
11	Нөхөн сэргээлт, орчны тохижилтонд зориулж мод, сөөг үржүүлж бойжуулах	Байгаль орчны туршилтын талбай	2023 оны хавар талбайн хөрс боловсруулалтын ажлыг эхэлж 10 төрөл зүйлийн 10000ш суулгацыг үр болон мөчирөөр тарьж ургуулсан байна. Үүнд: Тоорой-1000 ш, Жигд-2500 ш, Сухай-2500 ш, Шар хуайс-200 ш, Заг-100 ш, Улиас-500 ш, Хайлаас-3000, Агч-100, Бүйлс-100, Гүйлс-100ш тус тус үржүүлэн арчилгаа хамгаалалтыг хийж байна	30,000.0	10000ш
Ургамал, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					
12	Уулын туруутан амьтдад зориулсан биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэх	Хангинах уул	2023 оны 1 болон 2 дугаар саруудад Энержи ресурс ХХК сумын баруун талд байрлах Хангинах, Тугийн цохио зэрэг 2 байршилд нийт 40 боодол өвс байршуулсан. Бид зэрлэг амьтадын ажиглалт хийх зорилгоор Хангинах ууланд автомат камер байрлуулсан.	1,000.0	40 боодол өвс
НИЙТ ЗАРДАЛ, мян.төг					31,000.0*

Үйлдвэрлэлийн зардлаар хийгдсэн ажлын өртөг багтаагүй дүн

4.1.1. Уурхайн замын усалгаа

Нүүрс олборлох явцад дотоод тээвэрлэлтээс үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор дараах ажлууд хийгдэж байна. Үүнд:

- Уурхайн технологийн замын материалыг улаан шавран материалаар хийх
- Технологийн замыг тогтмол услах
- Тээвэрлэлт хийх хурдыг багасгах
- 2023 онд Уурхайн технологийн замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор CAT773D маркийн усны машин нийт 285,795 м³ усаар усалгаа хийсэн байна.



Зураг 4.1.1.1 Уурхайн технологийн замын усалгаа хийж буй байдал

4.1.2. Уурхайн замын материал

Уурхайн үйл ажиллагаанаас үүсдэг тоосжилтын нэг томоохон эх үүсвэр нь уурхай доторх тээвэрлэлтийн зам бөгөөд үүнд замын материал гол нөлөө үзүүлдэг. Тайлант хугацаанд уурхайн технологийн тээврийн замын засвар үйлчилгээнд өмнөх жилүүдэд тоосжилт бага үүсгэдэг нь батлагдсан замын 26,197 м³ материалыг ашиглан технологийн тээврийн замыг зассан. Мөн олборлолтын явцад гарсан замын материалыг замын засвар үйлчилгээнд тогтмол ашиглах зорилгоор нөөц бүрдүүлэн хадгалж байна.



Зураг 4.1.2.1 Уурхайн замын материал ба дэвссэн байдал

4.1.3. Тоосжилтыг бууруулах зорилгоор мананцаржуулагч ашигалх

Тоосжилтыг бууруулах ажилд мананцаржуулагч ашиглах ажил хийгдээгүй.

4.1.4 Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа

Ахуйн хаягдал ус цэвэрлэх байгууламжийг горимын дагуу ажиллаж 2023 оны 09 сарын байдлаар 30-ны байдлаар 147,542 м³ бохир усыг цэвэршүүлсэн. Хаягдал усыг стандарт шаардлагад нийцүүлэх



Зураг 4.1.5.1 Ундны ус цэнгэгжүүлэх байгууламж

4.1.6 Ус ашиглах дүгнэлт, зөвшөөрлийг холбогдох байгууллагаар гаргуулж гэрээ байгуулах,

Усны тухай хуулийн холбогдох заалтын дагуу холбогдох баримт бичгийг бүрдүүлэн хүргүүлж “Усны газар”-аас 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 06/112 тоот Ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулж авсан. Мөн Галба Өөш Долоодын Говийн сав газрын захиргааны даргын 2023 оны А/06 тушаалаар ус ашиглах зөвшөөрлийг гаргуулсан бөгөөд сав газрын захиргаатай 2023 оны 03-р сарын 20-ны өдөр 2023/02 тоот ус ашиглах гэрээг байгуулан ажиллаж байна.

МОНГОЛ УСНЫ ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧИ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР
Чөлөөт хэдэн гудамж, 2 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16200
Утасны утас: (976-11) 28 55 78, (976-11) 28 55 36,
Цахилгаан шуудан: office@water.gov.mn,
Цахилгаан хуудас: www.water.gov.mn

2023.02.02 № 01/112
Танай 2023.01.02-ны № 06

“ЭНЕРЖИРЕСУРС” ХХК-Д

Танай байгууллагын 2023 оны 06 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлт, холбогдох бичиг баримтыг судалж үзээд Усны тухай хуулийн 28.4 дэх заалтын дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах “Ухаа худаг” нэртэй газарт орших ашиглалтын МВ-011952 дугаартай тусгай зөвшөөрөлтэй хонхонх нүүрсний ордыг ил аргаар ашиглах болон Ухаа худагийн нүүрс баяжуулах үйлдвэр, Ханбогд сумын Хайрхан багийн нутагт байрлах Цагаан хадны кемп, нүүрс ачиж буулгах талбайд 2023 онд ус ашиглуулах дүгнэлтийг гарган хавсралтаар хүргүүлж байна.

Хувийг Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргаанд

Хавсралт 9 хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *В.БОЛДАБААТАР*

162330223

БАТГААР
ГАЛБА-ӨӨШ-ДОЛООДЫН ГОВИЙН
САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГА

БАТГААР
“ЭНЕРЖИРЕСУРС” ХХК-ИЙН
ДЭД ОРШИОГООЛГОЧ

Б.ЯМАЛТААР
Ц.БААСАНОРЖ

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2023 оны 1 сарын 20 Дугаар 2023/02 Сайншилд

Нэг. Ерөнхий туйл

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 28.7, 29 дугаар зүйлийн 29.1-д заагдсан дагуу Усны газрын 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 06 дугаар ус ашиглуулах дүгнэлт, Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргааны даргын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/06 дугаар тушаалаг тус тус үндэслэл:

Ус ашиглуулагч Агацад “Захирагч” гэх нэр төлөөлөгч Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргааны Усны барьта байгууламж, үйлдвэр, нэвдэж ажил үр ашигтайгаар ашиглах зориулалттай хөрөнгийн 3-Жанцандорж, нэвдэж талбай ус ашиглах Агацад “Ус ашиглагч” гэх нэр төлөөлөгч Баянговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах Ухаа худагийн нүүрс баяжуулах үйлдвэр, Ханбогд сумын нутагт байрлах Цагаан хадны кемп болон нүүрс ачиж буулгах талбай эрх зориулалттай байрлах “Энержи ресурс” ХХК-ийн бүртгэлийн дугаар 1011001001, регистрийн дугаар 2887760-ийн Дэд бүтэйн албаны дарга Ч.Барсайхан нар ус ашиглах талбай төлөрдөд ашиглах гэрээг 2023 оны 01 дугаар сарын 01-ний өдөр 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаагаар байгуулах.

Хөр. Гэрээний гол нөхцөл

- Ус ашиглах зориулалт
 - Уд ахуйн хэрэглээнд ашиглах ус
 - Мэд урлагийн зориулалтад усны хэмжээ
 - Уурхайн саван байгууламж суурийн ус
 - Бусад зориулалтад ашиглах ус
- Ашиглах усны хэмжээ
 - Уд ахуйн хэрэглээнд ашиглах ус – 8,122.5 м³/ажил
 - Мэд урлагийн зориулалтад ашиглах ус – 2,281,873.7 м³/ажил
 - Уурхайн саван байгууламж суурийн ус – 161,812.4 м³/ажил

Зураг 4.1.6.1 Ус ашиглуулах дүгнэлт гэрээ

4.1.7. Хаягдал усны гэрээ байгуулж биелэлтийг ханган, төлбөрийг цаг тухайд нь барагдуулах

Манай компани “Ус бохирдуулсны төлбөрийн тухай” хуулийн дагуу Ухаа худаг ус хангамж ХХК дээр 213.103 мян.м3, Энержи Ресурс ХХК дээр 254.943 мян.м3 бохир усыг хүрээлэн буй орчинд болон төвлөрсөн бохир усны шугаманд “Хүрээлэн байгаа орчин, Усны чанар, хаягдал, ерөнхий шаардлага MNS4943:2015”, “Хүрээлэн байгаа орчин чанар, Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус, ерөнхий шаардлага MNS6561:2015” стандартаар тогтоосон норматив шаардлагад нийцүүлэн хаях зайлуулах зөвшөөрлийг нэг жилийн хугацаатайгаар авч гэрээг байгуулав.



Зураг 4.1.7.1. Хаягдал усны зөвшөөрөл

4.1.8 Үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулж, хадгалах ба уг үйл ажиллагаанд хяналт тавих.

Уурхайн ухмал болон хаягдал чулуулгийн овоолгын тэлэх талбайн тэлэлтийн үйл ажиллагааны нөлөөгөөр эвдрэлд орох газрын шимт хөрсийг “Тазар шорооны ажлын үед үржил шимт хөрс, хуулалт, хадгалалт MNS 5916:2008” стандартын дагуу хуулж хадгалдаг. Шимт хөрсний овоолго тус бүрийг дугаарлаж овоолго хийсэн огноо, хөрсний эзлэхүүн зэрэг мэдээллүүдийг оруулан бүртгэлжүүлж байна. Тайлант хугацаанд хаягдал чулуулгийн талбайн тэлэлттэй холбогдуулан 32,000 м3 хөрсийг хуулж овоолго үүсгэсэн байна.



Зураг 4.1.8.1. Шимт хөрсний хуулалт хийх төлөвлөлтийн зураг

4.1.9 Уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан хэмжээнд олборлолт хийх

Ухаа худаг уурхайн 2023 оны уулын ажлын төлөвлөлтөөр нийт 14.37 сая тонн нүүрс олборлохоор батлуулсан ба 2023 оны 9-р сарын 30-ны байдлаар 9,615,463 тонн нүүрс олборлосон байна.

4.1.10 MV-011952 тусгай зөвшөөрлийн талбайд болон талбайгаас тусгай зөвшөөрөлгүйгээр түгээмэл тархацтай ашигт малтмал, ус, ургамал ашиглахгүй байх

Ухаа худаг төслийн хүрээнд тайлант онд түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглаагүй. Ухаа худаг лицензийн талбайд Цэций хороолол өргөтгөл болон Ухаа худаг терминалын талбайн урсгал засварын бүтээн байгуулалтын ажилд ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох түр зөвшөөрлийг Өмнөговь аймгийн засаг даргын 2023 оны 7-р сарын 07-ны А/1263 тоот захирамжаар авсан. Ерөнхий үнэлгээний дүгнэлт гарсны дараа гэрээ байгуулан ажиллахаар төлөвлөж байна.



Зураг 4.1.10 Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох түр зөвшөөрөл

4.1.11 Нөхөн сэргээлт, орчны тохижилтонд зориулж мод, сөөг үржүүлж бойжуулах

Бид компанийн байгаль орчны нөхөн сэргээлтийн туршилт, мод үржүүлгийн талбайд говийн бүс нутагт дасан зохицсон, амьдрах чадвар өндөртэй мод сөөг, нутгийн ургамал болон олон наст ургамлын суулгацыг бэлтгэн биологийн нөхөн сэргээлт болон орчны тохижилт, ойн зурвас байгуулах зэрэг үйл ажиллагаанд 2010 оноос хойш ашиглаж байгаад бөгөөд жилд дунджаар 5-10 мянга орчим мод сөөг, бутлаг ургамлын тарьц, суулгац үржүүлж бойжуулдаг. 2023 оны хавар талбайн хөрс боловсруулалтын ажлыг эхэлж 10 төрөл зүйлийн 10000 ш үр болон мөчирөөр тарьж ургуулсан байна. Үүнд: Тоорой-1000 ш, Жигд-2500 ш, Сухай-2500 ш, Шар хуайс-200 ш, Заг-100 ш, Улиас-500 ш, Хайлаас-3000, Агч-100, Бүйлс-100, Гүйлс-100ш тус тус үржүүлэн арчилгаа хамгаалалтыг хийж байна. Тоорой модыг үрээр тарималжуулах ургуулах туршилт судалгааны ажлыг үргэлжлүүлэн Баянхонгор аймаг Эхийн голоос тоорой модны үр түүж мод үржүүлэг туршилтын талбайд тарьж байна.



Зураг 4.1.11. Хүлэмжинд үрээр тарьж ургуулсан жигд болон гүйлсний өсөлт



Зураг 4.1.11. Гадаа үрээр тарьж ургуулсан хайлаас болон жигд

4.1.12 Уулын туруутан амьтдад зориулсан биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэх

2023 оны 1 болон 2 дугаар саруудад Энержи ресурс ХХК Цогтцэций сумын зүүн талд байрлах Хангинах, Тугийн цохио зэрэг 2 байршилд нийт 40 боодол өвс байршуулсан. Бид зэрлэг амьтадын ажиглалт хийх зорилгоор Хангинах ууланд автомат камер байрлуулсан.

Тус үйл ажиллагаанд нийт 10 хүн 2 суудлын автомашин 1 ачааны машиныг ашигласан бөгөөд өвс тавих байршлыг Цогтцэций сумын байгаль хамгаалагч болон нутгийн малчин өрхөөс өгсөн зөвлөмжийн дагуу тодорхойлсон болно.



Зураг 4.1.12. Биотехникийн арга хэмжээ зохион байгуулсан байдал

4.2. Нүүрс баяжуулах үйлдвэрийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Тоо хэмжээ
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					
1	Нүүрсний шаталт уугилтыг тухай бүр бууруулж агаарын бохирдлоос сэргийлэх	Нүүрс ачих талбай	2023 оны 1-9-р сарын байдлаар нүүрсний овоолгын халалттай хэсгийг усаар хөргөж, тусгаарлаж авснаар 52620 тн нүүрс шатаж агаар бохирдохоос урьдчилан сэргийлсэн байна.	Үйлдвэрийн зардлаас	-
2	НБҮ-ийн конвейрийн хэсгээс үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор тоос сорогч төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах,	Нүүрс баяжуулах үйлдвэр	Нарийн ширхэглэгт тоосонцор сорох төнөг төхөөрөмжийг хэвийн ажиллагааг ханган тогтмол ажиллуулсан. Үйлдвэрийн удирдлагын өрөөнөөс удирдагдах бүрэн боломжтой автоматчилагдсан тоноглол юм	Үйлдвэрийн зардлаас	3
Газар доорх усны нөөцийг хэмнэлттэй ашиглах, хамгаалах					
3	Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэрийн үйл ажиллагааг горимын дагуу явуулж НБҮ-ийн технологийн усыг эргэлттэйгээр ашиглаж усны нөөцийг хэмнэх	Нүүрс баяжуулах үйлдвэр	2023 оны 9 сарын 30-ны өдрийн байдлаар хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэр нь 6 ширхэг усгүйжүүлэх төхөөрөмжийг ажиллуулж 888,795 м ³ усыг үйлдвэрт эргүүлэн татсан байна.	Үйлдвэрийн зардлаас	-

4	Усыг зөвхөн дүгнэлтэнд заасан хэмжээнд ашиглах	Ухаа худаг ус хангамж	2023.03.20 өдөр Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргаатай байгуулсан ус ашиглах гэрээгээр 1,625,808 м3/жил усыг баяжуулах үйлдвэрт ашиглахаас 679,603.7 м3 усыг ашигласан байна.	Үйлдвэрийн зардлаас	2
Хөрс, ургамал үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					
5	Мод тарьсан талбай, ногоон байгууламжийн усалгаа арчилгаа хийх	НБҮ-ийн засварын хэсэг	Баяжуулах үйлдвэрийн гадна ногоон байгууламж болон засмал зам дагуу 3000 модтой ногоон байгууламж бүхий талбайн усалгааг хуваарийн дагуу хийж гүйцэтгэсэн. Модны усалгаа арчилгаа хийхийн зэрэгцээ намрын цэнэг усалгааг 10 сарын 25-30-ны хооронд хийж өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангаж ажиллав	12,000	3000 мод
6	Мод сөөг тарих	Хаягдлыг овоолгын зүүн талд	Уурхайн хаягдлын овоолгын зүүн талд хаврын тарилтаар 5-р сарын 22-25-ны өдрүүдэд сухай, хайлаас, улиас, жигд гэсэн 4 төрлийн 500 мод тарьж усалгаа арчилгааг хийж гүйцэтгэв.	2,100	300 мод
НИЙТ ЗАРДАЛ, мян.төг				14,100.0*	


*Үйлдвэрлэлийн зардлаар хийгдсэн ажлын өртөг багтаагүй дүн

4.2.1 Нүүрсний шаталт уугилтыг тухай бүр бууруулж агаарын бохирдлоос сэргийлэх

Ухаа худаг уурхайн нүүрсний өөрөө шатах үзэгдлийг хянах, шаталтаас урьдчилан сэргийлэх зорилгоор дотоод нүүрсний өөрөө шатах үзэгдлийг хянах, сэргийлэх журмыг боловсруулан мөрдөж байна.

Нүүрсний шаталтаас үүсэх агаарын бохирдлоос урьчилсан сэргийлж нүүрсний овоолгын халалтын температурыг өдөр бүр хэмжиж, хэмжилтийн тайланг гаргаж холбогдох хүмүүст тайлагнаж байна.

2023 оны 10-р сарын 27-ны өдрийн байдлаар нүүрсний овоолгын халалттай хэсгийг усаар хөргөж, тусгаарлаж авснаар 52620 тн нүүрс шатаж агаар бохирдохоос урьдчилан сэргийлсэн байна.



Зураг 4.2.1.1. Өдөр тутмын тайлан



Зураг 4.2.1.2. Нүүрсний шаталт



Зураг 4.2.1.3. Шаталттай тусгаарлаж байгаа нь

4.2.2 НБҮ-ийн конвейрийн хэсгээс үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор тоос сорогч төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах,

Үйлдвэрийн тэжээлийн конвейер дээр 3 ширхэг Dust separator-г тус бүрд нь шинээр суурилуулж тэжээлийн кабель татаж удирдлагын өрөө болон газар дээр нь самбар байрлуулж тоноглож ажиллагаанд оруулсан. Үйлдвэрийн удирдлагын өрөөнөөс удирдагдах бүрэн боломжтой автоматчилагдсан тоноглол юм. Нарийн ширхэглэгт тоосонцор сорох төнөг төхөөрөмжийг хэвийн ажиллагааг ханган тогтмол ажиллуулсан.




Зураг 4.2.2.1. Тоосны хэмжилтийн график болон суурилуулсан төхөөрөмж

4.2.3 Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэрийн үйл ажиллагааг горимын дагуу явуулж НБҮ-ийн технологийн усыг эргэлттэйгээр ашиглаж усны нөөцийг хэмнэх

Хаягдлын усгүйжүүлэх үйлдвэрийн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангахын тулд засвар үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгэж байна.

2023 оны 9 сарын 30-ны өдрийн байдлаар хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэр нь 6 ширхэг усгүйжүүлэх төхөөрөмжийг ажиллуулж 888,795 м³ усыг үйлдвэрт эргүүлэн татсан байна.



Зураг 4.2.3.1 Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэр

4.2.4. Усыг зөвхөн дүгнэлтэнд заасан хэмжээнд ашиглах

Ухаахудаг уурхайн нүүрс баяжуулах үйлдвэрийн хэрэглээнд ашиглах усны дүгнэлтийг 2021.03.02-ны өдөр Усны газраас авч, Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргаатай ус ашиглах гэрээг байгуулсан бөгөөд гэрээнийд зааснаар 2,281,673.7 м³/жил ашиглахаас 9-р сарын 30-ны байдлаар үйлдвэрт ашигласан усны хэмжээ 1,791,910 м³ байна.



Зураг 4.2.4.1 Усны зөвшөөрөл болон гэрээ

4.2.5. Мод тарьсан талбай, ногоон байгууламжийн усалгаа арчилгаа хийх

Баяжуулах үйлдвэрийн гадна ногоон байгууламж болон засмал зам дагуу 3000 модтой ногоон байгууламж бүхий талбайн усалгааг хуваарийн дагуу хийж гүйцэтгэсэн. Модны усалгаа арчилгаа хийхийн зэрэгцээ намрын цэнэг усалгааг 10 сарын 25-30-ны хооронд хийж өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангаж ажиллав.



Зураг 4.2.5.1 Зам дагуух талбай болон НБҮ-н оффисийн гадна талбай

4.2.6. Мод сөөг тарих

Уурхайн шимт хөрсний овоолгын зүүн талд хаврын тарилтаар 5-р сарын 22-25-ны өдрүүдэд сухай, хайлаас, улиас, жигд гэсэн 4 төрлийн 500 мод тарьж усалгаа арчилгааг хийж гүйцэтгэв.



Зураг 4.2.7 Шимт хөрсний овоолгын урд мод тарилт

4.3. Цахилгаан станцын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Биелэлтийн шалгуур
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					
1	Цахилгаан станцын уурын зуухны нарийн үнс тээвэрлэхэд үүсэх тоосжилт бууруулах	Цахилгаан станц	Үнс зөөдөг машины битүүмжлэлийг сайжруулах арга хэмжээ авч тээвэрлэлтийн үед тоосжилт үүсэхээс сэргийлж ажилласан. Мөн үнс барих төхөөрөмжөөс гарч байгаа нарийн үнсийг чийглэж багсармал байдалд оруулж тээвэрлэх зориулалттай Pugmill төхөөрөмжийн судалгааны ажлыг хийж төсвийг шийдвэрлүүлсэн.	Үйлдвэрлэлийн зардалд багтсан	1 ширхэг
2	Станцын яндангаас гарах SO ₂ хийг бууруулах ажлын хүрээнд туршилтын журмаар шохойн чулууг зууханд хэрэглэх.	Цахилгаан станц	Зууханд нүүрсийг шатаах явцад үүссэн SO _x -г бууруулахын тулд 5 тонн шохойн чулуу шатааж турших зорилгоор худалдан авалтыг хийсэн.	Үйлдвэрлэлийн зардалд багтсан	5тн
Усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					
3	Цахилгаан станцын технологийн хаягдал усыг ногоон байгууламж ба зам талбайн усалгаанд дахин ашиглах	Цахилгаан станцын ус бэлтгэлийн хэсэг	Монгол улсын “Усны чанар, хаягдал ус, ерөнхий шаардлага”-ын стандарт MNS 4943:2015-н дагуу Цахилгаан станцын технологийн усанд шинжилгээ хийж, шинжилгээний үр дүн зөвшөөрөгдөх хэмжээнд гарсан тохиолдолд төслийн талбайн хөнгөн тэрэгний замны усд оруулж болох	Үйлдвэрлэлийн зардалд багтсан	30тн/ хоног

	Уст цэгийн ундарга сэргээх, тохижуулах	Сайн бичигт,	Өмнөговь аймаг Цогтцэций сумын Сийрст багийн нутагт байрлах Сайн бичигтийн хийдийн гар худгийн эх хамгаалах зорилгоор 3*4м харьцаатай байшин барих ажлыг Вектор хийц ХХК- иар хийлгэхээр гэрээ байгуулан ажиллаж байна	6,000	1
Ургамал, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					
5	Барилга байгууламжийн гадаад талбайн ногоон байгууламжид усалгаа арчилгааг хийх	Станцын гадаад талбай	Тайланд онд шинээр 1588 ширхэг модны тарьцыг тарьсан. Цахилгаан станцын гадна талбайд ургаж байгаа 4000 орчим модны усалгааг 5-10-р сарын хугацаанд хуваарийн дагуу хийсэн.	4,000	1000 мод усалгаа арчилгаа
6	Шувуудын хорогдол гарч буй эсэхэд ажиглалт судалгаа явуулах,	Цахилгаа -ны шугам сүлжээ ний дагуу	Наймдайн хөднийн усны гүний худгуудын хоорондох цахилгааны 10кВт-ын шугамын дагуу шувууны хорогдлын судалгааг 10 -р сарын 23-ны өдөр хийж гүйцэтгэсэн. Ажиглалтын явцад 5 хэрээ, 1 хул дунхай, 1 сар шувуу нийт 7 шувуу цахилгааны шонгийн дор тогонд цохиулан үхсэн байна. Тогонд цохиулж үхсэн 7 шувууны 4 нь тусгаарлагч бүрээсгүй шон байна.	2,000.0	20 км шугам
НИЙТ ЗАРДАЛ, мян.төг				12,000.0*	

*Үйлдвэрлэлийн зардлаар хийгдсэн ажлын өртөг багтаагүй дүн

4.3.1 Цахилгаан станцын уурын зуухны нарийн үнс тээвэрлэхэд үүсэх тоосжилт бууруулах

Цахилгаан станцын зуухны шаталтаас үүссэн утаанд агуулагдаж байгаа үнсийг цахилгаан статик шүүлтүүрээр ялган авдаг ба ялгаж авсан үнсийг уурхайн отволийн зориулалтын цэгт асгадаг. Үнсийг тээвэрлэх явцад үүсэх тоосжилтыг бууруулахын тулд үнс тээвэрлэдэг ачааны машины тэвшинд битүүмжлэл хийх, үнсийг тээвэрлэх явцад үнсний асгаралтыг бууруулах арга хэмжээг авч ажилласан.



Зураг 4.3.1. Үнсний тээвэрлэлтээс үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор хийгдсэн үнсний нягтруулгын мэдээлэл

4.3.2 Станцын яндангаас гарах SOx хийг бууруулах ажлын хүрээнд туршилтын журмаар шохойн чулууг зууханд хэрэглэх

Зууханд нүүрсийг шатаах явцад үүссэн SOx-г бууруулахын тулд 5 тонн шохойн чулуу шатааж турших зорилгоор худалдан авалтыг хийсэн. Туршилтыг өвлийн их ачааллын горимд хийхээр төлөвлөж байна. Туршилтын үр дүнд үндэслэн цаашид шохойн чулууг ашиглах эсэхийг тогтооно.

4.3.3 Цахилгаан станцын технологийн хаягдал усыг ногоон байгууламж ба зам талбайн усалгаанд дахин ашиглах

Монгол улсын “Усны чанар, хаягдал ус, ерөнхий шаардлага”-ын стандарт MNS 4943:2015-н дагуу Цахилгаан станцын технологийн усанд шинжилгээ хийж, шинжилгээний үр дүн зөвшөөрөгдөх хэмжээнд гарсан тохиолдолд төслийн талбайн хөнгөн тэрэгний замын усалгаанд болон цахилгаан станцын гадна талбайн ногоон байгууламж услахад 55,950 тн технологийн хаягдал усыг дахин ашигласан.



Зураг 4.3.3 Цахилгаан станцын технологийн хаягдал усаар зам талбай, мод услаж буй байдал

4.3.4. Уст цэгийн ундарга сэргээх, тохижуулах

Өмнөговь аймаг Цогтцэций сумын Сийрст багийн нутагт байрлах Сайн бичигтийн хийдийн гар худгийн эх хамгаалах зорилгоор 3*4м харьцаатай байшин барих ажлыг Вектор хийц ХХК-иар хийлгэхээр гэрээ байгуулан ажиллаж байна

4.3.4 Барилга байгууламжийн гадаад талбайн ногоон байгууламжид усалгаа арчилгааг хийж, мод сөөг нэмж тарих,

Ухаа Худагийн цахилгаан станцын хашаан дотор болон гадна 888 ширхэг, дэд станцын хашаан дотор 700 ширхэг хайлаас, бут, сөөг тарьж ургуулан, ногоон байгууламжийг сайжруулсан бөгөөд автомат усалгааны систем суурилуулж, мод арчилгааг тогтмол хийн ажиллаж байна.

Ногоон байгууламж харах нь хүний хувьд стрессийн төвшнийг бууруулж, анхаарал төвлөрөх чадварыг нэмэгдүүлж, оюун бодлыг цэгцлэхэд тусалдаг байна. Харин гадаад орчны хувьд орчны дуу шуугианыг өөртөө шингээх; цаг агаарын хэт халалт болон сэрүүний температурыг тэнцвэржүүлэх; нүүрстөрөгч, хүхрийн дутуу ислийг задалж орчны агаарыг цэвэршүүлэх; орчны тоосжилтыг бууруулах зэрэг давуу талуудтай.



Зураг 4.3.4 Ногоон байгууламжийн харагдах байдал

4.3.6. Шувуудын хорогдлын судалгаа

М Си Эс Интернэйшнл ХХК нь цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуурууд дээр шувуу үргэгч хийснээр агаарын шугамын хөндлөвч дээр шувуу суух болон нисэх үед далавчаар гүйдэл дамжуулагчид хүрч агаарын шугам хамгаалалтаар тасрах, шувууны хорогдол гарах эрсдэлийг бууруулах ажлыг 2021 оноос хойш үе шаттайгаар гүйцэтгэж байна. Энэ онд 10 кВ-Кемпийн цахилгаан дамжуулах агаарын шугамын дагуу нийт 152 ширхэг шувуу үргэгч суурилуулж, тусгаарлагчуудыг чангалж тэгшлэх ажлыг гүйцэтгэсэн байна. Наймант, болон Наймдайн цахилгааны дамжуулах агаарын шугамын дагуу шувууны хорогдлын судалгаа хийхэд наймдайн 7-р худгийн хажууд нэг хар хэрээ хорогдсон байв.



Зураг 4.3.5.1. Шувуу үргээгч суурилуулсан байдал хар хэрээ

Зураг 4.3.5.2 Наймдайн 7-р худгийн хажууд үхсэн

4.4. Нүүрс ачиж буулгах талбайн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Тоо хэмжээ
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					
1	Дотоод замаас үүсэх тоосжилыг бууруулах зорилгоор хурдны хязгаарт хяналт тавих, цэвэрлэгээ хийх, шаардлагатай тохиолдолд усалгаа хийх	Ухаа худаг ба Цагаан хад НАБТ	Зам талбайг тоосжилт бага үүсгэдэг материалаар хучиж, усалгааг тогтмол хийж, НАБТ дотор тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 5км/ц байхыг мөрдүүлж ажилласан.	Үйлдвэр лэлийн зардалд багтсан	Шаардлага тай үед усалгаа, цэвэрлэгээ хийгдсэн байх
2	Салхины хаалтны бүрэн бүтэн байдлыг хангах замаар тоосны тархалтыг хязгаарлах	Цагаан хад НАБТ	Нүүрс ачиж буулгах талбайн салхины хамгаалалтын хашааны бүрэн бүтэн байдлыг хангаж шаардлагатай засвар үйлчилгээг тухай бүр хийж гүйцэтгэх нь тоосжилтын тархалтыг хязгаарлах ач холбогдолтой ажил бөгөөд салхины хамгаалалтын хашааны засвар үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр ажлын даалгавар боловсруулан ажиллаж байна.	Үйлдвэр лэлийн зардалд багтсан	Засвар үйлчилгээ хийгдсэн байх
Усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					

3	Унд ахуйн усны зөөврийн ба түр нөөцлөх савнуудад угаалга цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэл хийх	Ундны усны дамжлагын цэгүүд	Цагаан хадны ажилчдын кемпийн ундны усны нөөцийн 6м3 багтаамжтай 3ш савны угаалга ариутгал халдваргүйтгэлийн улирал тутам хийж гүйцэтгэсэн. Ундны усны нөөцийн савны угаалга, ариутгал халдваргүйтгэх ажлыг Энержи ресурс ХХК-ийн Эрүүл ахуйн журманд заасны дагуу хийж гүйцэтгэсэн болно.	500.0	Ариутгал халдваргүйтгэл хийгдсэн байх
4	Ахуйн шингэн хаягдлын цэгт ариутгал халдваргүйтгэл хийх	Цагаанханд	Дэд бүтцийн албанаас хуваарийн дагуу “Цагаан хад” хэсгийн амрах байрны ариун цэврийн байгууламж, цэвэрлэгээ, угаалга, үйлчилгээнээс ялгарч буй шингэн хог хаягдал цэгт 1 удаагийн ариутгал халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэсэн Хаягдал усны даланг тойруулж 500 м урттай төмөр хашаа шинээр барьж, мал амьтан орохоос хамгаалсан.	800.0	1-12 сард
Агаар мандалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					
5	Ахуйн хаягдал ус цэвэрлэх байгууламж барих	Төслийн талбай	Цэвэрлэх байгууламж нь кемпээс зүүн урагш 300 м зайд байрлана. Цагаан хадны ажилчдын хотхоны ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг цэвэрлэх зориулалттай хоногт 100м ³ /хүчин чадал нь бүхий цэвэрлэх байгууламжийн барьж ашиглалтанд оруулсан.	Үйлдвэрлэлийн зардлаас	1-12-р сард

6	Тосны асгаралтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах	Засварын төв	Асгаралтаас урьдчилан сэргийлэх, асгаралт үүссэн үед бэлэн байдлыг хангах зорилгоор асгаралт үүсгэх эрсдэлтэй цэгүүдийг тодорхойлж тус цэгүүд дээр асгаралтын үед хэрэглэх багаж хэрэгсэл, сав зэргийг байрлуулан хаягжуулсан. ЦХ-ны нүүрс тээврийн шаланзны засварын төвд асгаралтын үеийн бэлэн байдлыг хангах цэг байгуулсан. Цагаан хадны засварын төвөөс гарсан хаягдал тосыг Ухаа худагийн тээврийн засварын төвийн хаягдал тосны танк руу тээвэрлэн хийж байна.	Үйлдвэрлэлийн зардлаас	1-12-р сард
Ургамал, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					
7.	Мод сөөг шинээр тарьж ургуулах, усалгаа арчилгаа хийх	Цагаан хад НАБТ	Цагаан хадны Засварын төв орчимд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх буюу мод тарьж ургуулах ажлын хүрээнд 2023 оны 10 сард намрын тарилтаар 100 ширхэг хайлаас модыг тарьсан.	700.0	100ш мод тарьсан байх
8.	Зэрлэг амьтад хамгаалах биотехникийн арга хэмжээ зохион байгуулах,	Цагаан хад орчим байгуулсан уст цэг	Тус ажлын хүрээнд Цагаад хадны НАБТ дээрх уст цэгийг засварлаж ойролцоогоор 500тн усыг зөөвөрлөж дүүргэсэн бөгөөд засмал замын зүүн талд шинээр цэг үүсгэж усаар хангасан. Тухайн уст цэгийн ойролцоо 10 боодол өвс байрлуулсан ба Ханбогд сумын ЗДТГ-г ойролцоох нутгийн биотехникийн ажилд зориулж 50 боодол өвс хүргүүлсэн.	1,000	1-12-р сард
НИЙТ ЗАРДАЛ, мян.төг				3,000.0	

*Үйлдвэрлэлийн зардлаар хийгдсэн ажлын өртөг багтаагүй дүн

4.4.1 Дотоод замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор хурдны хязгаарт хяналт тавих, цэвэрлэгээ хийх, шаардлагатай тохиолдолд усалгаа хийх

Нүүрс ачиж буулгах талбайн дотоод тоосжилтыг бууруулах зорилгоор нарийн ширхэгтэй нүүрсээр машины дугуйны нөлөөгөөр тоосжилт үүсгэхээс сэргийлж тогтмол хусаж цэвэрлэх, хашаан доторх автомашины хурдны хязгаарыг 5км/цаг байхыг мөрдүүлэх, шаардлагатай тохиолдолд зам талбайд усалгаа хийх зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.



Зураг 4.4.1. НАБТ-н зам, талбайн тоосжилтыг бууруулах усалгаа болон хурдны хязгаарын тэмдэг

4.4.2 Салхины хаалтны бүрэн бүтэн байдлыг хангах замаар тоосны тархалтыг хязгаарлах


Нүүрс ачиж буулгах талбайн салхины хамгаалалтын хашааны бүрэн бүтэн байдлыг хангаж шаардлагатай засвар үйлчилгээг тухай бүр хийж гүйцэтгэх нь тоосжилтын тархалтыг хязгаарлах ач холбогдолтой ажил бөгөөд салхины хамгаалалтын хашааны засвар үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр ажлын даалгавар боловсруулан ажиллаж байна.



Зураг 4.4.2. НАБТ-н талбайн салхины хамгаалалтын хашаа

4.4.3 Унд ахуйн усны зөөврийн ба түр нөөцлөх савнуудад угаалга цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэл хий

Цагаан хадны ажилчдын кемпийн ундны усны нөөцийн 6м3 багтаамжтай 3ш савны угаалга ариутгал халдваргүйтгэлийн улирал тутам хийж гүйцэтгэсэн. Ундны усны нөөцийн савны угаалга, ариутгал халдваргүйтгэх ажлыг Энержи ресурс ХХК-ийн Эрүүл ахуйн журманд заасны дагуу хийж гүйцэтгэдэг болно.



Зураг 4.4.3.1 Унд ахуйн нөөц саванд хийсэн угаалга болон ариутгал хийсэн байдал

4.4.4 Ахуйн шингэн хаягдлын цэгт ариутгал халдваргүйтгэл хийх

Дэд бүтцийн албанаас хуваарийн дагуу “Цагаан хад” хэсгийн амрах байрны ариун цэврийн байгууламж, цэвэрлэгээ, угаалга, үйлчилгээнээс ялгарч буй шингэн хог хаягдал цэгт 1 удаагийн ариутгал халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэсэн Хаягдал усны даланг тойруулж 500 м урттай төмөр хашаа шинээр барьж, мал амьтан орохоос хамгаалсан.



Зураг 4.4.4.1 Бохирын цэгийг ариутгасан байдал




Зураг 4.4.4.1 Бохирын цэгийг тойруулсан
барьсан хашаа

4.4.5 Ахуйн хаягдал ус цэвэрлэх байгууламж барих

Цэвэрлэх байгууламж нь кемпээс зүүн урагш 300 м зайд байрлана. Цагаан хадны ажилчдын хотхоны ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг цэвэрлэх зориулалттай хоногт 100м³/ хүчин чадал нь бүхий цэвэрлэх байгууламжийн барьж ашиглалтанд оруулсан.

Уг цэвэрлэх байгууламж нь технологийн схемийг умбуур цэвэрлэх байгууламжийн бодис, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч ба азотоор тооцсон гүн цэвэрлэгээ бүхий биологи цэвэрлэгээний процесстай байгууламж юм. Цэвэрлэх байгууламжаас гарах саарал усыг мод усалгаанд ашиглахаар төлөвлөж байна.



Зураг 4.4.5 Ахуйн хаягдал ус цэвэрлэх байгууламж болон хаягдал ус хуримтлуулах сан

4.4.6 Тосны асгаралтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах

Асгаралтаас урьдчилан сэргийлэх, асгаралт үүссэн үед бэлэн байдлыг хангах зорилгоор асгаралт үүсгэх эрсдэлтэй цэгүүдийг тодорхойлж тус цэгүүд дээр асгаралтын үед хэрэглэх багаж хэрэгсэл, сав зэргийг байрлуулан хаягжуулсан. ЦХ-ны нүүрс тээврийн шаланзны засварын төвд асгаралтын үеийн бэлэн байдлыг хангах цэг байгуулсан. Цагаан хадны засварын төвөөс гарсан хаягдал тосыг Ухаа худагийн тээврийн засварын төвийн хаягдал тосны танк руу тээвэрлэн хийж байна. Мөн сар бүр ажлын байрны үзлэг хийж гарсан асгаралтуудыг журмын дагуу цэвэрлүүлж, хариу арга хэмжээг авч ажиллаж байна.



Зураг 4.4.4.1 Хаягдал тос хадгалах түр цэг

4.4.7 Мод сөөг шинээр тарьж ургуулах, усалгаа арчилгаа хийх

Цагаан хадны Засварын төв орчимд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх буюу мод тарьж ургуулах ажлын хүрээнд 2023 оны 10 сард намрын тарилтаар 100 ширхэг хайлаас модыг тарьсан.



Зураг 4.4.6. Цагаан хад НАБТ засвар орчимд мод тарьж байгаа нь

4.4.8. Зэрлэг амьтад хамгаалах биотехникийн арга хэмжээ

Нүүрс ачиж буулгах талбайн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний хүрээнд биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлсэн. Тус ажлын хүрээнд Цагаад хадны НАБТ дээрх уст цэгийг засварлаж ойролцоогоор 550 тн усыг зөөвөрлөж дүүргэсэн бөгөөд засмал замын зүүн талд шинээр цэг үүсгэж усаар хангасан. Тухайн уст цэгийн ойролцоо 10 боодол өвс байрлуулсан ба Ханбогд сумын ЗДТГ-т биотехникийн ажилд зориулж 50 боодол өвс хүргүүлсэн.



Зураг 4.4.7.1. Цагаан хадны зэрлэг амьтад зориулсан уст цэгүүд



Зураг 4.4.7.2. Дайчингийн заг орчим биотехникийн арга хэмжээ зохион байгуулсан байдал

5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын Гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Биелэлтийн шалгуур
1	Хаягдлын овоолгыг налууулж, хэлбэршүүлэх	Уурхайн хаягдлын овоолго	Уурхайн хаягдлын овоолгын талбайг налууулж, хэлбэршүүлэх ажлыг 20 га талбайд хийж гүйцэтгэсэн.	Үйлдвэр - лэлийн зардлаас	20 га талбай
2	Хаягдлын овоолгын хэлбэршүүлсэн талбайг шимт хөрсөөр хучих	Уурхайн хаягдлын овоолго	Уурхайн хаягдлын овоолгын налууулж, хэлбэршүүлсэн талбайг шимт хөрсөөр хучих биологийн нөхөн сэргээлтийн эхний үе шатны ажлыг 10 га талбайд туслан гүйцэтгэгч компанитай хамтран шимт хөрсөөр хучих ажлыг хийж гүйцэтгэсэн.	Үйлдвэр - лэлийн зардлаас	10 га талбай
3	Ургамалжуулсан талбайг усалж арчилах, нөхөн тарилт хийх	Уурхайн хаягдлын овоолго	2020-2022 онд уурхайн хаягдлын овоолгын налууулж, хэлбэршүүлж ургамалжуулсан 3 га талбайн арчилгаа хамгаалалтыг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэв.	15,000.	3 га талбай
4	Тэр бум мод хөтөлбөрийн хүрээнд мод тарих	Үйлдвэрлэлийн бүс, ажилчдын хотхон, Баяндалай сум	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Энержи ресурс” ххк говь цөлийн бүсэд газар нутгийг хөрсний доройтол, цөлжилтөөс хамгаалах үндсэн зорилтын хүрээнд мод тарьж ургуулах ажлыг 2023.05.22-2023.05.30-ны өдрүүдэд ухаа худаг уурхайн үйлдвэрлэлийн бүс, хатуу хучилттай зам дагуу, ажилчдын хотхон, Цэций хороолол орчим, Баруун наран уурхайд нийт 30,000ш мод тарьж суулгах ажлыг хийж гүйцэтгэв.	60,000.	50,000ш
НИЙТ ЗАРДАЛ, мян.төг				75.000.0	

5.1. Хаягдлын овоолгын талбайд техникийн нөхөн сэргээлт хийх

“Ухаа худаг” уурхайн техник эдийн засгийн үндэслэлд тусгагдсан гадаад овоолгын техникийн ба биологийн нөхөн сэргээлтийн ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх, нөхөн сэргээлтийн ажлыг Монгол улсын холбогдох стандартын шаардлагад нийцүүлэн, зохих аргачлалын дагуу 20 га талбайд хийж гүйцэтгэсэн. Нөхөн сэргээлтийн ажлыг хаягдлын овоолгын зүүн хойд хэсэгт, холбогдох аргачлалын дагуу, стандартын шаардлагад нийцүүлэн хийсэн бөгөөд налууугийн хажуугийн өнцөг нь дунжаар 17 градус ба 4 м өргөнтэй дэвсгээр тусгаарлагдсан тус бүр нь 30 м хүртэл урттай 5 шатлал бүхий талбай юм.



Зураг 5.1.1. Хаягдлын овоолгыг хэлбэршүүлсэн байдал

5.2. Хаягдлын овоолгын талбайг шимт хөрсөөр хучих

Уурхайн хаягдлын овоолгын налууулж, хэлбэршүүлсэн талбайг шимт хөрсөөр хучих биологийн нөхөн сэргээлтийн эхний үе шатны ажлыг 10 га талбайд туслан гүйцэтгэгч компанитай хамтран шимт хөрсөөр хучих ажлыг хийж гүйцэтгэж байна. Хучилт хийсэн шимт хөрсний зузааныг уурхайн ТЭЗҮ-д заасны дагуу 0.3 метрээс багагүй хэмжээтэй байхаар хучилтын ажлыг явуулсан.



Зураг 5.2.1. Хаягдлын овоолгын хэлбэршүүлсэн талбай дээр шимт хөрсийн хучилт хийж буй байдал

5.3. Ургамалжуулсан талбайг усалж арчилах, нөхөн тарилт хийх

2020-2022 онд уурхайн хаягдлын овоолгын налууулж, хэлбэршүүлж ургамалжуулсан 3 га талбайн арчилгаа хамгаалалтыг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлж ургамлан бүрхэвч, ургалт нь сайн явагдаагүй хэсгүүд дээр 2023 оны 07 сарын 20-ноос 08-р сарын 15-нийг хүртэлх хугацаанд нөхөн тарилтын ажлыг хийж гүйцэтгэсэн.



Зураг 5.4.1. Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай ургамлан бүрхэвч



Зураг 5.4.2. Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай харагдаж буй байдал

5.5. Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд мод тарих

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Энержи ресурс” ххк говь цөлийн бүсэд газар нутгийг хөрсний доройтол, цөлжилтөөс хамгаалах үндсэн зорилтын хүрээнд мод тарьж ургуулах ажлыг 2023.05.22-2023.05.30-ны өдрүүдэд ухаа худаг уурхайн үйлдвэрлэлийн бүс, хатуу хучилттай зам дагуу, ажилчдын хотхон, Цэций хороолол орчим, Баруун наран уурхайд нийт 30,000ш мод тарьж суулгах ажлыг хийж гүйцэтгэв. Мөн Богдхан уул Хүрхрээгийн аманд 2500ш, Хэнтий аймагт 17,000ш, Баяндалай сумын нутагт байгалийн заган ойг түшиглэж 10,000ш бортоготой заган суулгацаар ойжуулалтын ажил хийхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.





Зураг 5.5.1. Үйлдвэрлэлийн бүс, зам дагуу ажилчдын хотхон тарилт хийж буй байдал



Зураг 5.5.2. Заган ойжуулалтын талбайн нүх ухалтын ажил

6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Биелэлтийн шалгуур
1	Биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэхэд Говь гурван сайханы байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх	Говь гурван сайханы БЦГ-н Баяндалай сумын хэсэг	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Говь гурван сайханы байгалийн цогцолборт газрын захиргаанд уулын туруутан амьтадад зориулж 131 боодол өвсийг 2023 оны 1-р сарын 21-ны өдөр хүлгээлгэн өгөв.	2,000.0	100 боодол өвс

2	Амьтдын амьдрах орчинг сайжруулах зорилгоор эвдэрсэн газарт нөхөн сэргээлт	Баяндалай сумын нутагт	Баяндалай сумын Төхөм багийн нутаг дэвсгэрт эвдэрч орхигдсон 5 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг стандарт шаардлагын дагуу хийж гүйцэтгэсэн.	50,000.0	5 га
НИЙТ ЗАРДАЛ, мян.төг				52,000.0	

6.1. Биотехникийн арга хэмжээ

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Говь гурван сайхан уулын байгалийн цогцолборт газрын захиргаанд уулын туруутан амьтадад зориулж 131ш боодол өвсийг 2023 оны 1-р сарын 21-ны өдөр хүлгээлгэн өгөв.



Зураг 6.1.1. Говь гурван сайханы байгалийн цогцолборт газрын захиргаанд өвс хүлээлгэн өгч буй байдал

6.2. Амьтдын амьдрах орчинг сайжруулах зорилгоор эвдэрсэн газарт нөхөн сэргээлт

Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт тусгагдсан Монгол орны хэмжээнд уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч эзэнгүй орхигдсон талбайг нөхөн сэргээх зорилтын хүрээнд манай компани гар аргаар алт олборлосон Өмнөговь аймгийн Баяндалай сумын Баян цагааны нуруу, 5 га эвдрэлтэй талбайд техникийн нөхөн сэргээлтийг холбогдох стандартын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг ажлыг уул уурхайн компаниуд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний хүрээнд хийж гүйцэтгэж байгаа бөгөөд Энержи ресурс ХХК нь 2018 оноос эхлэн Говь 3 сайханы байгалийн цогцолборт газар болон Наймдайн хөндийд дүйцүүлэн хамгааллын ажлыг хэрэгжүүлж ирсэн болно.

Техникийн нөхөн сэргээлтэнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Үүнд:


- Хуурай сайрын эргийг бэхжүүлэн түрж налуулах
- Гуу жалга, судгуудыг нээж үерийн усыг чөлөөтэй урсах нөхцлийг бүрдүүлэх
- Шимт хөрс дэвсэж зонхилох салхины хөндлөн чиглэлд самнаж, жижиг ховил үүсгэх

Монгол улсад мөрдөгдөж байгаа стандартын дагуу техникийн нөхөн сэргээлт хийснээр хүн, мал амьтан унаж бэртэх, осол эрсдэлийг бууруулж, амьдрах орчин сайжирна.

Нөхөн сэргээлтийн ажлыг 2023.10.14-19 ний хооронд Doosan 55 маркын гинжит экске, 2 оператор, гар тэгшилгээнд 4 хүн 2 хоног ажилласан.

Хэнгэрэг нэрт газар гар аргаар алт олборлсон 20 орчим нүхийг тэгшлэхэд техник орох боломжгүй тул гар аргаар хөрсөөр дүүргэж тэгшлэлтийн ажлыг гүйцэтгэв.

Нөхөн сэргээлтийн ажлыг 2023 оны 10-р сарын 20-ны өдөр Говь гурван сайханы байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Өмнөговь аймгийн Баяндалай сумын Төхөм багийн засаг даргын хамтаар газар дээр нь үзэж хүлээлцэх акт үйлдсэн болно.



Зураг 6.2.1 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт хийгдэх байршилын зураг





Зураг 6.2.2 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт хийж буй байдал

7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Энержи Ресурс ХХК нь нийгмийн хариуцлагынхаа хүрээнд орон нутгийн малчдад өвөл хаврыг өнтэй давхад нь туслах зорилгоор жил бүр өвс, тэжээлийн тусламжийг 2009 оноос хойш жил бүр үзүүлсээр ирсэн.

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Тоо хэмжээ
1	Нөлөөллийн бүсийн айл өрхөд өвс тэжээлийн дэмжлэг үзүүлэх	Ухаа худаг төсөл	Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын аюулгүй фондод 500 боодол өвс, өвсийг хүлээлгэн өгсөн төдийгүй Цогтцэций сумын 4 багийн 430 малчин өрх, “Ухаа худаг” уурхайн нөлөөллийн бүсийн 25 малчин өрх болон Баруун наран уурхайн нөлөөллийн бүсийн 20 малчин өрхөд өвс, тэжээлийн дэмжлэг тусламжийг үзүүлсэн байна.	Орон нутгийн төсөл хөтөлбөрийн зардлаас	5000 боодол өвс

Энэ жилийн хувьд нийт 8500 боодол өвсийг Дорнод аймгийн Булган сумаас 1600 уут хивэг тэжээл “Өег гурил” ХХК-иас худалдан авч “Ухаа худаг”-ийн нөөцийн цэгт төвлөрүүлж, нөөцлөх хураах, хадгалах, малчдад хүлээлгэн өгөх ажлуудыг тус тус зохион байгуулж дууслаа. Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын аюулгүй фондод 500 боодол өвс, өвсийг хүлээлгэн өгсөн төдийгүй Цогтцэций сумын 4 багийн 430 малчин өрх, “Ухаа худаг” уурхайн нөлөөллийн бүсийн 25 малчин өрх болон Баруун наран уурхайн нөлөөллийн бүсийн 20 малчин өрхөд өвс, тэжээлийн дэмжлэг тусламжийг үзүүлсэн байна.



Зураг 7.1.1. Малчдад өвс тэжээл олгож буй байдал

8. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Манай компани нь 2009 оноос хойш холбогдох хууль ба компанийн нийгмийн хариуцлагын ажлын хүрээнд түүх соёлын биет ба биет бус өвийг хамгаалах чиглэлээр дараах гол ажлуудыг хийж хэрэгжүүлсэн. Үүнд :

- Холбогдох хуулийн дагуу төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө археологи палентлогийн хайгуул судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, авран хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулсан.
- 2013 онд Говь шанхын уртын дууг заах сургагч багшийн сургалт явуулж, зохиогчийн эрхийн патентыг Цогтцэцийн сумын Соёлын төвийн нэр дээр авах ажлыг зохион байгуулсан.
- 2014 онд Ганжуур Данжуур судрыг Төвд хэлнээс хөрвүүлэн хэвлүүлэх ажлыг “Цогт цагийн хүрдэн” ТББ –тай хамтран гүйцэтгэж, Улсын төв номын санд хүлээлгэн өгсөн.
- Цогтцэцийн жонон морин хуурын татлагын сургалтыг 2 жилийн хугацаанд зохион байгуулж, сургалтанд хамрагдсан хүүхдүүдээс бүрдсэн морин хуурын хамтлаг байгуулж, хамтлагийг улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээг хүлээлгэн өгсөн.
- Цогтцэций суманд байрлах Монгол улсын баатар Т.Борын нэрэмжит музейн нэг танхимыг тохижуулсан.
- Цогтцэций сумын хэмжээнд соёлын биет болон биет бус өв тээгчдийн судалгааг хийж, нэгдсэн бүртгэлийг тус суманд хүлээлгэн өгсөн.

2023 оны хувьд түүх соёлын өвийг хамгаалах чиглэлээр үргэлжлэн хийгдэх ажил төлөвлөгдөөгүй бөгөөд цаашид түүх соёлын өвийг хамгаалах чиглэлээр тухай бүр шаардлагатай арга хэмжээг санаачлан зохион байгуулна.

9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Биелэлтийн шалгуур
9.1	Химийн бодисын агуулахад хадгалж байгаа бодисуудыг асгаралт, гоожилтоос урьдчилан сэргийлэх үзлэг, шалгалтыг тогтмол хийх	Химийн бодисын агуулах	Онцгой байдлын ерөнхий газрын даргын А/229 тушаалын хавсралт 6 дахь “Химийн бодисын агуулахыг шалгасан акт” бланкын дагуу агуулах дахь бодисын бүртгэл хөтлөл, асгаралт үүссэн эсэх, бусад зөрчлийг илрүүлэх, арилгах зорилгоор сар бүр дотооддоо үзлэг хийдэг.	4,800,0	Сар бүр
9.2	Химийн бодисын савыг эрх бүхий байгууллагад хүргүүлж устгуулах	Уурхайн хэмжээнд	Химийн бодисын сав баглаа боодол устгуулах нэмэлт гэрээг 2022 оны 12-р сарын 31-нийг дуустал хугацаанд аюултай хог хаягдал устгах, дахин боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий “Цэцүүх трейд” ХХК-тай байгуулсан бөгөөд тайлант хугацаанд дотоод хяналтын лабораторийн үйл ажиллагаанаас 156.1кг химийн бодисын хуванцар сав баглаа боодлыг хамгийн сүүлд 2023 оны 3 болон 10-р сар гэрээг компанид хүргүүлэх, устгуулах ажлыг зохион байгуулсан	6,000.0	11-р сард
9.3	Химийн бодистой харьцаж ажилладаг ажиллагсдыг сургалтанд хамруулах	Химийн бодисын агуулах	Химийн бодисын аюулгүй ажиллагааны сургалтыг нүүрс баяжуулах үйлдвэр, дэд бүтцийн алба, геологи уурхайн төлөвлөлтийн алба, уурхайн засвар хэсгүүдийн химийн бодистой харьцаж ажилладаг нийт 42 ажилтанд зохион байгуулж, бүртгэлийг хийж баталгаажуулсан.	3,000.0	Жилд 1 удаа
9.4	Галын эрсдэлээс сэргийлэх практик болон онолын сургалтыг нийт ажилтнуудад орох	Ухаа худаг төсөл	Галын аюулаас урьдчилан сэргийлэх онол болон практикын тактикийн сургуулилтыг Галерей кемпийн 38 ажилтанд Аврах бүлэг, Гал түймэр унтраах аврах 44 дүгээр ангитай хамтран 2023 оны 10-р сарын 11-ны өдөр 11:00 минутанд хийсэн.	Үйл ажиллагааны зардлаас	10-р сард

9.5	Галын аюулгүй байдлын бүлгэмийн үйл ажиллагааг хэвийн явуулах, галын хорны үзлэг шалгалтыг тогтмол хийх	Ухаа худаг төсөл	Тайлант хугацаанд галын бүлгэмийг шинчлэх, дахин бүрдүүлэх, дадлагажуулах үйл ажиллагааг тогтмол хийж гүйцэтгэсэн. ГАУС үзлэг шалгалтыг тогтмол хийж галын бүлгэмийн үйл ажиллагааг сайжруулах үүрэг чиглэл өгч ажиллаа. Гал унтраагуурын үйл ажиллагаанд хяналт тавьж сард 1-2 удаа үзлэг шалгалт хийх, тухай объектын ажилчидад дадлага сургуулилт орсон.	Үйл ажиллагааны зардлаас	Сар бүр
9.6	Лабораториудын шинжилгээний үед гарах химийн бодисын уусмал үлдэгдлийг аюулгүй байдлаар зайлуулагдаж байгаа эсэхэд бүртгэл хөтөлж, саарамагжуулж бохир ус зайлуулах шугаманд нийлүүлэх	УХГ төв лаборатори	Усны шинжилгээний лабораториос гарсан бага хэмжээний бодисын хаягдалыг саарамагжуулж, концентрацийг багасган аюулгүй болгон, рН-ийг тэмдэглэж, бүртгэл хөтөлж баримтжуулан, бохирын хоолойд нийлүүлж устгадаг. Микробиологийн лабораториос гардаг тэжээлт орчны хаягдалыг сумын бохир ус цэвэршүүлэх байгууламжид хүлээлгэн өгч устгуулдаг.	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш тухай бүрд
НИЙТ ЗАРДАЛ, мян.төг				13,800.0	

9.1 Химийн бодисын хадгалалтын хяналт

Онцгой байдлын ерөнхий газрын даргын А/229 тушаалын хавсралт 6 дах “Химийн бодисын агуулахыг шалгасан акт” бланкын дагуу агуулах дахь бодисын бүртгэл хөтлөн, асгаралт үүссэн эсэх, бусад зөрчлийг илрүүлэх, арилгах зорилгоор дотооддоо болон, ХАБ-ын ажилтнуудтай хамтарсан үзлэгийг сар бүр тогтмол зохион байгуулдаг. Одоогоор үл тохиролгүй ажиллаж байна.



Зураг 9.1.2. Химийн бодисын агуулахын үзлэгийн хуудас, асгаралт цэвэрлэх материал

9.2. Химийн бодисын савыг эрх бүхий байгууллагад хүргүүлж устгуулах

Химийн бодисын сав баглаа боодол устгуулах нэмэлт гэрээг 2022 оны 12-р сарын 31-нийг дуустал хугацаанд аюултай хог хаягдал устгах, дахин боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий “Цэцүүх трейд” ХХК-тай байгуулсан бөгөөд тайлант хугацаанд дотоод хяналтын лабораторийн үйл ажиллагаанаас 156.1 кг химийн бодисын хуванцар сав баглаа боодлыг хамгийн сүүлд 2023 оны 3 болон 10-р сар гэрээт компанид хүргүүлэх, устгуулах ажлыг зохион байгуулсан. Одоо химийн бодисын агуулахад хуримтлагдсан сав, баглаа боодлыг хог, хаягдал хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэж өгөхөөр бэлтгэж байна.

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАНГАЛЫН ТАГААЛАХ БИЧИГ
№ 00492

СЭРГЭЭЖИЙН ХАМГААГАЛ

Агуулга	Химийн бодисын нэр	Сав баглаа боодлын төрөл	Салын дээд хэмжээ	Хүлээх хугацаа	Тусгай зөвшөөрөл	Агуулахын төрөл
1	Хлоридын уусмал	Хлоридын уусмал	5000	2023.03.31	ХХК	ХХК
2	Хлоридын уусмал	Хлоридын уусмал	5000	2023.03.31	ХХК	ХХК
3	Хлоридын уусмал	Хлоридын уусмал	5000	2023.03.31	ХХК	ХХК
4	Хлоридын уусмал	Хлоридын уусмал	5000	2023.03.31	ХХК	ХХК

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАНГАЛЫН ТАГААЛАХ БИЧИГ
№ 0000550

СЭРГЭЭЖИЙН ХАМГААГАЛ

Агуулга	Химийн бодисын нэр	Сав баглаа боодлын төрөл	Салын дээд хэмжээ	Хүлээх хугацаа	Тусгай зөвшөөрөл	Агуулахын төрөл
1	Хлоридын уусмал	Хлоридын уусмал	5000	2023.03.31	ХХК	ХХК
2	Хлоридын уусмал	Хлоридын уусмал	5000	2023.03.31	ХХК	ХХК
3	Хлоридын уусмал	Хлоридын уусмал	5000	2023.03.31	ХХК	ХХК
4	Хлоридын уусмал	Хлоридын уусмал	5000	2023.03.31	ХХК	ХХК

Зураг 9.2.1 Химийн бодисын сав боодлыг мэргэжлийн байгууллагад хүргүүлсэн баримт



Зураг 9.2.2 Эрх бүхий байгууллагад хүргүүлсэн сав баглаа боодол

9.3. Химийн бодистой харьцаж ажилдаг ажиллагсдыг сургалтанд хамруулах

Химийн бодисын аюулгүй ажиллагааны сургалтыг тайлант хугацаанд зохион байгуулсан байна. Энэхүү сургалтыг химийн бодисын ХАЛМ, Химийн бодистой холбоотой Монгол улсын хууль дүрэм журам, үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглагддаг химийн бодисоос үүдэлтэй эрсдэл, түүнээс

урьдчилан сэргийлэх чиглэлийн 2 цагийн хөтөлбөрөөр 2023.05.03, 05.19, 09.11-ний өдрүүдэд зохион байгуулав. Энэ удаагийн сургалтанд нүүрс баяжуулах үйлдвэр, геологи уурхай төлөвлөлтийн алба, уурхайн засвар, дэд бүтцийн албаны химийн бодистой харьцаж ажилладаг нийт 42 ажилтан хамрагдсан байна.

Зураг 9.3.1 Химийн бодисын сургалтын бүртгэл



Зураг 9.3.2 Сургалтанд хамрагдах үеийн зураг

9.4 Бодисын уусмалын дотоод хяналт

Галын аюулаас урьдчилан сэргийлэх онол болон практик, тактикийн сургууилтыг Галерей кемпийн 38 ажилтанд Аврах бүлэг, Гал түймэр унтраах аврах 44 дүгээр ангитай хамтран 2023 оны 10-р сарын 11-ны өдөр 11:00 минутанд хийсэн.



Зураг 9.4.1 Сургалтанд хамрагдах үеийн зураг

9.5 Галын аюулгүй байдлын бүлгэмийн үйл ажиллагааг хэвийн явуулах, галын хорны үзлэг шалгалтыг тогтмол хийх.


Тайлант хугацаанд галын бүлгэмийг шинчлэх, дахин бүрдүүлэх, дадлагажуулах үйл ажиллагааг тогтмол хийж гүйцэтгэсэн. ГАУС үзлэг шалгалтыг тогтмол хийж галын бүлгэмийн үйл ажиллагааг сайжруулах үүрэг чиглэл өгч ажиллаа. Гал унтраагуурын үйл ажиллагаанд хяналт тавьж сард 1-2 удаа үзлэг шалгалт хийх, тухай объектын ажилчидад дадлага сургуулилт орсон.



Зураг 9.5.1 Сургалтанд хамрагдах үеийн зураг

9.6 Бодисын уусмалын дотоод хяналт

Усны химийн шинжилгээг гүйцэтгэхэд бага хэмжээний химийн бодисын уусмалын үлдэгдэлийг тухай бүрд нь саармагжуулж, концентрацийг багасган аюулгүй болгон, рН-ийг тэмдэглэж, бүртгэл хөтлөн баримтжуулж, бохирын хоолойд нийлүүлж устгадаг. Микробиологийн лабораториос гардаг тэжээлт орчны хаягдалыг сумын бохир ус цэвэршүүлэх байгууламжид хүлээлгэн өгч устгуулдаг.



Зураг 9.6.1 Химийн бодисын уусмал үлдэгдлийг саармагжуулж устгасан бүртгэл, Тэжээлт орчны хаягдалыг устгасан бүртгэл

10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал, мян.т өг	Тоо хэмжээ
1.	Хуванцрын хог хаягдлыг ангилан ялгах	Хог хаягдал түр хадгалах цэгүүд	2023 оны 10-н сарын байдлаар хуванцар хог хаягдлыг эх үүсвэр дээр нь 267 м3 ангилан ялгаж дахиварын цех дээр хуванцар сав пресслэгч машиныг суурилуулсан бөгөөд одоогийн байдлаар 230 м3-ыг пресслэн үлдсэн 37 м3-ыг дахиварын цех дээрх хуванцар хадгалах хашаанд хадгалж байна.	4,000.0	40
2.	Зам талбайд хийсч тарсан хог хаягдлын цэвэрлэгээ зохион байгуулах	Төслийн талбай Цагаан хад НАБТ Ажилчдын хотхон	Ухаа худаг төслийн талбайн зам, талбайд хийсч тарсан хогны цэвэрлэгээг 18 удаа хийж нийт 13 м3 хогийг зайлуулсан байна. Мөн Цогтцэций сумын засаг даргаас УБ-ДЗ-ЦЦ чиглэлийн авто замын дагуу 2 талаар 27-37км-т зурваст заасан хог хаягдлыг 5-р сарын 17-ны өдөр 8 м3 хог цэвэрлэгээг хийж гүйцэтгэсэн. Цагаан хадны НАБТ-д давхардсан тоогоор 351 ажилчин 39 удаагийн хог цэвэрлэгээгээр, давхардсан тоогоор 408 га талбайгаас 237.2м3 хогийн зайлуулсан байна.	800.0	4

3.	Дахин ашиглагдах хаягдлыг 2догч түүхий эд авдаг аж ахуйн нэгж байгууллагад нийлүүлэх. /хуванцар сав, мод, төмөр/	Хог хаягдал түр хадгалах цэгүүд	Тайлант онд нийт 40.6 м3 хаягдал модыг татан авснаас 23 м3 орон нутгийн иргэдийн ахуйн хэрэглээнд, 110 тонн хаягдал төмрийг хогийн цэгт хадгалж байгаа ба 15тн төмрийг орон нутгийн хаягдал төмөр хүлээн авдаг “Хүрэл эрчим ” ХХК-д хүлээлгэн өгсөн байна.	Үйл ажиллагааны зардлаас	1-12-р сард
4.	Хаягдал дугуй, машин техникийн хаягдал төмөр, сэлбэгийг төвлөрүүлэх,	Хог хаягдал түр хадгалах цэгүүд	2023 оны 10 сарын 25-ны байдлаар 5400 ширхэг дугуй, 27 тэвш мод, 125 тонн төмөр төвлөрүүлсэн ба дотоод журмын дагуу компанийн ажигчид болон орон нутгийн иргэдэд борлуулжээ.	Үйл ажиллагааны зардлаас	50
5.	Аюултай хог хаягдлыг шаардлага хангасан нөхцөлд хадгалж, нийлүүлэгчид буцаан хүргүүлэх	Уурхайн засварын төв, 1тн эзэлхүүнтэй ИВС сав	2023 оны 09 сарын 25-ны байдлаар 579 ширхэг 1 тонны эзлэхүүнтэй ИВС сав нийлүүлэгч компанид буцаагдсан байна.	3,000.0	300
6.	Хаягдал тосыг цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Засварын төвүүд	Төслийн хэмжээнд энэ онд 365 тн хаягдал тос гарсан ба засварын төвд суурилуулсан 50 тн багтаамжтай зориулалтын ёмкостонд цуглуулж, хаягдал тос дахин боловсруулдаг “Хай би ойл ” ХХК-д нийлүүлсэн. 2023 онд аюултай хог хаягдлыг хүлээн авах эрх бүхий “Хай би ойл ” ХХК, “Монпители ойл” ХК гэрээ байгуулж хамтарч ажиллаж байна.	3,000.0	300
7.	Аюултай хог хаягдал болох аккумуляторыг эрх бүхий компанид хүргүүлэх	Засварын төв	Уурхайн үйл ажиллагаанаас гардаг хаягдал аккумуляторыг цуглуулан тээвэрлэж хуулийн шаардлагын дагуу хадгалдаг ба тусгай зөвшөөрөлтэй “Үлэмж хүдэр” ХХК-тай 2023 онд гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. 2023 онд нийт 427 ширхэг хаягдал аккумуляторыг “Үлэмж хүдэр” ХХК-д нийлүүлээд байна.	Үйл ажиллагааны зардлаас	100
8.	Аккумулятор түр хадгалах цэгийн тохижилтыг сайжруулах	Тээвэр логистикийн хэлтэс	Хүнд даацын автомашинаас гардаг хаягдал аккумуляторыг тээвэр ложистикийн хэлтэс дээр удаан хугацаанд хадгалалгүйгээр гэрээт компанид хүргүүлдэг	3,000.0	1

			зохицуулалтыг хийн ажиллаж байна. Хаягдал аккумуляторыг шаардлагад нийцүүлэн хадгалах зориулалтын савны худалдан авалтын ажил хийгдэж байна.		
9.	Хог хаягдлын үйлчилээний гэрээт компанийн тостой хаягдал шатаах зуухыг сайжруулах	Хогийн цэг	2023 онд хогийн цэгийн аюултай хог хаягдал шатаах зуух болох Turbo burner тостой хог хаягдал шатаах шинэ зуухыг ажиллуулж эхлээд байна. 2023 оны 7-р сараас эхлэн 679 м3 аюултай хог хаягдлыг шатаагаад байна.	20,000.0	1
НИЙТ ЗАРДАЛ, мян төг				33,800,0	

10.1. Хуванцар ангилан ялгалт

2023 оны 10-н сарын байдлаар хуванцар хог хаягдлыг эх үүсвэр дээр нь 267 м3 ангилан ялгаж дахиварын цех дээр хуванцар сав пресслэгч машиныг суурилуулсан бөгөөд одоогийн байдлаар 230 м3-ыг пресслэн үлдсэн 37 м3-ыг дахиварын цех дээрх хуванцар хадгалах хашаанд хадгалаад байна.



Зураг 10.1. Хуванцар савыг цуглуулж пресслэсэн байдал

10.2. Зам талбайд хийсч тарсан хог хаягдлын цэвэрлэгээ зохион байгуулах

Ухаа худаг төслийн талбайн зам талбайд хийсч тарсан хогны цэвэрлэгээг 18 удаа хийж нийт 13 м3 хогийг зайлуулсан байна. Түүнчлэн сумын засаг даргаас ирүүлсэн албан бичгийн дагуу байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2023 оны 2 дугаар албан даалгаврын хүрээнд Таван толгой-Гашуун сухайт чиглэлийн авто замын 2-8 дахь километрийн хооронд 2023 оны 08 дүгээр сарын 23-наас 24-ний өдрүүдэд хийгдсэн бүх нийтийн хог цэвэрлэгээнд манай компани дугуйт ачигчтай оролцон хуримтлагдсан хур хогийг цуглуулж овоолго үүсгэх болон ачилт хийх ажлыг гүйцэтгэлээ.

Тус цэвэрлэгээгээр нийт 46 машин буюу 1150м3 орчим хогны ачилт хийн, 50 орчим хогны овоолго хийв.



Зураг 10.2.1 Ухаа худагийн зам, ЭУС-н талбайд хог цэвэрлэгээг хийж байгаа байдал



Зураг 10.2.2 УБ-ДЗ-ЦЦ чиглэлийн авто замын дагуу талбайд хог цэвэрлэгээг хийж байгаа байдал

Цагаан хадны НАБТ-д давхардсан тоогоор 351 ажилчин 39 удаагийн хог цэвэрлэгээгээр давхардсан тоогоор 408га талбайгаас 237.2м3 хогийн зайлуулсан байна.



Зураг 10.2.3 Цагаан хадны НАБТ талбайд хог цэвэрлэгээг хийж байгаа байдал

10.3 Дахин ашиглагдах хаягдлыг хоёрдогч түүхий эд авдаг аж ахуйн нэгж байгууллагад нийлүүлэх.

Энэ онд нийт 40.6 м3 хаягдал модыг татан авсанаас 23 м3 орон нутгийн иргэдэд ахуйн хэрэглээнд, мөн 110 тонн хаягдал төмрийг хогийн цэгт хадгалж байгаа ба 15тн төмрийг орон нутгийн хаягдал төмөр хүлээн авдаг “Хүрэл эрчим” ХХК-д хүлээлгэн өгсөн байна.



Зураг 10.3.1 Хаягдал төмөр ачиж байгаа байдал



Зураг 10.3.2 Хаягдал мод ачиж байгаа байдал

10.4 Хаягдал дугуй, машин техникийн хаягдал төмөр сэлбэгийг төвлөрүүлэх

2023 оны 10 сарын 25-ны байдлаар 5400 ширхэг дугуй, 27 тэвш мод, 125 тонн төмөр төвлөрүүлсэн ба компанийн ажичид болон орон нутгийн иргэдэд тодорхой зохицуулалтын дагуу түгээжээ.



10.5 Аюултай хог хаягдлыг шаардлага хангасан нөхцөлд хадгалж, нийлүүлэгчид буцаан хүргүүлэх

Ухаа худаг төслийн хүнд машин механизмыг завсарын төвд ашигладдаг 1 тонны савалгаатай тосыг “Майнс Ап” ХХК-наас худалдан авалтыг хийдэг бөгөөд гэрээнд тусгасны дагуу ашигласан тосны саваа тус компанид буцаан нийлүүлдэг.

2023 оны 09 сарын 25- ны байдлаар 579 ширхэг аюултай хог хаягдал болох 1 тонны тосны савыг нийлүүлэгч болох “Майнс Ап” ХХК-д буцаан ачуулсан байна.



Зураг 10.5.1 Тонны савыг нийлүүлэгчид буцаахаар ачсан байгаа нь

10.6 Хаягдал тосыг цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх

Ил задгай хаягдсан тос тосолгооны материал нь хөрс болон гүний усанд бохирдол үзүүлэх сөрөг нөлөөтэй тул хаягдал тосыг зөв зохистой цуглуулж, дахин боловсруулах үйлдвэрт хүргэх нь байгаль хамгаалах чухал арга юм.

Төслийн хэмжээнд энэ онд 365 тн хаягдал тос гарсан ба засварын төвд суурилуулсан 50 тн багтаамжтай зориулалтын ёмкостонд цуглуулж, хаягдал тос дахин боловсруулдаг “Хай би ойл” ХХК-д нийлүүлдэг. 2023 онд аюултай хог хаягдлыг хүлээн авах эрх бүхий “Хай би ойл” ХХК, “Монпители ойл” ХК гэрээ байгуулж хамтарч ажиллаж байна.

Зураг 10.6.1 “Хай би Ойл” ХХК-н тусгай зөвшөөрлийн гэрчилгээ “Монпители Ойл” ХХК-н гэрээ



Зураг 10.4.2 Хаягдал тос тээврийн машин

10.7 Аюултай хог хаягдал болох аккумуляторыг эрх бүхий компанид хүргүүлэх


Уурхайн үйл ажиллагаанаас гардаг хаягдал аккумуляторыг цуглуулан тээвэрлэж хуулийн шаардлагын дагуу хадгалдаг ба тусгай зөвшөөрөлтэй “Үлэмж хүдэр” ХХК-тай 2023 онд гэрээ хийж хамтран ажиллаж байна. 2023 онд нийт 427 ширхэг хаягдал аккумуляторыг “Үлэмж хүдэр” ХХК-д нийлүүлээд байна.



Зураг 5.1 Хаягдал аккумуляторыг тээвэрлэсэн байдал ба дагалдах хуудас

10.8 Аккумулятор түр хадгалах цэгийн тохижилтыг сайжруулах


Хүнд даацын автомашинаас гардаг хаягдал аккумуляторыг тээвэр ложистикийн хэлтэс дээр удаан хугацаанд хадгалалгүйгээр гэрээт компанид хүргүүлдэг зохицуулалтыг хийн ажиллаж байна. Хаягдал аккумуляторыг шаардлагад нийцүүлэн хадгалах зориулалтын савны худалдан авалтын ажил хийгдэж байна.



Зураг 10.8.1 Хаягдал аккумуляторыг түр хадгалж байгаа, худалдан авалт хийхээр захиалагдсан байгаа зориулалтын контайнер

10.9 Хог хаягдлын үйлчилээний гэрээт компанийн тостой хаягдал шатаах зуухыг сайжруулах

Тосоор бохирдсон аюултай хог хаягдлыг шатаах зориулалтаар жижиг оврын шатаах зуух “Turbo burner”-ны худалдан авалтыг хийн тостой хаягдлыг харицангуй бүрэн шаталттайгаар устгал хийн ажиллаж байна. 2023 оны 7-р сараас хойш 10 сарын 25-ны өдрийг хүртэл нийт 679 м3 аюултай хог хаягдлыг шатаагаад байна. Хог шатаах жижиг оврын шатаагчийг ажиллуулах ажилчдын аюулгүй ажиллагааг ханган, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг бүрэн хэрэглүүлэх тал дээр хяналт тавин ажиллаж байна.



Зураг 10.9.1 Тостой хог хаягдал шатааж байгаа байдал

11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Биелэлтийн шалгуур
1	Байгаль орчны хууль, журмын хэрэгжилтийг хангах зорилгоор дотоод хяналтыг хэрэгжүүлэх	Ухаа худаг төсөл, Гэрээт компаниуд	2023 оны 1-10 сарбын байдлаар хийсэн ажлын байрны үзлэгээр нийт 227 байгаль орчны үл тохирол илэрсэн ба гүйцэтгэл нь 86.8% залруулагдсан байна.	Үйл ажиллагааны зардлаас	Нийт ажлын байрнууд дээр хуваарийн дагуу үзлэг хяналт хийж, үл тохирвол илэрвэл залруулах
2	Ус ашигласны төлбөрийг ноогдуулалтын дагуу төлж барагдуулах ажилд хяналт тавих	Ухаа худаг төсөл	Ус ашиглуулах дүгнэлтийн дагуу УХГ уурхайн үйл ажиллагаанд зарцуулсан усны төлбөрийг хуулийн дагуу улирал тутамд төлж байна.	-	-
3	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд нэмэлт тодотгол хийлгэх	Ухаа худаг төсөл	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд нэмэлт тодотгол хийлгэх ажил гэрээний шатанд явагдаж байна.	Үйл ажиллагааны зардлаас	-
4	Байгаль хамгаалах тэмдэглэлт өдрүүдэд сургалт, мэдээллийн ажил зохион байгуулах	Ухаа худаг төсөл	Байгаль хамгаалах өдөр тэмдэглэх ажлын хүрээнд тайлант онд Дэлхийн усны өдөр, Эх Дэлхийн цэвэрлэгээний өдөр болон Дэлхийн байгаль хамгаалах өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлсэн байна.	5,000.0	Дэлхийн усны өдөр Дэлхийн байгаль хамгаалах өдөр,

5	Нийт ажилтнуудад байгаль орчныг хамгаалах чиглэлээр сургалт зохион байгуулах	Ухаа худаг төсөл	Ухаа худаг уурхайд ажиллахаар шинээр ирсэн болон одоо ажиллаж байгаа үндсэн, гэрээт компанийн ажиллагсад компанийн аюулгүй ажиллагаа, байгаль орчин, галын аюулгүй байдал, анхны тусламжийн чиглэлээр нэг хүнд 11 цагийн сургалт зохион байгуулсан. 2023 онд давхардсан тоогоор 13491 хүнд 148894 хүн/цагийн сургалт зохион байгуулсан байна.	2,000.0	Байгалийн нөөцийн хэмнэлт, БО-ны хууль эрхзүйн мэдлэгийг сайжруулах, Хог хаягдал г.м
6	Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэх		Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн холбогдох шаардлагын дагуу Ухаа худаг төслийн байгаль орчны хууль эрх зүйн нийцлийн 2 жил тутмын аудитыг хийлгэх ээлжит хугацаа 2023 онд таарч байгаа бөгөөд тус ажлыг гүйцэтгүүлэхээр аудитын эрх бүхий мэргэжлийн байгууллага болох БО№АД ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна.	15,000.0	Байгаль орчны эрх зүйн нийцтэй байдлыг үнэлүүлэх


7	Байгаль орчны ажилтнуудыг чадавхижуулах сургалт болон сайн туршлага судлах үйл ажиллагааг зохион байгуулах, хурал, семинар, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох	БО хэсэг	Говь цөлийн бүсэд ус бага ашиглан ойжуулалт хийсэн туршлагатай танилцах, компанийн мод үржүүлгийн үйл ажиллагааг хүний хөдөлмөрийг хөнгөвчилж техникжүүлэх туршлага болон ногоон байгууламжийн автомат усалгааны систем нэвтрүүлэх боломжийг судлах, уурхай биологийн нөхөн сэргээлтийн аргачлалтай танилцах зорилгоор БНХАУ-н Ордос хотын Кубуки цөлийн ойжуулалтын талбайтай танилцсан. Түүнчлэн багийн гишүүд байгаль орчны сургалт, хэлэлцүүлэг, бага хуралд оролцсон байна.	3,000.0	Стандарт болон ногоон байгууламжийн чиглэлээр, Салбарын чиглэлийн аливаа үйл ажиллагаанд санаачлагатай оролцох
8	Эрчим хүчний хэмнэлтийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх	Ухаа худаг төсөл	Компанийн Уурхайн болон дэд бүтцийн төслүүдийн эрчим хүчний бүхий л хэрэгцээг хангадаг цахилгаан станц нь бөгөөд жил бүр эрчим хүчий хэмнэлтийн төлөвлөгөөг боловсруулан гүйцэтгэлийн ханган ажилладаг. 2023 онд эрчим хүчний хэмнэлтийн 9 ажил төлөвлөсөн бөгөөд 85 хувийн биелэлттэй байсан.	Үйл ажиллаганы зардлаас	Салбарын чиглэлийн аливаа үйл ажиллагаанд санаачлагатай оролцох
9	ISO14001:2015 стандартын баталгаажуулалтын аудит хийлгэх	Ухаа худаг төсөл	МонСертф олон улсын итгэмжлэгч байгууллагын аудитын баг нь Ухаа худаг уурхайд 2023 оны 2 дугаар сард хийгдсэн. Аудитын багийн дүгнэлтээр менежментийн тогтолцооны шаардлага хангасан.	10,000.0	-

10	Гэрээт компаниудад байгаль орчны чиглэлээр хяналт шалгалтыг сайжруулах	Гэрээт компаниуд	Уг ажлын хүрээнд үндсэн гэрээт компаниудад Шүүт трейд, Эрч майнинг, М-Армор, ЮСС, Паблик сервис ХХК -д сар бүр нэгдсэн үзлэгийг хийсэн.	2,000.0	Дотоод хяналт, ажлын байрны үзлэг, гүйцэтгэлийн дүгнэлт КРІ тайлан авдаг болсон. БО шалгуур үзүүлэлтийг дүгнэдэг болсон
НИЙТ ЗАРДАЛ, мян.төг				37,000.0	

11.1. Байгаль орчны дотоод хяналт

Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй нийцлийн албанаас гаргасан ажлын байрны үзлэг хийх дотоод журамын дагуу бүх алба нэгжүүдэд сар бүр хуваарь гарган нэгдсэн үзлэгийг хийдэг.

2023 оны 10 дугаар сарын 27-ны байдлаар нийт 227 байгаль орчны үл тохирол илэрсэн ба гүйцэтгэл нь 86.8% залруулагдсан. Үзлэгээр илэрсэн нийт үл тохирлын 80% -г хог хаягдал, үлдсэн 20%- тос тосолгооны материалыг буруу хадгалалт, асгаралт, хөрсний эвдрэлтэй холбоотой үл тохирлууд эзлэсэн байна.



Зураг 11.1.1 Ажлын байрны үзлэгийн тайлангууд

11.2. Ус ашигласаны төлбөр

“Энержи ресурс” ХХК-ийн “Ухаа худаг” уурхайн цогцолбор байгууламж төслийн үйл ажиллагаанд ашиглах ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усны дүгнэлт зөвшөөрлийг хуулийн дагуу авч, ус ашигласны төлбөрийг усны ашиглах дүгнэлтийн дагуу улирал тутамд төлж байна.



Зураг 11.2.1 Усны төлбөр төлсөн баримтуул

11.3 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд нэмэлт тодотгол хийлгэх

Хуулийн шаардлагын хүрээнд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд нэмэлт тодотгол хийлгэх ажлыг хийлгэхээр мэргэжлийн байгууллага болох “Эх Монголын байгаль” ХХК гэрээний шатанд явагдаж байна.

11.4. Байгаль хамгаалах тэмдэглэлт өдрүүд

Байгаль хамгаалах өдөр тэмдэг ажлын хүрээнд тайлан онд Дэлхийн усны өдөр, Эх дэлхийн цэвэрлэгээний өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлсэн байна.

Дэлхийн байгаль хамгаалах өдөр: Экологийн боловсролыг хүүхдэд бага насгаас нь олгох нь ач холбогдолтой, үр дүнтэй бөгөөд Дэлхийн байгаль хамгаалах өдрийг тохиолдуулан Цогтцэций сумын 27-р цэцэрлэгт мод тарих арга техник, арчилгааны онцлог болон цэцэрлэгийн дотоод орчинд тасалгааны цэцгийг тарих сургалт зөвлөгөөг цэцэрлэгийн багш, ажилчдад өгөв. Зарим нэр төрлийн тасалгааны цэцэг болон модны суулгац, бордооны туслалцаа дэмжлэгийг үзүүлэв.





Зураг 11.4.1 Сургалтын үеийн байдал

Дэлхийн усны өдөр: Дэлхийн усны өдрийг тохиолдуулан нийт ажилчдад “Усны зөв хэрэглээ, ашиглалт” сэдэвт сургалтыг 2023 оны 03-р сарын 22 нд зохион байгуулсан. Сургалтын үеэр ус хэмнэх энгийн аргууд, усны хомсдлын өнөөгийн нөхцөл байдлын тухай агуулгыг ажилчдад хүргэв.



Зураг 11.4.2 Сургалт зохион байгуулж байгаа байдал

Дэлхийн усны өдөр: Дэлхийн усны өдрийг тохиолдуулан Ерөнхий боловсролын 2 сургуулийн ахлах ангийн 30 сурагч, 3 башид Ухаа худаг уурхай болон усны барилга байгууламж болон гүний худгийн хянах автомат системийн үйл ажиллагааг танилцуулсан.



Зураг 11.4.3 Уурхайн болон гүний худгийн автомат телеметрийн системийн танилцуулга хийж
буй байдал

Эх дэлхийн цэвэрлэгээний өдөр: Цогтцэций сумын ерөнхий боловсролын 1-р сургуулийн 9-10 р ангийн сурагчдад хог хаягдлын менежмент 3R систем, хог хаягдлаас үүсэх орчны бохирдлоос урьдчилан сэргийлэхэд бидний оролцоо сэдвийн дор сургалтыг орж, хаягдал картон цаасыг дахин ашиглан хаягдал батарей цуглуулах савыг хамтран хийв. Сургалтаар анги бүрийн төлөөлөл болсон 25 сурагч, 1 багш хамрагдсан ба тус сумын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн Э. Отгонжаргал байлцав.



Зураг 11.4.3 Сургалт зохион байгуулж байгаа байдал

11.5 Нийт ажилтнуудад байгаль орчныг хамгаалах чиглэлээр сургалт зохион байгуулах

Ухаа худаг уурхайд ажиллахаар шинээр ирсэн болон одоо ажиллаж байгаа үндсэн, гэрээт компанийн ажиллагсад компанийн аюулгүй ажиллагаа, байгаль орчин, галын аюулгүй байдал, анхны тусламжийн чиглэлээр нэг хүнд 11 цагийн сургалт зохион байгуулсан. 2023 онд давхардсан тоогоор 13491 хүнд 148894 хүн/цагийн сургалт зохион байгуулсан байна.



Зураг 11.5.1 Сургалтанд хамрагдаж байгаа байдал

11.6 Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэх

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн холбогдох шаардлагын дагуу Ухаа худаг төслийн байгаль орчны хууль эрх зүйн нийцлийн 2 жил тутмын аудитыг хийлгэх ээлжит хугацаа 2023 онд таарч байгаа бөгөөд тус ажлыг гүйцэтгүүлэхээр аудитын эрх бүхий мэргэжлийн байгууллага болох БОАД ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна.

11.7 Байгаль орчны ажилтнуудыг чадавхижуулах сургалт болон сайн туршлага судлах үйл ажиллагааг зохион байгуулах

Жил бүр нөхөн сэргээлт мод үржүүлгийн чиглэлээр туршлага судлах үйл ажиллагааг уламжлал болгон зохион байгуулдаг бөгөөд говь цөлийн бүсэд ус бага ашиглан ойжуулалт хийсэн туршлагатай танилцах, компанийн мод үржүүлгийн үйл ажиллагааг хүний хөдөлмөрийг хөнгөвчилж техникжүүлэх туршлага болон ногоон байгууламжийн автомат усалгааны систем нэвтрүүлэх боломжийг судлах, уурхай биологийн нөхөн сэргээлтийн аргачлалтай танилцах зорилгоор БНХАУ-н Ордос хотын Кубуки цөлийн ойжуулалтын талбайтай танилцсан. Кубуки цөл нь 18600км² талбай бүхий Хятад улсын 7 дахь том цөл бөгөөд 50 жилийн дотор 1,8 тэрбум мод тарьж уг цөлийг ногоон болгох зорилготой томоохон төсөл байна. Түүнчлэн ӨМӨЗО-ны Хөх хотын мод үржүүлэг судалгааны Монгол өвс төвийн үйл ажиллагаатай танилцан компанийн удирдлагуудтай уулзаж, мэдээлэл авсан.



Зураг 11.7.1 Туршлах судлах ажлын зураг

Байгаль орчин аялал жуулчлалын яам, Уур амьсгалын өөрчлөлт, судалгаа шинжилгээний төв, Байгаль орчны судалгаа шинжилгээний төвөөс зохион байгуулсан Хариуцлагатай уул уурхай, нөхөн сэргээлт, орчны хяналт шинжилгээ сэдэвт 15 цагийн чадавхижуулах сургалтанд байгаль орчны ахлан ажилтан Г.Ган-Эрдэнэ, байгаль орчны ажилт Д. Адьяасүрэн нар оролцсон.

Тэрбум мод аяны хүрээнд Ойн газраас зохион байгуулсан “Тэрбум модны хэрэгжилт, цаашид авах арга хэмжээ” сэдэвт бүсийн чуулган, мөн Тэрбум мод аяны уул уурхайн компаниудын амлалттай холбоотой хэлэлцүүлэгт Байгаль орчны ахлах ажилтан Г. Ган-Эрдэнэ оролцсон.

Цөлжилттэй тэмцэх дэлхийн өдрийг тохиолдуулан Өмнөговь аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Оюу толгой ХХК хамтран 2023 оны 6 сард зохион байгуулсан Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг сааруулах сэдэвт бага хуралд Байгаль орчны менежер М. Мөнгөнхонх, Байгаль орчны ажилтан Д. Адьяасүрэн, Э.Уранчимэг Г. Амаржаргал нар хамрагдсан.



Зураг 11.7.2 Бага хурал болон сургалтанд хамрагдаж байгаа ажилтнууд

11.8 Эрчим хүчний хэмнэлтийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх

“Энержи Ресурс” ХХК-ний Ухаа худаг коксжих нүүрсний ордыг түшиглэн 18 МВт-ын хүчин чадалтай цахилгаан станц барьж, 2011 оны 9 сарын 24-нд ашиглалтанд оруулсан. Тус станц нь уурхайн болон дэд бүтцийн төслүүдийн эрчим хүчний бүхий л хэрэгцээг хангадаг бөгөөд жил бүр эрчим хүчий хэмнэлтийн төлөвлөгөөг боловсруулан гүйцэтгэлийн ханган ажилладаг. 2023 онд эрчим хүчний хэмнэлтийн 9 ажил төлөвлөсөн бөгөөд 85 хувийн биелэлттэй байсан.

Эрчим хүчний үнэ ХХК

М Сх 30 Интернационал ХХК-ийн Өмчлөх далай санхүү

№	Ардчилсан амжилтаар өмнө болсон ажил, тус хөдөлгөөний ажил	Сайн болсон арга хөдөлгөөний үр дүндийг хангах, амжилт	Хэрэгжүүлсэн хугацаа	Биелэлт %	2023 оны үр дүн		2022 оны үр дүн	2023 оны үр дүн	2022 оны үр дүн	Хэрэгжүүлсэн хугацаа	Хэрэгжүүлсэн хугацаа
					2023 оны үр дүн	2022 оны үр дүн					
1	Газартайгаа холбох	Цахилгаан станц, дэд станц, газартайгаа холбох ажил	2020-2021	100	208,282	+	35,181,006	Ангийн байрны гэрээтэй гэрээ	33,424,480		0.95
2	Давсгаар хөдөлгөөний үр дүндийг хангах	Давсгаар хөдөлгөөний үр дүндийг хангах ажил	2020-2023	80	-	-	-		3,527,273		
3	Давсгаар хөдөлгөөний үр дүндийг хангах	Давсгаар хөдөлгөөний үр дүндийг хангах ажил	2020-2023	80	-	-	-		3,527,273		
4	Турбидын хөдөлгөөний үр дүндийг хангах	Турбидын хөдөлгөөний үр дүндийг хангах ажил	-	-	-	-	-		-		
5	Картоны үйлдвэрийн хөдөлгөөний үр дүндийг хангах	Картоны үйлдвэрийн хөдөлгөөний үр дүндийг хангах ажил	2020-2023	80	-	-	-		4,354,545		
6	Картоны үйлдвэрийн хөдөлгөөний үр дүндийг хангах	Картоны үйлдвэрийн хөдөлгөөний үр дүндийг хангах ажил	-	-	-	-	-		-		
7	Картоны үйлдвэрийн хөдөлгөөний үр дүндийг хангах	Картоны үйлдвэрийн хөдөлгөөний үр дүндийг хангах ажил	-	-	-	-	-		-		
8	Турбидын хөдөлгөөний үр дүндийг хангах	Турбидын хөдөлгөөний үр дүндийг хангах ажил	-	-	-	-	-		-		
9	Турбидын хөдөлгөөний үр дүндийг хангах	Турбидын хөдөлгөөний үр дүндийг хангах ажил	-	-	-	-	-		-		


Тайлбар: 1. С.Түрэгт 2. Эрчим хүчний үнэ ХХК-ийн 3. 8801007 4. 8801008



Зураг 11.8.1 Эрчим хүч хэмнэх төлөвлөгөөний биелэлт, давтамж хувиргуур захиалагдан ирсэн байгаа нь

11.9 ISO14001:2015 стандартын баталгаажуулалтын аудит хийлгэх

Манай компани нь үйл ажиллагаандаа 2018 онд менежментийн нэгдсэн тогтолцооны ISO 45001, ISO 14001, ISO 9001 стандартыг нэвтрүүлсэн. Стандартын дахин баталгаажуулалтыг Францын Аfnor группын нэрийн өмнөөс МонСертф олон улсын итгэмжлэгч байгууллагын аудитын баг нь Ухаа худаг уурхайд 2023 оны 2 сард хийгдсэн. Аудитын багийн дүгнэлтээр менежментийн тогтолцооны шаардлага хангасан.



Зураг 11.9.1 Стандартын гэрчилгээ

Зураг 11.9.2 Аудитын хаалтын хурал

11.10 Гэрээт компаниудад байгаль орчны чиглэлээр хяналт шалгалтыг сайжруулах

Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй нийцлийн албанаас гаргасан ажлын байрны үзлэг хийх дотоод журамын дагуу бүх алба нэгжүүдэд сар бүр хуваарь гарган нэгдсэн үзлэгийг хийдэг. Уг ажлын хүрээнд үндсэн гэрээт компаниудад Шүүт трейд, Эрч майнинг, М-Армор, ЮСС, Паблик сервис ХХК -д сар бүр нэгдсэн үзлэгийг хийсэн. Ажлын байрны үзлэгээр илэрсэн үл тохирлыг тухай бүр арилгуулан ажилласан.

NON-STANDARD CONDITIONS / PERFORMANCE / СТАНДАРТ БҮС БОХИОЛ, ҮРЛЭЛТ							
No	Hazard Class / Аюулны ангилал	Non-compliance / Үл тохирол	Picture / Зураг	Action Required / Ааж арга хэмжээ	Responsible person / Хариуцаж буй этгээд	Targeted Date / Арга хэмжээ авч дуусгах хугацаа	Performance and date / Үйлдвэрлэл ба өгөгдөл
2	B	Шүүт ХХК-а нэгдсэн үзлэгийн газраас тодорхой болгоогдох нөхцөлд агаарын дуурааг утасны байдал		Тооцор болгоогдох агаарын дуурааг утасны байдалыг хянаж, утасны нөхцөлийг шинэчлэх		2023.10.10	
3	D	Ухаагийн үл тохирлуулал байгуулам руу явж чиглэсэн агаарын дуурааг		Харгалсан өгөгдөл нэгдсэн үзлэгийн газраас тодорхой болгоогдох нөхцөлд агаарын дуурааг утасны байдалыг хянаж, утасны нөхцөлийг шинэчлэх		2023.10.20	

Зураг 11.10.1 Гэрээт компаниудад хийгдсэн ажлын байрны үзлэгийн тайлангууд

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

12.1. Гадаргын ба газрын доорх усны хяналт шинжилгээ

№	Хяналт шинжилгээний төрөл	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Биелэлтийн шалгуур
12.1.1	Малчдын гар худгуудын усны түвшин болон эрдэсжилт, ЦДЧ, рН хэмжих	Наймантын хөндийд байрлах малчдын 12 гар худаг	Наймантын хөндийд байрлах малчдын 12 худагт 5 удаагийн хэмжилт хийж бүртгэл хөтөлсөн	3,300.0	2 сар тутамд хэмжилт хийгдсэн байх
12.1.2		Наймдайн хөндийд байрлах 8 гар худаг	Наймдайн хөндийд байрлах 8 гар худагт 5 удаагийн хэмжилт хийж бүртгэл хөтөлсөн	2,000.0	2 сар тутамд хэмжилт хийгдсэн байх
12.1.3	Ашиглалтын хяналтын цооногийн усны түвшин хэмжих	Наймантын хөндийд байрлах 12 ажиглалтын цооног	Хэмжилтийг сар бүр хийсэн	-	Сар тутамд хэмжилт хийгдсэн байх
12.1.4		Наймдайн хөндийд байрлах 12 ажиглалтын цооног	Хэмжилтийг сар бүр хийсэн	-	Сар тутамд хэмжилт хийгдсэн байх
12.1.5	Малчдын гар худгийн чанарын хяналт	Наймант болон наймдайн хөндийд байрлах 20 гар худаг	Ухаа худаг уурхайн усны шинжилгээний лабораторит 21 гар худгийн усанд химийн шинжилгээ хийлгэсэн	1,200.0	Усны ерөнхий химийн шинжилгээ хийлгэсэн байх
12.1.6	Хяналтын цооногуудын усны түвшин болон эрдэсжилт,, рН	Эргэлтийн усан сан 4, уурхайн хяналтын 3 цооног	Эргэлтийн усан сангийн хяналтын 4 цооног ба уурхайн бүсийн 3 цооногт усны түвшний болон бусад үзүүлэлтүүдийн хэмжилт хийсэн.	1,480.0	Сар тутамд хэмжилт хийсэн байх
12.1.7	Газар доорхи усны хяналтын цооногуудаас дээж авах, микро элементийн агуулгыг шинжлүүлэх	Төслийн талбайд байрлах 3 цооног, ЭУС орчмын 4 цооног	Мониторингийн 7 цооногоос усны дээж авч микро элементийн шинжилгээ хийлгэсэн.	1,700.0	Жилд 1 удаа шинжилгээ хийлгэсэн байх
НИЙТ ЗАРДАЛ, мян.төг				9,680.0	

12.1.1. Наймантын хөндийн малчдын худгуудын хэмжилт

Наймантын хөндийд байрлах малчдын 13 гар худагт 2023 оны 1-ээс 9-р сарын хооронд хоёр сард нэг удаа буюу нийт 65 удаагийн хээрийн хэмжилтийн ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Хээрийн хэмжилтээр усны түвшинг зөөврийн багаж ашиглан хэмжилт хийж, бүртгэл хөтөлсөн.



Зураг 12.1.1.1. Малчдын гар худгуудад усны хэмжилт хийж буй байдал, Ухаа худаг




График 12.1.1.1. Наймантын хөндий орчмын малчдын худгуудын усны түвшин, 2023 он

Наймантын хөндийн малчдын гар худгуудын усны түвшний 2023 оны хэмжилтийн мэдээг дээрх графикт харуулсан байна. Малчдын худгуудын усны түвшний хэлбэлзэл нь тухайн худгийн ашиглалтын байдал, усалж байгаа малын тоо толгой болон тухайн жилийн хур тунадасны хэмжээ, худгийн усны ундарга, ул хөрсний онцлог зэргээс шалтгаалдаг. Наймантын хөндийн малчдын нийт худгуудын түвшний хэмжилтийн үр дүнд улирлын ялгаа, хур тунадас болон тухайн хэмжилт хийгдсэн өдрийн мал усалсан байдлаас шалтгаалан усны түвшин хэлбэлзсэн үзүүлэлттэй байна.

Хармагтай, Хоолойн гучин, Хулгар, Батчулуун, Шинэ усны худгуудын усны түвшин харьцангуй тогтвортой байсан бол Шугамын худаг 3-р сард 6 метрээр нэмэгдсэн байсан бол 5 болон 9-р сард 6.2-оос 6.5 метрээр буурч 1-р сарын хэмжилтийн утгатай адил түвшинд хүрсэн байна. Цагаан эрэг 1-р сараас 7-р сар хүртэл усны түвшин тогтвортой байсан бол 9-р сард 0.6 метрээр буурсан дүн ажиглагдаж байна. Гучин ус худгийн усны түвшин 3-р сард 1.7 метрээр нэмэгдсэн байсан ба 5 болон 7-р сард 2 метрээр буурсан дүн ажиглагдаж байна. Бунхантын усны түвшин 1-р сараас 7-р сар хүртэл тогтвортой байсан ба 9-р сард өмнөх сараас 0.6 метрээр буурсан үзүүлэлттэй байна. Адгийн ус, Хулсан усны худгуудын усны түвшин 3-р сард буурах хандлагатай байсан бол 5-р сараас 9-р сар хүртэл усны түвшин нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Маахууз болон Хажуу усны худгуудын усны түвшин нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

12.1.2. Наймдайн хөндийн малчдын худгуудын хэмжилт

Наймдайн хөндийн орчмын малчдын худгуудад суурь мэдээллийн сан үүсгэх зорилгоор 2012 оноос хойш усны хэмжилтийг тогтмол хийж байна. Бид 2023 оны 2 сараас 10 сарын хооронд Наймдайн хөндийд байрлах малчдын 7 гар худагт нийт 35 удаагийн хээрийн хэмжилтийг хийсэн. Хээрийн хэмжилтээр усны түвшинг зөөврийн багаж ашиглан хэмжилт хийж, бүртгэл хөтөлсөн.




График 12.1.2.1. Наймдайн хөндий орчмын малчдын худгуудын усны түвшин, 2023 он

Малчдын худгуудын усны түвшний хэмжилтийн үр дүнд Наймдайн болон Долоодойн худгууд нь 2023 оны 5 удаагийн хэмжилтээр усны түвшин тогтмол буурах хандлагатай байна. Зүүн сайр болон Сүүжийн худгуудын худгуудын усны түвшин нь 2-р сараас 10-р сар хүртэл харьцангуй тогтвортой үр дүн ажиглагдаж байна. Харин Шангай худгийн усны түвшин нь жилийн туршид хэлбэлзэл ихтэй үр дүн ажиглагдаж байна. Улаан худаг усны түвшин нь 2-р сараас 8-р сар хүртэл харьцангуй тогтвортой байсан бол 10-р сард усны түвшин мэдэгдэхүйц буюу 1.5 м-ээр нэмэгдсэн үр дүн ажиглагдсан. Үүний суурь шалтгаан нь худгийн хэмжилтийг хийх үед худгийг ашигладаг малчин айл малаа услан, ундны усаа авж байсан үе таарсан болно.



Зураг 12.1.2.1. Улаан худаг малчны худгийн 10-р сарын усны түвшний хэмжилт хийх үеийн байдал

12.1.3. Ашиглалтын хяналтын цооногийн усны түвшин хэмжих

Ухаа худаг төслийн хэрэгцээний ус ашиглалтыг хянах зорилгоор Наймантын хөндийн 11 хяналтын цооногуудын усны түвшиний хэмжилтийг 2023 оны 2-р сараас 9-р сарын хооронд нийт 4 удаагийн хэмжилт хийж тэмдэглэл хөтөлсөн ба усны түвшин огцом буурсан болон нэмэгдсэн үр дүн ажиглагдахгүй байна.

Хүснэгт 12.1.3.1. *Наймантын хөндийн хяналтын цооногийн усны түвшиний хэмжилтийн дүн, 2023 он*

	2-р сар	4-р сар	7-р сар	9-р сар
DZ08EB01	77.43	76.52	77.98	76.69
DZ08EB02	49.01	48.08	50.22	48.99
DZ08EB08	<i>ГӨД Сав газрын автомат мэдрэгчтэй</i>			
DZ08EB04	46.06	45.23	46.28	44.18
DZ08EB05	<i>Бөглөрсөн</i>			
DZ09EB06	67.18	66.92	66.21	66.79
DZ09EB09	<i>ГӨД Сав газрын автомат мэдрэгчтэй</i>			
DZ09EB10	15.21	14.65	15.88	13.22
DZ09EB11	25.16	24.33	25.78	23.1
DZ09EB12	<i>Бөглөрсөн</i>			
DZ09EB15	60.62	58.14	61.24	57.17




График 12.1.3.1. *Наймантын хөндий орчмын хяналтын цооногуудын усны түвшиний хэмжилтийн дүн*

12.1.4. Наймдайн хөндийн ашиглалтын хяналтын цооногийн хэмжилт

Наймдайн хөндийн 8 хяналтын цооногуудын усны түвшиний хэмжилтийг 2023 оны 1-р сараас 10-р сарын хооронд нийт 8 удаагийн хийж тэмдэглэл хөтөлсөн.

Хүснэгт 12.1.4.1. Наймдайн хөндийн ашиглалтын цооногийн усны түвшиний хэмжилтийн дүн,
2023 он

	1-р сар	4-р сар	7-р сар	9-р сар
NK09EB14	5.5	9.11	9.16	9.05
NK10DD09	<i>Бөглөрсөн</i>			
NK12OB02	38.8	36.94	38.06	37.59
NK12OB03	23.56	24.82	25.57	25.1
NK12OB05	7.71	9.01	10.02	9.86
NK12OB07	25.5	24.56	24.78	24.67
NK12PB06	<i>Бөглөрсөн</i>			
NK12PB08	16.92	14.01	12.69	12.23




График 12.1.4.2 Наймдайн хөндий орчмын хяналтын цооногуудын усны түвшиний хэмжилтийн дүн

NK09EB14 цооногийн усны түвшин 1-р сараас 4-р хооронд 3.61 м-ээр буурч түүнээс хойш тогтворжсон үзүүлэлттэй байна. NK12OB03 болон NK12OB07 цооногуудын усны түвшин жилийн туршид хэлбэлзэл багатай үр дүн ажиглагдаж байна. NK12OB03 болон NK12OB05 цооногуудын усны түвшин 1-р сараас 7-р сарын хооронд буурах хандлагатай байсан бол 9-р сард харьцангуй тогтворжсон үзүүлэлттэй байна. NK12PB08 цооногийн усны түвшин хэмжилтийн туршид нэмэгдэх хандлагатаа ажиглагдаж байна.

12.1.5. Малчдын гар худгуудын усны чанарын хяналт

Цогтцэй сумын наймант, наймдайн хөндийн малчдын худгуудын уснаас дээж авч Ухаа худаг уурхайн дотоодын итгэмжлэгдсэн лабораторид жилд нэг удаа өгч шинжлүүлдэг.



Зураг 12.1.5.1. Малчдын худгуудаас шинжилгээнд зориулж дээж авч буй байдал

Хүснэгт 12.1.5.1. Наймдайн малчдын гар худгуудын усны чанарын хяналт, 2023 он

№	Шинжилгээний үзүүлэлтүүд	Стандарт	Зүүн сайр	Сүүж	Шангай	Наймдай	Улаан худаг
1	Өнгө, градус	20	0	0	172	175	63
2	ЦДЧ ц/см	1.0	2.5	0.7	1.2	0.96	0.45
3	Ууссан давс, мг/л	-	1255	351	598	484	226
4	Усны орчин, рН	6.5-8.5	7.68	7.58	7.68	7.67	8.33
5	Ерөнхий хатуулаг, мг-экв/л	7	10.2	2.02	2.78	2.28	0.99
6	Аммоны ион (NN4), мг/л	1.5	3.08	≤0.05	≤0.05	≤0.05	≤0.05
7	Нитритийн ион (NO2), мг/л	1	≤0.007	≤0.007	≤0.007	0.040	≤0.007
8	Фторид (F), мг/л	0.7-1.5	≤0.05	≤0.05	≤0.05	≤0.05	≤0.05
9	Нийт төмөр (Fe), мг/л	0.3	≤0.05	≤0.05	0.23	≤0.05	0.15

Наймдайн хөндий орчмын 5 худгийн усны дээжид усны ерөнхий химийн 9 үзүүлэлтийг шинжлүүлсэн. Шинжилгээний дүнгээс харахад өнгөний хувьд Улаан худаг стандартаас 3 дахин хэтэрсэн үзүүлэлттэй байсан бол бусад худаг стандартаас хэтрээгүй байна. Цахилгаан дамжуулах чанарын хувьд Зүүн сайр болон Шангай худаг стандартаас 1.2-2.5 дахин хэтэрсэн үзүүлэлттэй байна. Ерөнхий хатуулаг Зүүн сайр худаг стандартаас 3.2 мг-экв/л-ээр, аммоны ион стандартаас 1.58 мг/л-ээр хэтэрсэн үзүүлэлттэй байна. Бусад үзүүлэлтийн хувьд стандартаас давсан үзүүлэлт ажиглагдахгүй байна. Стандартаас хэтэрсэн үзүүлэлтүүд нь тухайн худгийн уст үед байрлаж буй давхаргын эрдэс

чулуулгийн найрлага болон малчдын худагт механик бохирдол их буюу битүүмжлэл хангалтгүй байгааг харуулж байна. *Лабораторийн шинжилгээний хариуг хавсралтаас харна уу.*

Хүснэгт 12.1.5.2 *Наймантын малчдын гар худгуудын усны чанарын хяналт, 2023 он*

№	Шинжилгээний үзүүлэлтүүд	Стандартууд	Батчулуун	Бунхант	Адгийн ус	Майхууз	Шинэ ус	Хажуу ус	Хулгар	Гучин ус	Хулсан	Цагаан эрэг	Хоолойн гучин	Шугам
1	Өнгө, градус	20	0.0	13	0.0	0.0	0.0	172	0.0	0.0	0.0	0.0	0.0	7.53
2	ЦДЧ ц/см	1.0	3.20	0.57	1.16	1.01	0.93	3.25	0.49	2.84	2.06	0.32	4.10	1.78
3	Ууссан давс, мг/л	-	1600	284	578	506	466	1619	247	1491	1031	160	2050	893
4	Усны орчин, рН	6.5-8.5	7.84	8.16	7.88	7.98	7.94	7.78	8.08	8.07	7.72	8.01	7.72	7.88
5	Ерөнхий хатуулаг, мг-экв/л	7	3.05	≤0.05	≤0.05	≤0.05	2.63	4.93	1.04	3.16	3.87	0.97	8.38	2.82
6	Аммоны ион (NH ₄), мг/л	1.5	0.81	0.15	1.77	0.37	0.58	0.87	0.31	0.09	0.36	≤0.05	1.49	0.10
7	Нитритийн ион (NO ₂), мг/л	1	0.009	0.121	0.211	0.003	0.007	0.005	≤0.007	0.23	0.106	0.023	0.049	≤0.007
8	Фторид (F), мг/л	0.7-1.5	≥2.0	≥2.0	≥2.0	≥2.0	≥2.0	≥2.0	≥2.0	≥2.0	≥2.0	≥2.0	≥2.0	≥2.0
9	Нийт төмөр (Fe), мг/л	0.3	≤0.05	0.13	0.05	≤0.05	≤0.05	≤0.05	≤0.05	≤0.05	0.06	≤0.05	0.06	0.09

Наймантын хөндий орчмын 12 малчдын худгийн усны дээжид усны ерөнхий химийн 9 үзүүлэлтийг шинжлүүлсэн. Шинжилгээний дүнгээс харахад өнгөний хувьд Батчулуун, Адгийн ус, Майхууз, Хажуу ус, Гучин ус, Хулсан болон Шугамын худгуудын усны цахилгаан дамжуулах чанар стандартаас хэтэрсэн үзүүлэлтэй байсан бол Адгийн усны худгийн усанд аммоны ион стандартаас 0.25 мг-экв/л-ээр хэтэрсэн үзүүлэлтэй байна. Бусад үзүүлэлтүүд стандартаас хэтрээгүй байна.

Лабораторийн шинжилгээний хариуг хавсралтаас харна уу

12.1.6. Газар доорх усны хяналтын цооногуудын хэмжилт

Нүүрс баяжуулах үйлдвэрийн дэргэдэх хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэрээс гарсан усыг эргэлтийн усан сан (ЭУС)-д төвлөрүүлж байсан ба ЭУС орчмын газар доорх усанд чанарын хяналт хийх зорилгоор 4 цооногт сард нэг удаа хэмжилт хийсэн.

Мөн уурхайн олборлолт явуулж байгаа бүсэд гүний усны хяналт хийх зорилгоор 3 цооногт хэмжилт хийсэн. Уурхайн цооногууд нь шатахуун түгээх станц, нүүрс баяжуулах үйлдвэр, цахилгаан станц орчимд байрладаг. Усны түвшинг зөөврийн багаж ашиглан хэмжилт хийж, бүртгэл хөтөлдөг.

Хүснэгт 12.1.6.1. Эргэлтийн усан сан орчмын хяналтын цооногуудын байршил

№	Цэгийн дугаар	Цэгийн байршил	Цэгийн координат
1	Цооног 2	“Түмэн заг” ХХК-ын харуулын постны зүүн талд	X 43.668286, Y 105.595272
2	Цооног 3	Эргэлтийн усан сангийн зүүн хойн	X 43.664357, Y 105.593947
3	Цооног 4	Эргэлтийн усан сангийн зүүн талд	X 43.655998, Y 105.587902
4	Цооног 5	Эргэлтийн усан сангийн зүүн урд	X 43.651612, Y 105.584215
5	Цахилгаан станц	Цахилгаан станцын баруун хойд талд	X 43.673627, Y 105.538163
6	Шатахуун түгээх станц	ШТС-ын баруун талд НАБТ тээврийн машин зогсоолын зүүн талд	X 43.657411, Y 105.539755
7	Нүүрс баяжуулах үйлдвэр	НБҮ-ийн халаалтын зуухны хойно	X 43.668777, Y 105.535016




График 12.1.6.1 Эргэлтийн усан сан орчмын хяналтын цооногуудын усны түвшин, 2023 он

Дээрх графикт ЭУС орчмын хяналтын цооногуудын усны түвшинг харуулсан байна. ЭУС –ын 4 цооногт 2023 оны 1-р сараас 10-р сарын хооронд нийт 40 удаа хэмжилт хийсэн. Дээрх хэмжилтийн үр дүнд цооног 2-ын усны түвшин 4 сар хүртэл бага зэрэг буурсан үзүүлэлттэй байсан бол 8 сараас усны түвшин нэмэгдсэн үзүүлэлттэй байна. 3 болон 4-р цооногийн усны түвшин 1-р сараас 8-р сар хүртэл усны түвшний огцом бууралт ажиглагдаагүй боловч 9 сард 1.2, 1.3м-ээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. 5-р цооногийн усны түвшин 4-р сард 1.2 м нэмэгдсэн үзүүлэлт ажиглагдаж байгаа боловч 5-р сараас буурч тогтворжсон үзүүлэлт ажиглагдаж байна.




График 12.1.6.2 Уурхайн бүс орчмын хяналтын цооногуудын усны түвшин. 2023 он

Дээрх графикт уурхайн бүс дэх хяналтын 3 цооногийн усны түвшний өөрчлөлтийг харуулсан байна. Уг хэмжилт 2022 оны 1-р сараас 10-р сар хүртэл нийт 30 удаагийн хэмжилт хийгдсэн. Хэмжилтийн үр дүнд Цахилгаан станцын цооногийн усны түвшин огцом өөрчлөлтгүй байсан бол Шатахуун түгээх станцын усны түвшин 4-р сард 1 м-ээр нэмэгдсэн үзүүлэлттэй байсан бол 5, 6-р сард буурч 7- сараас усны түвшин 1.6 м-ээр нэмэгдсэн байна. Нүүрс баяжуулах үйлдвэрийн усны түвшин 4-р сараас 8-р сар хүртэл бууралттай байсан ба 4 м-ээр буурсан байна. 9 болон 10-р сард усны түвшин 1.5 м-ээр нэмэгдсэн байна.

12.1.7. Хяналтын цооногуудын усны чанарын шинжилгээ

Эргэлтийн усан сан орчмын гүний усны хяналтын 4 цооног, Уурхай орчмын бүс буюу Нүүрс баяжуулах үйлдвэр (НБҮ), Дулаан цахилгаан станц (ДЦС), Шатахуун түгээх станц (ШТС) –ын цооноогоос дээж авч ALS LLC-ын лабораторид микро элементийн шинжилгээг хийлгүүлсэн. Шинжилгээний дүнг MNS6148:2010 “Газрын доорх усыг бохирдуулагч бодисуудын зөвшөөрөгдөх хэмжээ” стандарттай харьцуулан үр дүнг боловсруулсан. *Лабораторийн шинжилгээний хариуг хавсралтаас харна уу*

Хүснэгт 12.1.7 ЭУС болон Уурхай орчмын хяналтын цооногийн усны микро элементийн шинжилгээний дүн, 2023 он

Элементүүд	Al	As	Ba	Cd	Cr	Cu	Fe	Mn	Mo	Pb	Sb	Sr	V	Zn	Ni
MNS6148:2010	0.5	0.01	2	0.003	0.07	1	0.3	0.1	0.04	0.05	0.006	-	5	0.3	0.01
Цооног 2	0.08	<0.01	0.01	<0.01	<0.01	<0.01	0.02	<0.01	0.03	0.02	<0.04	1.22	<0.01	0.07	0.03
Цооног3	0.07	<0.01	0.02	<0.01	<0.01	<0.01	0.03	0.06	0.03	<0.02	<0.04	0.58	<0.01	0.04	0.01
Цооног 4	0.12	<0.01	0.02	<0.01	<0.01	<0.01	0.03	0.02	0.03	<0.02	<0.04	0.87	<0.01	0.1	<0.01
Цооног 5	0.17	<0.01	0.03	<0.01	<0.01	<0.01	0.07	0.01	0.02	<0.02	<0.04	2.05	<0.01	0.18	<0.01
НБҮ	0.01	0.01	0.01	<0.01	<0.01	<0.01	0.02	0.05	0.03	0.02	<0.04	0.64	<0.01	0.34	<0.01
ДЦС	0.05	0.01	0.04	<0.01	<0.01	0.01	<0.01	<0.01	0.02	<0.02	<0.04	6.31	<0.01	0.43	<0.01
ШТС	0.13	<0.01	0.02	<0.01	<0.01	<0.01	0.02	<0.01	0.01	<0.02	<0.04	1.8	0.01	0.24	<0.01

Дээрх хүснэгтэд ЭУС болон Уурхайн орчмын 7 цооногт хийсэн усны микро элементийн шинжилгээний үр дүнг харуулсан байна. Шинжилгээний үр дүнг MNS 6148:2010 Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарттай харьцуулахад цайр НБҮ, ДЦС-ын цооног дээр 0.13 болон 0.04 мг/л хэтэрсэн үзүүлэлт ажиглагдаж байна. Бусад үзүүлэлтүүд дээр хэтэрсэн үзүүлэлт ажиглагдахгүй байна.

12.2. Агаарын чанарын хяналт шинжилгээ

№	Хяналт шинжилгээний төрөл	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Биелэлтийн шалгуур
1	Тоосжилтын нөлөөллийг хянах зорилгоор агаарт агуулагдах нарийн ширхэгт тоосонцорыг хэмжих	Ухаа худаг уурхай, Цогтцэций сум, Цагаан хад НАБТ-ын 12 цэг	Цогтцэций сум болон уурхай орчим 9 цэг сар бүр, Цагаан хад орчмын 2 цэгт улирал бүр хэмжилтийг хийж гүйцэтгэсэн.	11,400.0	Сар тутамд хэмжилт хийгдсэн байх Улирал тутамд хэмжилт хийсэн байх
2	Тоосжилтын нөлөөллийг хянах зорилгоор агаарт агуулагдах тоосонцорыг хэмжих	Ухаа худаг уурхай	Уурхайн орчимд өдөр тутам тоосонцорыг хэмжсэн.	4,300.0	Хэмжилт хийгдсэн байх
3	Ухаа Худаг уурхай болон ЦХ НАБТ орчмын гадаад орчны агаарын чанарын \ NO ₂ , SO ₂ , хэмжилт хийх	Ухаа худаг уурхай, ЦС, Цэвэрлэх байгууламж, Хогийн цэг, Цагаан хад НАБТ, Ажилчдын хотхон	Дотоодын итгэмжлэгдсэн багажаар хэмжилтийг 5 цэг дээр хийж гүйцэтгэсэн	1,600.0	Хөндлөнгийн хяналт хийлгэсэн байх
4	Зуухны газруудын утааны найрлага хэмжилт	Галлерей кемп, Цэций хороолол, НБҮ-ийн халааттын зуух	3 зууханд хагас жилд нэг удаа хэмжилт хийх	2,000.0	Хэмжилт хийгдсэн байх
	Цахилгаан станцын утааны найрлага хэмжилт	Ухаа худаг уурхай	Цахилгаан станцын яндангийн утааны найрлагыг тодорхойлох 4 удаагийн хэмжилтийг хийсэн.	2,000.0	Хэмжилт хийгдсэн байх
НИЙТ ЗАРДАЛ, мян.төг				19,900.0	

12.2.1. Гадаад орчны тоосны концентрацийн хэмжилт

Ухаа Худаг төслийн агаарт агуулагдах тоосны концентрацийн хяналт шинжилгээний ажлын хүрээнд Ухаа Худаг уурхай, Цогтцэций сум, Эргэлтийн усан сан зэрэг газруудад 2023 оны 1-р сараас 10-р сарын хугацаанд сар бүр тогтмол хийж гүйцэтгэсэн. Тоосны хэмжилтийг Dust Trak TSI 8530 болон 8533 загварын агаар дахь аэрозолийн хэмжээг тодорхойлдог багажаар хэмжсэн ба хэмжилтээр PM2.5 буюу нарийн ширхэгтэй тоосонцрыг 24 цаг хүртэлх хугацааны дундаж агууламжаар тодорхойлсон (Зураг 12.2.2.1). Хэмжилтийн үр дүнг MNS 4585:2016 “Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага” Монгол улсын стандарттай харьцуулан дүгнэлт гаргаж шаардлагатай арга хэмжээг авч ажилласан.



Зураг 12.2.1.1. Гадаад орчны тоосонцрын хэмжилт, Ухаа худаг

Хүснэгт 12.2.1.1. Уурхайн орчмын сар тутмын тоосны хэмжилтийн үр дүн, 2023

Цэгүүдийн байршил	1-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар
Сумын төв	0.036	0.094	0.036	0.041	0.041	0.042	0.010	0.024	0.046
Сумын баруун урд	0.014	0.026	0.07	0.05	0.01	0.01	0.010	0.031	0.019
Ундны ус цэнгэгжүүлэх байгууламж	0.006	0.031	0.056	0.045	0.007	0.021	0.011	0.02	0.023
Уурхайн зүүн урд	0.051	0.024	0.047	0.03	0.03	0.063	0.010	0.015	0.055
Уурхайн урд	0.032	0.068	0.026	0.037	0.016	0.085	0.014	0.009	0.011
Ойн зурвас	0.005	0.019	0.015	0.019	0.023	0.019	0.029	0.005	0.019
Уурхайн төв	0.032	0.041	0.048	0.036	0.03	0.014	0.033	0.033	0.054
Уурхайн зүүн хойно	0.058	0.039	0.046	0.054	0.004	0.035	0.029	0.004	0.029
Эргэлтийн усан сан	0.016	0.028	0.023	0.025	0.035	0.041	0.016	0.006	0.036
НБҮ дэргэд (Лаборатори)	0.044	0.033	0.099	0.02	0.045	0.061	0.013	0.054	0.065




График 12.2.1.1. Ухаа худаг уурхай, Цогтцэций сум орчмын нарийн ширхэглэгт тоосны концентрацийн хэмжилтийн үр дүн (мг/м3), 2023 он

Дээрх графикаас харахад PM 2.5 нарийн ширхэглэгт тоосонцрын хэмжилтийн үр дүнд хогийн цэг дээр 1 болон 4-р сард 0.008 мг/м3, 0.04 мг/м3-ээр хэтэрсэн, сумын төв, 212-р пост ойр орчимд 2 сард агаарын чанарын стандартаас 0.018 мг/м3-0.044 мг/м3-ээр хэтэрсэн үзүүлэлттэй байсан бол Галлерей кемп, Ундны усны байгууламж, Лабораторийн ойр орчимд 3-р сард агаарын чанарын стандартаас 0.02 мг/м3-ээс 0.04 мг/м3-ээр хэтэрсэн үзүүлэлттэй байна. 212-р пост, майга усан сан болон лабораторийн орчим 7-р сард 0.011 мг/м3- 0.035 мг/м3-ээр хэтэрсэн үзүүлэлттэй байсан. Лабораторийн орчимд 9 болон 10-р сард агаарын чанарын стандартаас 0.004 мг/м3 – 0.015 мг/м3-ээр хэтэрсэн үзүүлэлттэй байна мөн сургалт болон майга усан сан дээр 10-р сард 0.004 мг/м3 0.005 мг/м3-ээр хэтэрсэн үзүүлэлт ажиглагдаж байна.

12.2.2. Гадаад орчны тоосны концентрацын өдөр тутмын хэмжилт

Ухаа Худаг төслийн хамрах хүрээнд тоосжилтын хяналт хийх зорилгоор 2023 оны 1-р сарын 1-ээс эхлэн сургалтын төв дээр байрлуулан 9-р сарын 21-н хүртэл өдөр бүр тоосны концентрацийн хэмжилтийг хийсэн. Тоосны хэмжилтээр PM2.5 буюу нарийн ширхэгтэй тоосонцрыг 1 минутын дундаж агууламжийг 24 цагт 4 минутын зайтайгаар 288 удаагийн давтамжтай тодорхойлсон. Хэмжилтийн үр дүнг MNS 4585:2016 “Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага” Монгол улсын стандарттай харьцуулан дүгнэлт гаргасан.




График 12.2.2.1 Ухаа худаг уурхай орчмын нарийн ширхэгт тоосонцорын өдөр тутмын
концентрацийн хэмжилтийн үр дүн, 2023 он

Дээрх графикаас харахад PM2.5 тоосонцор 1-ээс 3 сар хүртэл нийт 18 удаа агаарт агуулагдах нарийн ширхэглэгт тоосонцорын агууламжын хэмжээ стандартаас давсан байсан бол 4 болон 5-р сард хэтэрсэн үзүүлэлт ажиглагдаагүй. 6-р сараас 9-р сар хүртэл нийт 13 удаа агаарын чанарын стандартаас хэтэрсэн үзүүлэлттэй байна.

Тоосны концентрацийн утга стандартаас өндөр гарсан тохиолдлууд нь хүйтний улиралд агаарын инверсийн үзэгдэл үүсч тоос үүссэн орчиндоо тогтож хуримтлагддаг, уурхайн зам усалгаа аюулгүй байдлын шалтгаанаар хязгаарлагддаг, зэрэг шалтгаантай холбоотой байж болох бол хаврын улиралд салхины хүч нэмэгдэж, шороон шуургатай өдрүүдийн тоо нэмэгддэг, агаарын чийг багасч хуурай үе тохиолддог нь үндсэн суурь нөхцөл болох талтай. Компанийн зүгээс үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор эргэлтийн усан санг технологийн нөхөн сэргээлт хийж байгаа ба уурхайн олборлолтын хэсгийн технологийн зам дээр дулааны улиралд тогтмол усалгаа хийсэн, тоосжилт бага үүсгэдэг улаан материал дэвссэн. Мөн хүйтний улиралд уурхайн олборлолтын технологийн замаас үүсэх тоосжилтыг бууруулах тал дээр анхаарал хандуулж ажиллаж байна⁵

Цагаан хадны тоосны концентрацийн хэмжилтийн дүн

Цагаан хадны нүүрс ачиж буулгах талбайн тагаарт агуулагдах тоосны концентрацийн хяналт шинжилгээний ажлын хүрээнд кемп, НАБТ болон ойролцоох харьцуулах цэгт 2023 оны 1, 4, 7 болон 10-р сард хэмжилтийг хийж гүйцэтгэсэн.




График 12.2.2.2 Цагаан хад орчмын нарийн ширхэгт тоосонцорын концентрацийн хэмжилтийн үр дүн, 2023 он

Дээрх графикаас харахад РМ 2.5 нарийн ширхэглэгт тоосонцрын хэмжилтийн утга цагаан хад НАБТ дээр 2, 7 сард 0.011-0.034 мг/м³-ээр хэтэрсэн үзүүлэлттэй байсан бол 9-р сард цагаан хад кемп болон харьцуулах цэг дээр 0.02 мг/м³-ээр агаарын чанарын стандартаас хэтэрсэн үзүүлэлттэй байна.

12.2.3. Гадаад орчны агаарын чанарын хяналт шинжилгээ

Гадаад орчны агаарын чанарын хяналт шинжилгээний хүрээнд бохирдуулагч хий болох азотын давхар исэл, хүхрийн давхар исэл, нүүрсхүчлийн хий, хүхэрт устөрөгчийг хэмжилтийг дотоодын хөдөлмөрийн эрүүл ахуйн gas tester II H in polybutel багажаар NO₂, SO₂, CO₂ тубэ, хүхэрт ус төрөгчийг Drager X-am 5000 багаж ашиглан хийсэн. Агаарын чанарын хэмжилтийн уурхай орчмын 6 цэгт хийсэн болно.



Зураг 12.2.3.1 Гадаад орчны агаарын чанарын хэмжилт

Хүснэгт 12.2.3.1. Агаарын шинжилгээний дүн, мкг/м³

Цэгийн нэр үзүүлэлт	Агаарын чанарын MNS4585:2016 стандарт	Цагаан хад НАБТ	Цэвэрлэх байгууламж	Ухаа худаг уурхай	Шатахуун түгээх станц	Цахилга ан станц	Хогийн цэг
Хүхэрлэг хий SO ₂ , мкг/м ³	450 мкг/м ³	<20 мкг/м ³	<20 мкг/м ³	<20 мкг/м ³	663.01 мкг/м ³	<20 мкг/м ³	31.28 мкг/м ³
Азотын давхар исэл мкг/м ³	200 мкг/м ³	54.25 мкг/м ³	56.34 мкг/м ³	66.62 мкг/м ³	50.7 мкг/м ³	52.24 мкг/м ³	67.15 мкг/м ³
Нүүрсхүчлийн хий CO ₂	1800 мг/м ³	Илрээгүй					
Хүхэрт устөрөгч	-	Илрээгүй					

Дээрх дүнгүүдээс харахад азотын давхар исэл, хүхрийн давхар ислийн хэмжилтийн дүнг агаарын чанарын MNS4585:2016 стандарттай харьцуулахад шатахуун түгээх станц дээр хүхэрлэг хий (SO₂) 213.01 мкг/м³-ээр хэтэрсэн үзүүлэлттэй байсан бол бусад хэсэгт стандартаас давсан үзүүлэлт ажиглагдахгүй байна. Дизель түлш нь их эсвэл бага хэмжээгээр хүхрийн нэгдлүүдийг агуулдаг бөгөөд дизель түлш шатах үеийн хүхрийн давхар исэл (SO₂) ялгаруулалт, дизель түлшний зөөвөрлөлт хийх үеийн болон ШТС нь хажууд байрлах НАБТ-н нүүрсний дотоод шаталтын уугилт гэх дараах 3 суурь шалтгаанаас үүдэн хэмжилт хийх үеийн үзүүлэлт өндөр гарсан байх магадлалтай юм.

12.2.4. Цахилгаан станц болон халаалтын зуухнуудын утааны найрлагын хэмжилтийн тайлан

Цахилгаан станцын зуухны утааны бохирдуулагч хийн хэмжилтийг 2023 оны 10 сарын 22-нд цахилгаан станцын 1, 2 болон 3-р зуух, НБҮ, Цэций хороолол болон Галлерей кемпийн халаалтын зуухан дээр "Термокалор"ХХК-ний эрчим хүчний зөвлөх инженертэй хамтран хийж гүйцэтгэв. Хэмжилтийг Testo 340 XL загварын багажаар CO, NOx, SO2 үзүүлэлтүүдийг хэмжсэн.



Зураг 12.2.4.1 Хэмжилт хийж буй байдал



Зураг 12.2.4.2 Хэмжилт хийсэн зуух



Зураг 12.2.4.3 Хэмжилтийн үр дүн

Бохирдуулагч хийн хяналтаар агаарыг бохирдуулагч гол гурван хий болох нүүрс хүчлийн дутуу исэл CO, азотын исэл NOx, хүхрийн исэл SO2 зэргийн утгыг нормал агаарын түвшинд шилжүүлэн Монгол улсын MNS 5919:2008 стандарттай харьцуулан гаргадаг. Цахилгаан станцын гурван зуух 2023 онд бүрэн хүчин чадлаараа ажилласан.

Хүснэгт 12.2.7.1. Цахилгаан станцын зуухнуудын азотын давхар исэл болон нүүрстөрөгчийн дутуу ислийн хэмжилтийн дүн, 2023

Огноо	Зуух 1			Зуух 2			Зуух 3		
	CO мг/м3	NOx мг/м3	SO2 мг/м3	CO мг/м3	NOx мг/м3	SO2 мг/м3	CO мг/м3	NOx мг/м3	SO2 мг/м3
Стандарт	3320	1500	1740	3320	1500	1740	3320	1500	1740
Хэмжилтийн утга	760.45	134.64	2843.16	1706.17	224.51	3688.99	290.57	318.84	3779.16

Хэмжитийн үр дүнд нүүрс хүчлийн дутуу исэл болон азотын исэл стандарт утгаас хэтэрсэн үзүүлэлт ажиглагдаагүй. Хүхрийн давхар ислийн агууламж зуух 1 дээр стандарт утгаас 1103 мг/м3, зуух 2 дээр стандарт утгаас 1949 мг/м3, зуух 3 дээр стандарт утгаас 2039 мг/м3-ээр хэтэрсэн үзүүлэлт ажиглагдаж байна.

Хүснэгт 12.2.7.2. Ухаа худаг уурхай болон сумын халаалтын уурын зуухнуудын азотын давхар исэл, нүүрс төрөгчийн дутуу ислийн хэмжилтийн үр дүн, 2023

Огноо	Нүүрс баяжуулах үйлдвэр			Цэций хороолол			Галлерей кемп		
	CO мг/м3	NOx мг/м3	SO ₂ мг/м3	CO мг/м3	NOx мг/м3	SO ₂ мг/м3	CO мг/м3	NOx мг/м3	SO ₂ мг/м3
Стандарт	3320	1500	1740	3320	1500	1740	3320	1500	1740
Хэмжилтийн утга	491.89	1283.32	3857.36	2174.58	1138.96	6448.97	389.62	205.68	3143.69

Нүүрс баяжуулах үйлдвэр, Цэций хороолол болон Галлерей кемпийн халаалтын зуухнууд дээр хийсэн хэмжилтийн үр дүнд CO, NOx стандарт утгаас хэтрээгүй байсан ба хүхрийн давхар исэл SO₂ НБҮ-ийн халаалтын зууханд стандарт утгаас 2227 мг/м3, Цэций хороололлын халаалтын зуух 4819 мг/м3, Галлерей кемпийн халаалтын зуух 1514 мг/м3-ээр хэтэрсэн үзүүлэлттэй байна.

12.3 Хөрсний судалгаа

№	Хяналт шинжилгээний төрөл	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Тоо хэмжээ
1	Хөрсний агрохимийн шинжилгээ	Шимт хөрсний овоолгууд	Ухаа худаг уурхай орчмын 9 шимт хөрсийн овоолго ба ойн зурвасаас хөрсний дээж авч “Инженер геодези ХХК”-д шинжилгээ хийлгэсэн.	700.0	10 цэг
2	Ухаа Худаг уурхай болон Цагаан хад НАБТ-н дэд бүтцийн барилга байгууламж орчмын хөрснөөс микро элементийн дээж авч шинжлүүлэх	Засварын төвүүд, ШТС, Хогийн цэг, ЦХ НАБТ орчим болон хогийн цэг, Гэрээт олборлогч компаний засварын төв	Уурхай орчмын хөрсний бохирдлын мониторингийн 7 цэг, ЦХ орчмын 3 цэгээс хөрсний микро элементийн шинжилгээнд дээж авч итгэмжлэгдсэн лабораторит шинжилгээ хийлгэсэн.	1,220.0	10 цэг
НИЙТ ЗАРДАЛ, мян.төг				1,920.0	

12.3.1. Хөрсний агрохимийн шинжилгээ

Ухаа худаг уурхайн шимт хөрсний овоолгын 9 цэгээс дээж авч хөрсний агрохимийн шинжилгээг “Инженер геодези ХХК”-д хийлгэсэн. Дээрх цэгүүдээс авсан дээжийн задлан шинжилгээний үр дүнг харьцуулах цэг буюу ойн зурвасын гадна талбайгаас авсан хөрсний агрохимийн шинжилгээний үр дүнтэй харьцуулан (Хүснэгт 12.3.1.1)-д үзүүлэв. *Лабораторийн шинжилгээний хариуг доорх хавсралтаас ханра уу*

Хүснэгт 12.3.1.1. Хөрсний химийн задлан шинжилгээний дүн, Ухаа худаг

Дээжний нэр		Шимт хөрс 2011	Шимт хөрс 2012	Шимт хөрс 2013	Шимт хөрс 2014	Шимт хөрс 2016	Шимт хөрс 2017	Шимт хөрс 2018	Шимт хөрс 2022	Ойн зурвас гадна талбай (Харьцуулах цэг)
рН		9.61	10.3	9.62	9.4	9.2	8.89	8.74	8.97	8.70
ЦДЧ dsm		1.105	0.370	0.908	0.419	1.672	0.224	0.178	0.331	0.210
Давс %		0.51	0.14	0.42	0.19	0.78	0.10	0.08	0.15	0.09
Ялзмаг %		0.41	0.36	0.44	0.51	0.72	0.46	0.36	0.42	0.51
CaCO ₂ %		1.15	1.15	1.32	1.65	1.32	0.99	1.81	1.32	0.16
Шингээгдсэн сууриул, мг-экв/100 гр	Ca	8.4	6.7	9.4	8.5	7.1	9.3	8.5	10.4	7.7
	Mg	6.5	2.5	5.1	3.5	5.2	2.6	6.6	3.0	1.1
Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	P ₂ O ₅	0.9	0.9	1.8	1.6	2.2	1.2	2.3	1.7	1.9
	K ₂ O	5	19	21	18	39	31	15	15	51

Хөрсний агрохимийн шинжилгээний үр дүнг харьцуулах цэг буюу ойн зурвасын гадна талбайн цэгээс авсан дээжийн шинжилгээний үр дүнтэй харьцуулан үзэхэд хүчил, шүлтийн харьцаа бага зэрэг өндөр буюу 2012 оны хөрсний овоолго нь хамгийн их буюу 1.6 их гарсан байсан бол цахилгаан дамжуулах чадвар нь 2011 болон 2013 онд 2 дахин өндөр байсан бол бусад шимт хөрсний овоолго харьцангуй зөрүү багатай байна. Хөрсний ялзмагийн хувьд 2016 оны шимт хөрсний овоолго 0.2 хувиар их байсан бол 2014 оны шимт хөрсний овоолго ялзмагийн хувьд зөрүүгүй байсан бол бусад шимт хөрсний овоолгийн хувьд харьцангуй бага байна. CaCO₂ хувьд шимт хөрсний овоолгууд ойн зурвасын хөрснөөс 0.83-1.65 хувиар их байна. Шингээгдсэн сууриуд буюу Кальци болон Магни нь харьцуулах цэгээс бага зэрэг их боловч шим тэжээлийн элементүүд буюу P₂O₅ болон K₂O нь харьцуулах цэгээс хэтэрсэн үзүүлэлт ажиглагдахгүй байна.

12.3.1.2. Хөрсний механик (ширхэгийн) бүрэлдэхүүн

Дээжний нэр		Шимт хөрс 2011	Шимт хөрс 2012	Шимт хөрс 2013	Шимт хөрс 2014	Шимт хөрс 2016	Шимт хөрс 2017	Шимт хөрс 2018	Шимт хөрс 2022	Ойн зурвас гадна талбай
Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, Мм	1-0.25	19.5	28.9	24.3	18.6	35.9	22.9	26.0	23.4	14.5
	0.25-0.05	53.1	52.2	45.0	56.5	39.1	54.5	48.3	53.6	66.9
	0.05-0.01	4.8	3.4	12.6	11.2	8.5	12.1	11.4	9.5	4.3
	0.01-0.005	8.3	4.4	4.2	0.9	4.0	2.6	0.3	2.5	5.0
	0.005-0.001	5.6	3.4	11.1	6.8	4.6	6.8	9.9	9.9	8.4
	<0.001	8.69	7.7	2.7	6.1	7.9	1.1	4.1	1.1	1.0
	<0.01	22.5	15.6	18.0	13.7	16.5	10.5	14.3	13.5	14.3




График 12.3.1 хөрсний механик бүрэлдэхүүн, 2023 он

Хөрсний механик бүрэлдэхүүн нь 2 мм-ээс жижиг ширхэгтэй элс, тоос, шавар гэсэн хатуу хэсгүүдийн харьцаагаар илэрхийлэгдэх бөгөөд эдгээрээс аль фракц нь зонхилж байгаагаас хамаарч тухайн хөрсний механик бүрэлдэхүүний нэршил хамаардаг. Элсний ширхгийн хэмжээ 2-0.05мм, тоосных 0.05-0.002мм, шаварных <0.002мм тус тус байдаг (“Guidelines for soil description”. 2006). Судалгааны үр дүнгээс харахад хөрсөн дэх элсэн фракцын утгийн хэлбэлзэл буюу 1-0.05 мм-д 59.3% - 71.2% байсан. Тоосны фракцын утгийн хэлбэлзэл буюу 0.05-0.01 мм-ийн хооронд 3.4% - 12.6% байна. Шаврын фракцын утгийн хэлбэлзэл буюу 0.01-0.001 мм-ийн хооронд 7.7% - 15.3% байсан. Дээрх графикийн үзүүлэлтээс харахад хөрсний механик бүрэлдэхүүний ихэнх хувийг элсэн фракц 1-0.05 мм эзэлж байгааг харуулж байгаа ба харин тоос болон шаварлаг бүтэц нь харьцангуй бага байгааг харуулж байна.

12.3.2. Хөрсний микро элементийн шинжилгээ

Орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд уурхай орчмын хөрсний бохирдлын мониторингийн 10 цэгээс, цагаан хадны ормын 3 цэгээс хөрсний микроэлементийн шинжилгээнд дээж авч ALS MINERALS итгэмжлэгдсэн лабораторит шинжилгээ хийлгэсэн.



Зураг 12.3.2.1. Хөрсний микроэлементийн шинжилгээний дээж авч буй байдал

Хүснэгт 12.3.2.1 Хөрсний микроэлементийн шинжилгээний дүн, 2023 он

№	Байршил	Pb	Cd	Hg	As	Cr	Sr	V	Cu	Ni	Co	Zn	B
MNS 5850:2019		20	1.5	1	4	100	700	130	80	100	40	150	25
1	Тээвэр, ложистик засвар	9	<0.5	<1	8	20	31	38	20	18	8	41	<10
2	Уурхайн засвар	18	<0.5	1	15	20	149	44	27	15	8	71	10
3	Нүүрс баяжуулах үйлдвэр	8	<0.5	<1	11	17	132	42	22	18	8	50	10
4	Дулаан цахилгаан станц	8	<0.5	<1	8	19	149	41	26	16	8	43	10
5	Шатахуун түгээх станц	20	<0.5	<1	18	16	169	50	22	16	7	55	10
6	Хогийн цэг	9	<0.5	<1	11	21	101	45	24	16	7	42	<10
7	Насос станц	9	<0.5	1	10	22	78	41	25	18	9	50	10
8	Уурхай цэвэрлэх байгууламж	8	<0.5	<1	10	19	49	45	23	16	7	42	<10
9	Сумын цэвэрлэх байгууламж	12	<0.5	1	10	24	44	46	28	20	9	59	10
10	Ойн зурвас	8	<0.5	<1	9	22	38	40	19	19	7	42	<10
№	Байршил	Pb	Cd	Hg	As	Cr	Sr	V	Cu	Ni	Co	Zn	B
10	Цагаан хад ковш засвар	9	3.19	1	10	68	99	66	60	60	19	70	10
11	Цагаан хад засварын төв	9	3.25	<1	11	68	88	59	61	62	20	70	10
12	Цагаан хад хяналтын цэг	13	<0.5	<1	11	39	219	58	18	23	8	49	<10

Шинжилгээний дүнгээс харахад хүнцэлээс бусад элементийн агууламж MNS5850:2019 Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандартад заагдсан хэмжээнд байна. Харин хүнцэлийн (As) агууламж нь дээрх бүх цэгүүд дээр стандартад заагдсан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 1.7-3.5 дахин өндөр агууламжтай гарсан байна. Энэ нь тухайн бүс нутгийн газрын гадаргын эрдэс чулуулгийн бүтэц найрлагын онцлогтой холбогдон тайлбарлагдах бөгөөд энэ талаар хийсэн эрдэмтдийн судалгаа шинжилгээний бүтээл цөөнгүй байдаг. Хүнцэлийн агууламж бүс нутгийн хөрсний найрлаганд өндөр үзүүлэлттэй болохыг бид төслийн үйл ажиллагаа явуулж эхлэхээс өмнөх үеэс эхлэн жил бүрийн судалгаагаар давхар тодорхойлж байгаа болно

12.4 Ургамал, амьтны аймгийн судалгаа

№	Хяналт шинжилгээний төрөл	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Тоо хэмжээ
1	Ухаа Худаг уурхай орчим болон дэд бүтцийн барилга байгууламж, ус олборлолтын талбай орчмын ургамлан бүрхэвчийн судалгаа хийх	-Наймантын хөндий -Нисэх буудал -Хулсан ус худаг -Шинэ ус худаг -Эргэлтийн усан сан -Цагаан хад кемп -Цагаан хад НАБТ	Бид мониторингийн бичиглэл хийж ургамалжилтын доройтлын түвшнийг илэрхийлэх, нөхөн сэргээсэн талбайд үнэлэлт өгөх зорилгоор ургамлын бүлгэмдэл үүсгэлт, зонхилох зүйл, ургамлын тусгагийн бүрхэц, нэг цэгт бүртгэгдэх зүйлийн тоо, зүйлийн бүрэлдэхүүний амьдралын хэлбэрийн онцлог, доройтлыг илэрхийлэгч зүйлүүдийн эзлэх хувь зэргийг тодорхойлох зорилт тавин ажилласан	3,000.0	7 цэг
2	Амьтаны судалгаа хийх	Наймдайн хөндий	Зэрлэг амьтны судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн.	10,000.0	1 цэг
3	Уст цэг дээр автомат камераар ажиглалт явуулах	Цагаан хад	Цагаан хадны амьтдад зориулсан уст цэг дээр камер байрлуулж ажиглалт хийсэн.	2,000.0	1 цэг
НИЙТ ЗАРДАЛ, мян.төг			15,000.0		

12.4.1 Ургамлын бүрхэвчийн судалгаа

Бид мониторингийн бичиглэл хийж ургамалжилтын доройтлын түвшнийг илэрхийлэх, нөхөн сэргээсэн талбайд үнэлэлт өгөх зорилгоор ургамлын бүлгэмдэл үүсгэлт, зонхилох зүйл, ургамлын тусгагийн бүрхэц, нэг цэгт бүртгэгдэх зүйлийн тоо, зүйлийн бүрэлдэхүүний амьдралын хэлбэрийн онцлог, доройтлыг илэрхийлэгч зүйлүүдийн эзлэх хувь зэргийг тодорхойлох зорилт тавин ажилласан.

Ургамлын хээрийн судалгааг хийхдээ ажлын даалгаварт тусгасны дагуу 10 цэгт геоботаникийн бичиглэл хийлээ. Үүнд:

1. Ухаа худаг уурхай орчим болон Таван толгой нисэх буудал -8 цэг
2. Ойн зурвасын хашааны гадан талд болон дотор -2 цэг

12.4.1.1. Ухаа худаг уурхай орчмын ургамалжилт

Ухаа худаг уурхай орчимд ургамалжилтын мониторингийн 5 цэгт бичиглэл хийж боловсруулахад Турьхан цэцэгт зурман сүүлт, Ахар навчит баглуурт, Харлаг үмхий өвст, Амманы сэдэргэнэт гэсэн 4 бүлгэмдэлд ялгарсан.


Хүснэгт 12. Ухаа худаг уурхай орчмын ургамлын нөмрөгт бүлгэмдэл үүсгэлт, зүйлийн бүрэлдэхүүн

Ухаа худаг уурхай			Наймдүйн хөндий	Нисэх буудал	Хулсангийн ус худаг	Шинэ усны худаг	Хаагдлын далан
Бичиглэлийн код			UHGSF01	UHGSF02	UHGSF03	UHGSF04	UHGSF05
Өндөршил (м)			1328.6	1388	1411.9		1453
Өргөрөг (N)			43.851820	43.770310	43.729920	43.670330	43.65951
Уртраг (E)			105.490500	105.576890	105.541950	105.456560	105.59049
Өвслөг ташингын (H) бүрхэц (%)			25	30	50	25	25
Зонхилоч зүйл (H)			<i>P. tenuiflora</i>	<i>A. brevifolia</i>	<i>P. nigellastrum</i>	<i>P. nigellastrum</i>	<i>C. ammannii</i>
Зүйлийн тоо			6	5	4	5	4
Зүйлийн шинжлэх ухааны нэр	Зүйлийн монгол нэр						
<i>Puccinellia tenuiflora</i> (Griseb.) Scribn. & Merr.	Турьхан цэцэгт зурман сүүл	H	2a				
<i>Anabasis brevifolia</i> C.A.Mey	Ахар навчит баглуур	H		2b		1	
<i>Peganum nigellastrum</i> Bunge	Харлаг үмхий өвс	H			2b	2b	2a
<i>Convolvulus ammannii</i> Desr.	Амманы сэдэргэнэ	H	+				2b
<i>Chenopodium glaucum</i> L.	Хөх ногоон лууль	T			2a		
<i>Allium mongolicum</i> Regel	Монгол сонгино, хөмөл	G	+	2m			+
<i>Halogeton glomeratus</i> (M.Bieb.) Ledeb.	Баг хуш хамхаг	T				+	
<i>Stipa glareosa</i> P.A.Smirn.	Сайрын хялгана	H	+	2m		2m	1
<i>Artemisia xerophytica</i> Krasch.	Хуурайсаг шарилж	H	1				
<i>Zygophyllum xanthoxylum</i> (Bunge) Maxim.	Шар хотир, Нохой шээрэн	P	+				
<i>Dontostemon crassifolius</i> (Bunge ex Turcz.) Maxim.	Зузаан навчит багдай	H		1			
<i>Eragrostis minor</i> Host	Бага хургалж	T		1	1		
<i>Salsola tragus</i> L.	Өргөст бударгана	T			1	+	

12.4.1.2. Ойн зурвасын ургамалжилт, түүний онцлог

Ойн зурвасын хашааны дотор талд 15 овогт хамаарах 29 төрлийн 37 зүйл байгалийн ургамал бүртгэсэн. Ойн зурвасын талбайн хашааны дотор тал, гадна хэсгүүдийг зүйлийн бүрэлдэхүүнээр нь төсөөтэйн байдлыг коэффициентоор илэрхийлбэл гадна талбайн зүйлийн бүрдэл доторх зүйлийн бүрдэлтэй 0.32 буюу 32% төсөөтэй байна.

Төсөөтэйн коэффициент



Зураг 1. Ургамлын төсөөтэй байдал



Зураг 19. Ойн зурвасын хашааны гадна болон дотор талыг харьцуулсан байдал

Энэ орчимд нийт давхардаагүй тоогоор 40 зүйл ургамал бүртгэснээс хашааны дотор талд 37 зүйл, хашааны гадна 16 зүйл, хашааны гадна болон дотор талд 13 зүйл давхацсан бол 24 зүйл нь зөвхөн хашааны дотор, 3 зүйл нь хашааны гадна талд тохиолдсон байна.

12.4.1.3 Техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай

Нөхөн сэргээлтийн талбай нь биологийн ба техникийн нөхөн сэргээлт хийгдсэн 2 ялгаатай. Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайд:

1. Нутгийн ургамал тариалан биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай
2. Биологийн нөхөн сэргээлтэд түгээмэл ашигладаг ургамлаар нөхөн сэргээлт хийсэн талбай гэсэн 2 ялгаатай талбайд мониторингийн бичиглэл хийж ургамалжилтын байдлыг тодорхойлов.

Нутгийн ургамлаар 2020 онд нөхөн сэргээсэн талбайн ургамлын тусгагийн бүрхэц 30%, нийт 5 зүйл бүртгэгдсэн. Энэ талбайд тариалсан Коржинскийн харгана-ыг эс тооцвол бүгд нэг наст, терофит зүйлүүд бүртгэгдсэн. Эдгээр зүйлүүд нь хагалсан газар, хөндөгдсөн талбайд түрүүлж ургадаг, хөрс сайжруулдаг анхдагч зүйлүүд юм. Хөрс эдгэрч байгалийн өнгөн хөрс үүсэн бүрэлдэхэд байгалийн зүйлүүд түрэн ургадаг жамтай. Тиймээс энэ талбай нөхөн сэргэх чадвартай гэж дүгнэж байна. Нөхөн сэргээлтэд тариалдаг ургамлаар нөхөн сэргээлт хийсэн талбайн өвслөг ташингад Баг хуш хамхаг (*Halogeton glomeratus*) зүйл давамгайлсан, ургамлын тусгагийн бүрхэц 10%, ердөө нэг наст, терофит 2 зүйл бүртгэгдсэн. Энэ талбайд ургамалжилтад хөрс сайжруулах үүрэгтэй оролцдог анхдагч зүйлүүд ургаж эхэлж байна гэж үзэж байна. Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд хараахан тариалалт хийгдээгүй байгаа ба байгалийн жамаар хөл газрын анхдагч зүйлүүд болох 5 зүйл ургамал ургасан байсан. Ургамлын тусгагийн бүрхэц 10% илэрсэн. Энэ талбайд дээрхтэй мөн адил ургамалжилтад хөрс сайжруулах үүрэгтэй оролцдог анхдагч зүйлүүд ургаж эхэлж байна гэж үзэж байна.

12.4.1.4. Дүгнэлт

- Ухаа худаг уурхай орчимд Турьхан цэцэгт зурман сүүлт, Ахар навчит баглуурт, Харлаг үмхий өвст, Амманы сэдэргэнэт гэсэн 4 бүлгэмдэлд 13 зүйл ургамал бүртгэгдсэн. Ухаа худаг уурхай орчимд ургамлын тусгагийн бүрхэц маш бага (дундаж 30%), зүйлийн бүрдлийн тоо цөөн (дундаж 4-5 зүйл), тэдгээрийн дотор терофитүүд тодорхой хувийг эзэлж, мөн доройтлыг

- илэрхийлэгч зүйлүүд илэрч бүлгэмдэлд давамгайлсан тархалттай бүртгэгдсэн нь уурхай орчмын ургамлын нөмрөг ихээхэн доройтолтой болохыг илтгэж байна.
- Харин Ойн зурвас орчимд ургамлын зүйлийн бүрдэл, тэдгээрийн амьдралын хэлбэрийг талбайн хашааны дотор ба гадна талд харьцуулахад талбайн дотор талд (37) зүйлийн бүрдэл илэрсэн. Гадна талбайн ургамлын бүрэлдэхүүнийг дотор талын зүйлийн бүрэлдэхүүнтэй 32% төсөөтэй үзүүлэлт гарсан. Энэ нь хашаа татаж хамгаалсан, усалгааны систем ашиглаж байгаатай холбоотой юм.
 - Уурхайн нөхөн сэргээлтэд түгээмэл ашиглаж буй зүйлээр биологийн нөхөн сэргээлтийг хийсэн талбайд (2021) зорилготойгоор тариалсан зүйлүүдээс огт ургасан зүйл ажиглагдаагүй, харин хөл газрын хөрс сайжруулагч анхлан ургадаг зүйлүүд ургасан байгаа нь тариалалтад агротехнологийн алдаа гарсан, эсвэл тариалалтын хугацаанд салхи ихтэй байдаг нутгийн цаг уурын онцлогийг харгалзан салхины хамгаалалт хийх нь үр дүнд хүрэх магадлалтай. Хэрвээ агротехнологийн алдаа гараагүй гэж үзвэл бол нутгийн ургамал тариалах нь биологийн нөхөн сэргээлтэд илүү үр дүнтэй болно гэж дүгнэхээр байна.
 - Нутгийн ургамлаар (2020) нөхөн сэргээсэн талбайд тарималжуулсан зүйлүүд сайн ургасан, тухайн орчинд дасан зохицож физиологийн үйл ажиллагаа сайн явагдаж байгаа (шар хотир зүйл үрлэж жимсэлсэн байдлаас харж болно), тарималжуулснаас гадна байгалийн олон наст ургамлын зүйлүүд ургасан, нэг метр квадрат талбайд бүртгэгдсэн зүйл бусад талбайтай харьцуулахад олон зүйл бүртгэгдсэн зэрэг үр дүнгүүдээс үзвэл байгалийн буюу нутгийн ургамлаар нөхөн сэргээлт хийх нь илүү үр дүнтэй байна гэж дүгнэж байна.

12.4.2. Амьтан аймгийн судалгаа

Цогтцэций сумын баруун хойно байрлах Таван толгойн нисэх буудлын орчим жижиг хөхтөн амьтан болон шувуудын нарийвчилсан судалгаа, Ойн зурвас орчим шувуудын төрөл зүйлийн бүрдэл, тоо толгойг тогтоох судалгаа, Наймдайн хөндий орчимд жижиг хөхтөн амьтны судалгааг тус тус арга зүйн дагуу хийж гүйцэтгэсэн.

- Таван толгойн нисэх буудлын орчимд 3 зүйл жижиг хөхтөн (шар чичүүл, сибирь алаг даага, савагдаахай) бүртгэгдсэн. Ингэхэд 10 м² талбайд 3-5 нүхтэй талбай 23 га, 6-8 нүхтэй 80 га, 9-10 нүхтэй 56 га, 11-13 нүхтэй 45 га, 14-с дээш нүхтэй талбайн хэмжээ 77 га байсан бөгөөд нийт 281 га талбайд шар чичүүл тархсан байна. Нэг нүхнээс дунджаар 8-10 амьтан идэвхтэй гарч буй нь ажиглагдсан.
- Шувуудын судалгааг арга зүйн дагуу 3 харууц цэгийг сонгосноос гадна шугаман замналын дагуу явж бүртгэл хөтөлсөн. Таван толгой нисэх буудал орчмын шувуудын төрөл зүйлийн судалгааг өмнөх оныхтой (18 зүйлийн 853 бодгаль) харьцуулж дүгнэхэд зүйлийн олон янз байдал нэмэгдсэн хэдий ч бодгалийн тоо эрс буурсан (2023 онд 21 зүйлийн 200 орчим бодгаль) дүнтэй байна. Эдгээр зүйлүүдийн нарийвчилсан судалгааны (шувуудын өдрийн идэвхжил, биеийн хэмжээ, нислэгийн өндөр, хурд, чиглэл зэрэг) үр дүнг тайланд дэлгэрэнгүй тусгалаа.
- Ойн зурваст бүртгэгдээд буй 47 зүйл шувуудыг экологийн статус буюу оршин амьдрах хэлбэрээр нь авч үзвэл 31 зүйл буюу 65 хувь нь нүүдлийн буюу хагас нүүдлийн, 15 зүйл буюу 35 хувь нь суурин тохиолдох зүйл байна. Дэлхийн байгаль хамгаалах холбооны шалгуур үнэлгээгээр (IUCN) Олон улсын хэмжээнд “Ховордож болзошгүй” гэж үнэлэгдсэн нөмрөг тас байгаа бол бусад 46 зүйл нь бүс нутгийн болоод олон улсын хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” буюу тоо толгойн хувьд тогтвортой, түгээмэл тохиолдох зүйлүүд байгааг илэрхийлж байна.
- Наймдайн хөндийд 2022 онд хийсэн жижиг хөхтөн амьтны судалгаагаар 2 зүйлийн 22 бодгалийг ажиглах буюу барьж байсан бол энэ жил 4 зүйлийн 32 амьтан барих буюу бүртгэсэн нь (2022 онд 0.9, 2023 онд 0.8) зүйлийн олон янз байдлын индекс 0.1 баллаар өндөр байгааг илтгэнэ. Гэсэн хэдий ч наймдайн хөндийн зүйлийн баялаг ядмаг хэвээр байна.




(a)

(b)

(c)

Зураг 12.4.2.1 Судалгааны талбай (a. Таван толгой нисэх буудал, b. Ойн зурвас, c. Наймдайн хөндий)



Зураг 12.4.2.2 Ойн зурвас орчимд хийгдсэн судалгааны үр дүн (Борлог хөмрөг, Буулгат хүүрзгэнэ, Шилийн сар)





Зураг 12.4.2.3. Таван толгойн нисэх буудал орчимд шинээр бүртгэгдсэн 6 зүйл шувууд



Зураг 12.4.2.4 Наймдайн хөндий орчмын жижиг хөхтөн амьтдын судалгаа

12.4.3. Цагаан хад орчмын уст цэг дээр автомат камераар ажиглалт явуулах

Цагаан хадны баруун урд байрлах зэрлэг амьтдад зориулсан уст цэг дээр 2019 оноос хойш зэрлэг амьтан ажиглалтын автомат камер байрлуулж амьтны ажиглалт хийж байна. 2023 оны 09 сарын 10-аас 10 сарын 10 хүртэл 30 хоногийн хугацаанд байрлуулсан ба ажиглалтын хугацаанд үнэг болон шилийн сар бүртгэгдсэн байна.



Зураг 12.4.3.1. Цагаан хадны уст цэг дээр байрлуулсан амьтаны ажиглалтын камераар авсан зураг

13. ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах үйл ажиллагаа	Тайлан мэдээлэл хүлээн авах тал	Гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Хугацааны тов
13.1	Худаг ашиглагч нарт хэмжилт хийх тухай бүрт худгийн хэмжилтийн мэдээллийг танилцуулах	Цогтцэций сумын иргэд	Энэ жилийн нутгийн иргэдийг мониторингид оролцуулах ажлыг 9 сарын 13 өдөр зохион байгуулж 6 иргэнийг хамруулсан болно.	3,000.0	4 сарын 20, 8 сарын 20
13.2	Компанийн нээлттэй өдөрлөгийг зохион байгуулах	Орон нутгийн иргэд	2023 онд хийгдээгүй бөгөөд 2024 онд хийгдэхээр төлөвлөгдсөн байгаа	Үйл ажиллагааны зардлаас	11-р сарын1
13.3	Төслийн үйл ажиллагаанд ашигласан химийн бодисын ашиглалт зарцуулалтын тайлан	Цогтцэций сумын ЗДТГ БОАЖЯам	2023 оны химийн бодисын зарцуулалтын тайланг хуулийн хугацаанд төрийн захиргааны төв байгууллагад хүргэхээр төлөвлөж байна.	400.0	Жилд 1 удаа
13.4	Аюултай хог хаягдлын мэдээ	Цогтцэций сумын засаг даргын тамгын газар	Ухаа худаг уурхайн аюултай хог хаягдлын жилийн эцсийн тайланг Хог хаягдал улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэхийн журамд заагдсаны дагуу тайланг хуулийн хугацаанд төрийн захиргааны төв байгууллагад хүргэхээр төлөвлөж байна.	400.0	Жилд 1 удаа
13.5	Гадаад орчны тоосны концентрацийн хэмжилтийн үр дүн	Компанийн ажилтнууд	Гадаад орчны агаарын тоосжилтын мэдээг уурхайн нийт ажилтнуудад танилцуулах байдлаар сар бүр МНТ-ны самбар дээр байрлуулсан.	1,200.0	Сар бүрийн 5-ны өдөр
13.6	Компанийн байгаль орчны ажлын гүйцэтгэл	Олон нийт, сонирхогч талууд	Энержи Ресурс ХХК нь 2023 онд Фэйсбүүк хуудсаараа дамжуулан төслийн хүрээнд байгаль орчны холбогдолтой 18 пост, 1 бичлэг оруулан 3 төсөл хөтөлбөр, аяныг зарлаж хэрэгжүүлсэн байна.	800.0	Улирал бүр
НИЙТ ЗАРДАЛ, мян.төг			5,800.0		

13.1. Худаг ашиглагч нарт хэмжилт хийх тухай бүрт худгийн хэмжилтийн мэдээллийг танилцуулах

Ухаа худаг уурхайн Байгаль орчны хэсэг болон Орон нутгийн харилцааны нэгжүүд хамтран байгаль орчны хээрийн хэмжилтийн ажилд иргэдийг оролцуулж хэмжилтийн бодитой мэдээллийг иргэдэд олгох зорилгоор уг ажлыг жил бүр зохион байгуулдаг. Энэ жилийн нутгийн иргэдийг мониторингид оролцуулах ажлыг 9-р сарын 13 өдөр зохион байгуулж 6 иргэнийг хамруулсан болно.

- Ухаа худаг уурхайн усны хэмжилтийг “Хүрэм тойром”, “Наймдай”, “Баруун Хирс” малчны гар худгууд дээр очиж усны түвшин болон бусад физик- химийн үзүүлэлтүүдийг сар бүр хэрхэн хэмждэгийг бодитоор үзүүлж танилцуулсан. Хэмжилтээр Хүрэм тойром худгийн усны түвшин 36.7 м, усны эрдэсжилтийн хэмжээ 1000 мг/л, рН буюу усны орчин 9.0, Наймдай худгийн түвшин 7.15 м, усны эрдэсжилтийн түвшин 500 мг/л, рН буюу усны орчин 8.6, Баруун хирс худгийн усны түвшин 0.98 м, усны эрдэсжилтийн хэмжээ 573 мг/л, рН буюу усны түвшин 8.6-тай тус тус үр дүнгүүд гарсан. Дээрх үзүүлэлтүүдийг усны хэмжилтийн зөөврийн багажны тусламжтайгаар хийж холбогдох үр дүнг оролцогчдод танилцуулсан. Хэмжилтээс үзэхэд гар худгуудын усны дээжинд усан орчин болон эрдэсжилтийг тодорхойлоход усан орчин нь ундны усны MNS 900:2018 стандартын түвшинд байсан.



Зураг 13.1.1 Мониторингийн хэмжилтийг малчдад танилцуулж байгаа байдал

13.3. Төслийн үйл ажиллагаанд ашигласан химийн бодисын ашиглалт зарцуулалтын тайлан


2023 оны химийн бодисын зарцуулалтын тайланг хуулийн хугацаанд төрийн захиргааны төв байгууллагад хүргэхээр төлөвлөж байна.

13.4. Аюултай хог хаягдлын мэдээ

Ухаа худаг уурхайн аюултай хог хаягдлын жилийн эцсийн тайланг Хог хаягдал улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэхийн журамд заагдсаны дагуу тайланг хуулийн хугацаанд төрийн захиргааны төв байгууллагад хүргэхээр төлөвлөж байна.

13.5. Гадаад орчны тоосны концентрацын хэмжилтийн үр дүнгийн тайлан, мэдээ

Ухаа худаг уурхай орчмын гадаад орчны тоосны концентрацийн хэмжилтийн үр дүнг нийт ажилтнуудад нээлттэй байдлаар тайлагнах журмаар БОМТ-ны самбар дээр сар бүр байрлуулах ажил хийгдсэн байгаа. Дээрх ажлын хүрээнд сар бүрийн тоосны хэмжилтийн үр дүнгээс гадна Наймдайн болон Наймантын хөндийн малчдын гар худгуудын усны түвшний хэмжилтийн мэдээллийг хамт байрлуулсан.



Зураг 13.5.1 Гадаад орчны тоосонцрын мэдээлэл болон танин мэдэхүйн мэдээллийн хамт НМТ-ний мэдээллийн самбар дээр байрлуулсан байдал

13.6. Компанийн байгаль орчны ажлын гүйцэтгэл

Энержи Ресурс ХХК нь олон нийтийн сүлжээнд “Энержи Ресурс – Хөгжлийн Төлөө” Фэйсбүүк хуудсаараа дамжуулан “Ухаа Худаг” төслийн хүрээнд байгаль орчны холбогдолтой хэрэгжиж буй ажлууд болон мэдээллийг олон нийт болон сонирхогч талуудад 2012 оноос хойш мэдээлэллэж байна. 2023 оны 1 сарын 1-нээс 10 сарын 29-ны өдрийн байдлаар нийт 18 пост, 1 бичлэг оруулан 3 төсөл хөтөлбөр, аяныг зарлаж хэрэгжүүлсэн байна.

Энержи Ресурс ХХК-аас санаачлан зохион байгуулсан төсөл, хөтөлбөр, аянаас дурдвал:

- “Бяцхан Экологичид” төсөл
- “Цалинтай Оюутан – Амралтаараа ажилла” хөтөлбөр
- “Ойжуулъя, арчилъя, хамгаалъя” аян





Зураг 13.6.1 Фэйсбүүк хуудсаар дамжуулан нийтэлсэн зураг болон постон мэдээлэл

14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗАРДАЛ

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төлөвлөсөн зардал 321,460.000 төгрөг бөгөөд түүний барьцаа болох 162,000,000 төгрөгийг Төрийн сангийн тусгай дансанд Энержи Ресурс компаниас байгаль орчин хамгаалах төлөвлөгөөний барьцаа болгон байршуулсан.

№	Хийгдэх ажлын чиглэл	Хийгдсэн ажлын тодорхойлолт	Зарцуулалт, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	Уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	31,000.00
		Нүүрс баяжуулах үйлдвэрийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	14,100.00
		Цахилгаан станцын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	12,000.00
		Нүүрс ачиж буулгах талбайн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	3,000.00
2	Нөхөн сэргээлт	Шимт хөрсөөр хучсан талбайг ургамалжуулах, усалгаа арчилгаа хийх	60,000.00
		Ургамалжуулсан талбайг усалж арчлах, нөхөн тарилт хийх	15,000.00
3	Дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаа	Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний хүрээнд орхигдсон эвдэрсэн газрыг нөхөн сэргээх	52,000.00
4	Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор	Нөлөөллийн бүсийн малчид болон сумдын иргэдэд өвс тэжээлийн дэмжлэг үзүүлэх	ОНХ-н зардлаас
5	Түүх соёлын өвийг хамгаалах	Ажил төлөвлөгдөөгүй	0.0
6	Осол эрсдэлийн менежмент	Химийн бодисын хадгалалт ашиглалтаас үүсэх эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сургалт	13,800.00
7	Хог хаягдлын менежмент	Хог хаягдлын ангилан ялгалтын нэр төрлийг нэмэгдүүлэх, хог хаягдал түр хадгалах цэгийг сайжруулах,	33,800.00
8	Удирдлага зохион байгуулалт	Байгаль орчны менежмент тогтолцооны аудит, Байгаль орчны ажлын байрны үзлэг, сургалт	37,000.00
9	Орчны хяналт шинжилгээ	Усны хяналт шинжилгээ	9,740.00
		Агаарын чанарын хяналт шинжилгээ	19,900.00
		Хөрсний хяналт шинжилгээ	1,920.0
		Ургамлан бүрхэвч ба амьтны аймгийн судалгаа	12,400.00
10	Олон нийтэд тайлагнах	Мониторингийн ажилд олон нийтийг оролцуулах, төрийн байгууллагад мэдээ тайлан хүргүүлэх	5,800.00
НИЙТ ЗАРДАЛ, мян.төг			321,460